

БОГД БАНК ХК

(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31

БОГД БАНК ХК

АГУУЛГА

ХУУДАС

БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	1
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	2
ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН	3 – 6
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	7
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	8
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	9
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	10 – 12
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	13 – 76

БОГД БАНК ХК
БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

Лувсанвандангийн Болдхуяг
Ганбаатарын Саруул
Жамбалсүрэнгийн Нарантуяа
Эрдэнийн Бямбажав
Дэмчигжавын Моломжамц
Рожер Томас Мойес
Жан Торстэн Дазер
Эллиот Рован Аукланд
Базарсадын Ойгонжаргал

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Ренчинхорлоогийн Нямцэрэн

АЛБАН ХАЯГ:

Бодь цамхаг,
1-р хороо, Жигжиджавын гудамж 3,
Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар 15160,
Монгол Улс

АУДИТОРУУД:

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

БОГД БАНК ХК

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

Богд Банк ХК-ийн (цаашид “Банк” гэх) Гүйцэтгэх захирал Ганбаатарын Саруул болон Санхүү хариуцсан захирал Моломжамцийн Бат-Өлзий бид энэхүү санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

Ганбаатарын Саруул
Гүйцэтгэх захирал



Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 15

Моломжамцийн Бат-Өлзий
Санхүү хариуцсан захирал

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Богд Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Богд Банк ХК (“Банк”)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэисэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын онцгойлсон асуудал

Аудитын онцгойлсон асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын онцгойлсон асуудал нэг бүрийг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв.

Дүгнэлтийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.

Аудитын онцгойлсон асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
<p>Зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралт</p> <p>Удирдлага нь хорогдуулсан өртгөөр бүртгэдэг харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаанд үнэ цэнийн бууралтыг тооцоходоо үнэлэмж болон өндөр түвшний төсөөлөл ашиглан тооцоолдог.</p> <p>Хорогдуулсан өртгөөр бүртгэдэг харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны нийт хөрөнгийн 42 хувийг эзэлж байгаа бөгөөд холбогдох тооцооллын тодорхойгүй байдлаас үүдэн эдгээр харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг бид аудитын онцгойлсон асуудал гэж үзсэн.</p> <p>Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйг таамагласан Зээлийн Үнэ Цэнийн Хүлээгдэж буй Алдагдал (“ЗҮЦХА”)-ын загварт суурилсан. Энэхүү загвар нь ихээхэн төсөөлөл, болон тооцоолол шаарддаг. Үүнд:</p>	<p>Бидний аудитын горимд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг ЗҮЦХА-ын загвараар тооцоолоход Банкны ашигласан аргачлал, өгөгдөл, төсөөллүүдийг үнэлэх ажил багтсан.</p> <p>Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын сан тооцоолох аргачлалыг үнэлэхдээ бид Банкны ЗҮЦХА-ын загвар, холбогдох төсөөлөл, түүний үндэслэлийн талаар дэлгэрэнгүй ойлголт авч, загварын зохистой байдлыг үнэлсэн. Мөн чанаргүйдэлд өртөх дүнг 3 шатлалд ангилсан үндэслэл, ЧМ, АХЧ, ЧӨД түүнчлэн загварт ашигласан ирээдүйг таамагласан макро эдийн засгийн хувьсагчдыг зөв зохистой тодорхойлсон эсэхийг тус тус үнэлсэн.</p>

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЖЛЭЛ)

Богд Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Аудитын онцгойлсон асуудал (үргэлжлэл)

Аудитын онцгойлсон асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн хөрөнгийн шатлал; • ЗҮЦХА-ын загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Чанаргүйдлийн Магадал (“ЧМ”) болон Алдагалд Хүргэх Чанаргүйдэл (“АХЧ”) сонгох; • Олгохоор батлагдсан зээлээс зээлд хөрвөх магадлалыг оруулан Зээлийн Чанаргүйдэл Өртөх Дүн (“ЧӨД”)–г тодорхойлох; • Макро эдийн засгийн төсөөллүүд, эдийн засгийн өгөгдлүүд болон ЗҮЦХА-ын тооцоололд орох өгөгдлүүдийн нөлөөлөл хоорондын уялдаа, хамаарлыг тодорхойлох; • ЗҮЦХА-ын загварын өгөгдлүүдийг тодорхойлох ирээдүйн макро эдийн засгийн төсөөллүүд, тэдгээрийн жинэлсэн магадлалыг сонгох; <p>Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол тооцоолууд болон үнэлэмжүүдийг санхүүгийн тайлангийн Тодруулга 2-т толилуулсан.</p> <p>Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа мөн тэдгээртэй холбогдох зээлийн эрсдэлийн удирдлагын тодруулгуудыг санхүүгийн тайлангийн Тодруулга 2, 9, 17 болон 30.2-т тус тус толилуулсан.</p>	<p>Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид хугацаа хэтэрсэн зээлийн мэдээлэл, боломжтой тохиолдолд зээл олгох үеийн болон тайлагналын өдрийн зээлдэгчийн эрсдэлийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээллүүдийг шалгасан.</p> <p>Бид насжилтын тайлангийн бүрэн бүтэн байдлыг санхүүгийн бүртгэлтэй тулгаж шалгасан ба насжилтын тайлангийн хангалттай байдлыг түүврийн аргаар сонгогдсон зээлүүдийн мэдээллийг холбогдох баримтуудтай тулгаж шалгасан.</p> <p>Мөн бид ЗҮЦХА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Банкны боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний горимд дараах ажлууд багтсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Түүхэн ЧМ, АХЧ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод өгөгдлүүдийг үнэн зөв эсэхийг сонгогдсон зээлүүд дээр гадаад болон дотоод эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; • Олон хувилбарт шинжилгээнд ашигласан макро эдийн засгийн хэмжүүрүүдийг гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; • ЧӨД-ийн иж бүрэн эсэх болон олгохоор батлагдсан зээлээс зээлд хөрвөх магадлалын үнэн зөв байдлыг сонгогдсон зээлүүд дээр холбогдох зээлийн гэрээ, хүүний тооцоолол мөн түүхэн мэдээлэлтэй тулгасан. <p>Бид ЗҮЦХА-ын загварын гол өгөгдлүүдэд хэрэглэсэн үнэлэмжийн тууштай байдлыг авч үзсэн.</p> <p>Бид санхүүгийн тайланд холбогдох тодруулгуудыг хангалттай, зохистой толилуулсан эсэхийг мөн үнэлсэн.</p>

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Компанийн Захирлууд болон Гүйцэтгэх удирдлагууд бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт аудитын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж буй жилийн тайланд тусгагдах санхүүгийн тайлангууд болон тэдгээрт хамаарах аудиторын тайлангаас бусад мэдээлэл (“Бусад хэсэг”) багтана.

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Хэрэв бид аудитын тайлангийн өдрөөс өмнө олж авсан бусад мэдээлэлд хийсэн өөрсдийн ажилд үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэл агуулсан байна гэж дүгнэвэл энэ тухайгаа тайлагнах шаардлагатай. Үүний дагуу тайлагнах зүйл бидэнд байхгүй болно.

Жилийн тайлангийн “Бусад хэсэг”-ийг унших үед тэнд материаллаг буруу илэрхийлэл байна гэж дүгнэвэл уг асуудлын талаар бид засаглал хариуцсан этгээдэд мэдэгдэх шаардлагатай байдаг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Богд Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх

Бид аудитын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, аудитын явцад илэрсэн томоохон дутагдал болон дотоод хяналттай холбоотой аливаа томоохон доголдол зэргийг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.



EY

Building a better
working world

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

Богд Банк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан

Доржбатын Мандахбаяр
Партнер

Баталсан

Адриан Чу
Партнер

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 15

Богд Банк ХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тод.	2022 мян.төг	2021 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	4	45,611,503	26,708,425
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(16,258,468)	(11,170,933)
Хүүний цэвэр орлого		29,353,035	15,537,492
Хураамж ба шимтгэлийн орлого	6	2,121,638	1,337,388
Хураамж ба шимтгэлийн зардал	6	(602,073)	(493,389)
Шимтгэл ба хураамжийн цэвэр орлого		1,519,565	843,999
Арилжааны цэвэр орлого	7	2,044,326	4,289,583
Үйл ажиллагааны бусад орлого	8	1,220,937	2,281,200
Нийт үйл ажиллагааны орлого		34,137,863	22,952,274
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	9	(517,855)	(498,168)
Үйл ажиллагааны цэвэр орлого		33,620,008	22,454,106
Үйл ажиллагааны зардал	10	(12,393,928)	(9,970,149)
Татварын өмнөх ашиг		21,226,080	12,483,957
Орлогын албан татварын зардал	11	(2,169,603)	(1,702,975)
Тайлант жилийн ашиг		19,056,477	10,780,982
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал) (татварын дараах):			
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):			
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өрийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт</i>	28	(5,030,295)	(461,933)
<i>Ашиг алдагдлын тайлан руу дахин ангилагдах өрийн хэрэглүүрийн олз/гарз</i>	28	2,502,234	(129,760)
Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:			
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг өмчийн хэрэглүүрийн дахин үнэлгээний өөрчлөлт</i>	28	(500,000)	–
Бусад дэлгэрэнгүй орлого/(алдагдал)		(3,028,061)	(591,693)
Тайлант жилийн татварын дараах нийт дэлгэрэнгүй орлого		16,028,416	10,189,289
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төг):			
Нэгж хувьцаанд ногдох суурь болон хорогдуулсан ашиг		15.2	10.6

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

Богд Банк ХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
Санхүүгийн байдлын тайлан

	Тод.	2022.12.31 мян.төг	2021.12.31 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба Монголбанкинд байршуулсан мөнгө	13	127,975,910	106,311,464
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	51,241,913	26,421,661
Санхүүгийн хөрөнгө оруулалт	15	69,625,463	36,669,786
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	16	433,677	–
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	17	208,605,193	147,910,917
Бусад хөрөнгө	18	11,143,051	4,919,677
Борлуулах зорилготой хөрөнгө	19	1,468,263	1,034,300
Үндсэн хөрөнгө	20	4,197,543	2,893,119
Ашиглах эрхтэй хөрөнгө	21	2,760,642	2,845,683
Биет бус хөрөнгө	22	931,856	855,851
НИЙТ ХӨРӨНГӨ		478,383,511	329,862,458
ӨР ТӨЛБӨР			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	23	43,347,904	24,793,633
Репо хэлцэл	24	65,471,192	49,712,396
Харилцагчдын харилцах, хадгаламж	25	217,242,434	137,114,273
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	16	62,118	–
Зээлээр авсан эх үүсвэр	26	27,137,624	8,212,568
Бусад өр төлбөр	27	4,333,099	4,328,126
Түрээсийн өр төлбөр	21	2,955,777	2,994,860
Орлогын татварын өр төлбөр	11.2	1,213,285	909,940
НИЙТ ӨР ТӨЛБӨР		361,763,433	228,065,796
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Хувьцаат капитал	28	98,556,822	80,306,822
Бусад нөөц сан	28	(1,579,154)	928,997
Хурмтлагдсан ашиг		19,642,410	20,560,843
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		116,620,078	101,796,662
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		478,383,511	329,862,458

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

Богд Банк ХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Хувьцаат капитал мян. төг (Тод.28)	Бусад нөөц сан мян. төг (Тод.28)	Хуримтлагд- сан ашиг мян. төг (Тод.28)	Нийт өөрийн хөрөнгө мян. төг
2022 оны 1-р сарын 1-ний өдрөөр	80,306,822	928,997	20,560,843	101,796,662
Тайлант жилийн ашиг	–	–	19,056,477	19,056,477
Бусад дэлгэрэнгүй орлого	–	(3,028,061)	–	(3,028,061)
Зохицуулагч байгууллагын журмын сан	–	519,910	(519,910)	–
Мөнгөн ногдол ашиг	–	–	(1,205,000)	(1,205,000)
Хувьцаагаарх ногдол ашиг	18,250,000	–	(18,250,000)	–
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр	98,556,822	(1,579,154)	19,642,410	116,620,078
2021 оны 1-р сарын 1-ний өдрөөр	50,000,000	1,041,191	10,259,360	61,300,551
Тайлант жилийн ашиг	–	–	10,780,982	10,780,982
Бусад дэлгэрэнгүй орлого	–	(591,693)	–	(591,693)
Зохицуулагч байгууллагын журмын сан	–	479,499	(479,499)	–
Нийтэд санал болгон нэмж гаргасан энгийн хувьцаа	31,750,000	–	–	31,750,000
Хувьцаа нэмж гаргахтай холбоотой шууд зардал	(1,443,178)	–	–	(1,443,178)
2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр	80,306,822	928,997	20,560,843	101,796,662

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Богд Банк ХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Мөнгөн гүйлгээний тайлан

	Тод.	2022 мян.төг	2021 мян.төг
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		21,226,080	12,483,957
<i>Мөнгөн бус тохируулгууд:</i>			
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт борлуулсны олз	7	(9,775)	(4,047,554)
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт борлуулсны олз	7	(410,963)	41,825
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт	8	450,586	(533,247)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээний олз	8	(414,007)	–
Түрээсийн өр төлбөрийн үнийн хөнгөлөлтийн олз	8, 21	–	(66,651)
Түрээсийн нөхцөл өөрчилсний олз		–	(64,644)
Үндсэн хөрөнгө борлуулсаны (олз)/гарз	8	7,551	(47,822)
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсаны олз	8	–	(1,568,755)
Борлуулах зориулалттай хөрөнгө борлуулсаны олз	8	–	(6,000)
Үнэ цэнийн бууралтын эрсдэлийн сангийн зардал/(буцаалт):			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	9	(10,555)	10,384
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	9	1,898	(1,806)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	9	325,930	381,130
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр	9	72,750	(6,972)
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр	9	124,335	122,466
Бусад хөрөнгө	9	(16,480)	(9,161)
Тэнцлийн гадуурх үүрэг	9	19,977	2,127
Үндсэн хөрөнгийн элэгдэл	10	911,032	637,311
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн элэгдэл	10	–	162,638
Биет бус хөрөнгийн хорогдуулга	10	454,391	146,756
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	10	825,453	568,609
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	10	13,367	10,453
Зээлээр авсан эх үүсвэрийн хүүний зардал	5	378,565	21,582
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хүүний зардал	5	56,256	–
Түрээсийн өр төлбөрийн хүүний зардал	5, 21	437,697	358,686
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус (олз)/гарз	8	(1,224,476)	71,445
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг		23,219,612	8,666,757
<i>Эргэлтийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>			
Монголбанкинд заавал байлгах нөөц		(15,197,352)	(46,482,337)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		(23,793,251)	11,109,860
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		(61,040,183)	(47,029,051)
Бусад хөрөнгө		(4,085,935)	(1,793,207)
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж		18,554,271	(2,255,162)
Харилцагчдын харилцах, хадгаламж		80,128,161	36,439,746
Репо хэлцэл		13,373,870	24,663,523
Бусад өр төлбөр		4,973	3,393,411
Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		31,164,166	(13,286,469)
Орлогын албан татварын төлөлт	11.2	(1,866,258)	(929,489)
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт төлсөн цэвэр хүү		(13,808)	
Түрээсийн өр төлбөрийн хүүний төлөлт		(394,042)	(358,686)
Зээлээр авсан эх үүсвэрт төлсөн хүү		(23,344)	(150,095)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		28,866,714	(14,724,739)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салингүй хэсэг болно

Богд Банк ХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

	Тод.	2022 мян.төг	2021 мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Санхүүгийн хөрөнгө оруулалтын худалдан авалт		(115,145,173)	(62,473,244)
Үндсэн хөрөнгө худалдан авалт	20	(2,323,915)	(1,801,097)
Биет бус хөрөнгө худалдан авалт	22	(530,396)	(195,552)
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө худалдан авалт		(2,664,922)	–
Борлуулах зориулалттай хөрөнгө борлуулснаас орсон мөнгө	19	110,000	885,090
Үндсэн хөрөнгө борлуулснаас орсон мөнгө		87,540	634,480
Ногдол ашгаас орсон мөнгө		67,298	97,900
Санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулснаас орсон мөнгө		84,919,291	50,727,969
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулснаас орсон мөнгө		–	4,996,224
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(35,480,277)	(7,128,230)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Зээлийн эх үүсвэрийн санхүүжилт		36,543,631	6,575,126
Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт		(18,600,737)	(5,750,678)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт		(634,642)	(380,334)
Ногдол ашгийн төлөлт	28	(1,205,000)	–
Нэмж гаргасан энгийн хувьцаанаас орсон мөнгө		–	30,306,822
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		16,103,252	30,750,936
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)		9,489,689	8,897,976
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13	82,567,093	73,669,117
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13	92,056,782	82,567,093
ХҮҮТЭЙ ХОЛБООТОЙ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хүүний төлөлт		(10,335,111)	(9,847,349)
Хүлээн авсан хүүний орлого		41,952,307	28,811,336
МӨНГӨН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА			
Хувьцаагаарх ногдол ашиг	28	18,250,000	–
Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийн нэмэгдэл	21	200,130	927,248
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс Борлуулах зориулалттай хөрөнгөд шилжүүлсэн	19	543,963	1,569,300

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиугүй хэсэг болно.

Богд Банк ХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

	2022	2021
	мян.төг	мян.төг
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнээс үүссэн өр төлбөрийн хөдөлгөөн:		
Түрээсийн өр төлбөр		
1 дүгээр сарын 1	2,994,860	2,292,720
Мөнгөн бус нэмэгдэл	551,904	1,149,125
Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт	–	(66,651)
Тайлант жилийн хүүний зардал	437,697	358,686
Түрээсийн өр төлбөрийн хүүний төлөлт	(394,042)	(358,686)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөр төлөлт	(634,642)	(380,334)
12 дугаар сарын 31	2,955,777	2,994,860
Зээлээр авсан эх үүсвэр		
1 дүгээр сарын 1	8,212,568	7,464,732
Зээлийн эх үүсвэрийн санхүүжилт	36,543,631	6,575,126
Үндсэн төлбөр төлөлт	(18,600,737)	(5,750,678)
Хүүний төлөлт	(23,344)	(150,095)
Эргэн төлөлт, цэвэр	17,919,550	674,353
Гадаад валютын ханшийн тэгшитгэл	626,941	51,901
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн бус гүйлгээ	626,941	51,901
Хүүний өглөг	378,565	21,582
12 дугаар сарын 31	27,137,624	8,212,568

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салиугүй хэсэг болно.

1. Банкны талаарх мэдээлэл

Богд Банк нь Монголбанкнаас (“МБ”) олгосон 27 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээг 2014 оноос хойш үзүүлж байгаа бөгөөд тайлант жил болох 2022 онд Банкны үндсэн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт ороогүй болно. Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг хувьцаат компани юм. Банкны төв байрны албан ёсны хаяг нь Бодь Цамхаг, 1-р Хороо, Жигжиджавын гудамж 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот - 15160, Монгол Улс.

Банкны нийт хувьцааны 73.06%-ийг Бодь Капитал ХХК (2021: 73.06%), 6.94%-ийг Богд Капитал Инвестмент ХХК (2021: 6.94%) болон бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Банкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлангуудыг 2023 оны 3 дугаар сарын 15-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр баталсан.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого**2.1 Тайлан бэлтгэх үндэслэл ба нийцлийн мэдэгдэл**

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангуудыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн болон өмчийн хэрэглүүр, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, бодит үнэ цэнээр хэмжигдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүр, дансны цэвэр дүн ба бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассаны аль багаар хэмжигдсэн худалдах зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгөөс бусдаар түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлангийн дүнгүүдийг Банкны үйл ажиллагааны мөнгөн нэгж болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр (төг) тайлагнаж, тодруулгад өөрөөр заагаагүй бол мянганы орноор бүхэлчилсэн болно.

2.2 Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг харгалзах хөрөнгө/өр төлбөрийн дийлэнх хэсгийг нөхөх/барагдуулах банкны төлөвлөгөө болон чадварт үндэслэн хөрвөх чадвараар нь эрэмбэлэн толилуулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас дээш хугацаанд (урт хугацаанд) эргэн төлөгдөх эсвэл барагдуулах төлбөрийн шинжилгээг Тодруулга 33-г толилуулав.

Ирээдүйн үйл явдлаас учирч болзошгүй бус, хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй бөгөөд цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа эсвэл нэгэн зэрэг хөрөнгөө худалдаж өр төлбөрөө барагдуулах нөхцөлд л санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн ямар нэгэн стандарт, тайлбараар зөвшөөрөгдсөн эсвэл шаардсан болон банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан зааснаас бусад тохиолдолд орлого, зардлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлээгүй.

2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Банк нь эдгээр стандартуудыг хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөж эхэлнэ.

• СТОУС 17	<i>Даатгалын гэрээ¹</i>
• СТОУС 17 нэмэлт өөрчлөлт	<i>Даатгалын гэрээ¹</i>
• НББОУС 1 нэмэлт өөрчлөлт	<i>Эргэлтийн болон эргэлтийн бус өр төлбөрийн ангилал</i>
• НББОУС 8 нэмэлт өөрчлөлт	<i>Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт¹</i>
• НББОУС 1, СТОУС Практик тайлагнал 2-т орсон нэмэлт өөрчлөлт	<i>НББ-ийн бодлогын толилуулга¹</i>
• НББОУС 12 нэмэлт өөрчлөлт	<i>Нэг гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар¹</i>
• СТОУС 16 нэмэлт өөрчлөлт	<i>Борлуулаад буцаан түрээслэсэн хөрөнгийн түрээсийн өглөг²</i>
• НББОУС 1 нэмэлт өөрчлөлт	<i>Гэрээгээр хүлээсэн үүрэг бүхий эргэлтийн бус өр төлбөрүүд²</i>
• СТОУС 10, НББОУС 28 нэмэлт өөрчлөлт	<i>Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсхүл шилжүүлсэн хөрөнгө³</i>

¹2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант тайлант хугацаанд хүчинтэй

²2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлант тайлант хугацаанд хүчинтэй

³Хүчин төгөлдөр болох хугацааг тогтоогоогүй ч хэрэгжих боломжтой

СТОУС 17 Даатгалын гэрээ

2017 оны 5-р сард НББОУСЗ нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн шинэ стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг баталсан. СТОУС 17 нь хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)

СТОУС 17 Даатгалын гэрээ (үргэлжлэл)

СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран бүх төрлийн даатгалын гэрээнд (жишээлбэл, амь насны даатгал, шууд даатгал, давхар даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой онцлог бүхий санхүүгийн хэрэгсэл болон баталгаанд үйлчилнэ. Стандартын хамрах хүрээ нь цөөн хэдэн хязгаарлалттай. СТОУС 17 нь даатгалын шинж чанар бүхий банкны бүтээгдэхүүнүүдэд ямар хэрэгслүүд, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд нь СТОУС 9 эсвэл СТОУС 17-ийн хүрээнд хамрагдах эсэхийг тодорхойлоход нөлөөлж болохуйц нягтлан бодох бүртгэлийн шинэ шаардлагыг нэвтрүүлж байна.

Даатгалд хамрагддаг зээлийн карт ба түүнтэй адилтгах бүтээгдэхүүнүүд: эдгээр бүтээгдэхүүнийг олгогчдын ихэнх нь СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэгсэл гэж үзэн одоогийн ашиглаж буй бүртгэлийн зарчмыг үргэлжлүүлэх боломжтой болно. СТОУС 17 нь даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан зээлийн картын гэрээг (мөн түүнтэй адилтгах зээлийн эсвэл төлбөрийн нөхцөлтэй бусад гэрээг) гагцхүү аливаа нэг үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг тогтоохдоо тухайн үйлчлүүлэгчийн даатгалтай холбоотой эрсдэлийг тусгаагүй тохиолдолд СТОУС 17-ийн хамрах хүрээнд оруулахгүй.

Хэрэв даатгалын нөхцөл нь зээлийн картын гэрээний нөхцөлийн нэг хэсэг болж олгогддог тохиолдолд, олгогч нь дараах шаардлагын дагуу бүртгэнэ:

- Даатгалын бүрэлдэхүүн хэсгийг салгаж СТОУС 17-ийн дагуу бүртгэх
- Бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох бусад стандартууд (жишээлбэл, СТОУС 9, СТОУС 15 Хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний орлого эсвэл НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө гэх мэт)-ын дагуу бүртгэнэ.

Даатгалын шинж чанарыг хангасан боловч даатгалын тохиолдол үүсэхэд гэрээний дагуу даатгуулагчийн үүргийг биелүүлэхэд шаардагдах хэмжээгээр нөхөн төлбөрийг хязгаарласан зээлийн гэрээ: Энэ төрлийн зээлийг олгогчид – жишээ нь, нас баралтаас болон чөлөөлөгдсөн зээл - СТОУС 9 эсвэл СТОУС 17-г сонгох боломжтой. Уг сонголт нь эргэлт буцалтгүй бөгөөд багцын түвшинд хийгдэнэ.

СТОУС 17 нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэх эсвэл түүнээс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд шаардлагатай тоон үзүүлэлтүүдийг харьцуулна. Хэрэв Банк нь СТОУС 17 анх хэрэгжүүлж эхлэхээс өмнө эсвэл тухайн өдрөөс эхлэн СТОУС 9 болон СТОУС 15 стандартуудыг хэрэгжүүлж эхэлсэн тохиолдолд СТОУС 17-г хугацаанаас өмнө мөрдөж эхлэхийг зөвшөөрсөн. Энэхүү стандарт нь Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

СТОУС 17 Даатгалын гэрээнд орсон нэмэлт өөрчлөлтүүд

СТОУС 17-д оруулсан нэмэлт өөрчлөлтөд стандартын зарим шаардлагыг хялбарчлах, санхүүгийн гүйцэтгэлийг тайлбарлахад хялбар болгох өөрчлөлтүүдийг оруулсан болно. Нэмэлт өөрчлөлтүүд нь СТОУС 17-д шилжихэд шаардагдах хүчин чармайлтыг багасгах нэмэлт хөнгөлөлтүүдийг тусгасан. Мөн нэмэлт өөрчлөлтүүд нь СТОУС 17-ын хүчин төгөлдөр болох хугацааг 2023 оны 1-р сарын 1-нээс хойшхи жилийн тайлангийн үе болгон хойшлуулсан бөгөөд хугацаанаас өмнө мөрдөж эхлэхийг зөвшөөрсөн. Энэхүү нэмэлт өөрчлөлтүүд нь Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үнэлж байна.

НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлт: Эргэлтийн болон эргэлтийн бус өр төлбөрийн ангилал

2020 оны 1-р сард НББОУС3-с НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 69-76-р хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулж өр төлбөрийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилах шаардлагыг тодотгосон. Нэмэлт өөрчлөлтүүдэд:

- Төлбөр тооцоог хойшлуулах эрх гэж юу болох
- Тайлант хугацааны эцэст хойшлуулах эрхтэй байх ёстой
- Ангилал нь аж ахуйн нэгжийн хойшлуулах эрхээ хэрэгжүүлэх магадлалаас шалтгаалахгүй
- Зөвхөн хөрвөх нөхцөлтэй өр төлбөрт агуулагдах дериватив нь өөрөө өмчийн хэрэгсэл болох тохиолдолд өр төлбөрийн хугацаа нь түүний ангилалд нөлөөлөхгүй

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойшхи тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд буцаан мөрдөх нөхцөлтэй. Нэмэлт өөрчлөлтүүд нь Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт - НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлтүүд

2021 оны 2-р сард НББОУС3 нь НББОУС 8-ийн НББ-ийн тооцооллын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү өөрчлөлтүүд нь НББ-ын тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга зэргийн хоорондын ялгааг тодорхойлсон. Мөн аж ахуй нэгжүүд НББ-ийн тооцооллыг боловсруулахад хэмжилтийн техник болон өгөгдөл хэрхэн хэрэглэгддэгийг тодруулж өгсөн.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)*****Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт - НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлтүүд (үргэлжлэл)***

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсвэл түүнээс хойшхи тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болох бөгөөд НББ-ийн тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлтүүдэд үйлчилнэ. Холбогдох баримтуудыг толилуулсан тохиолдолд хугацаанаас өмнө мөрдөж эхлэхийг зөвшөөрсөн. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 1 болон СТОУС Практик тайлагнал 2-т орсон нэмэлт өөрчлөлтүүд: НББ-ийн бодлогын толилуулга

2021 оны 2-р сард НББОУС3-өөс НББОУС 1 болон СТОУС Практик тайлагнал 2-т материаллаг байдлын дүгнэлт хийх нэмэлт өөрчлөлтүүд оруулсан. Энэ нь НББ-ийн толилуулгад материаллаг байдлын дүгнэлтийг ашиглах заавар жишээг багтаасан. Нэмэлт өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжүүдэд "гол" нягтлан бодох бүртгэлийн толилуулах шаардлагыг "материаллаг" нягтлан бодох бүртгэлийн бодлогоо ил тод болгох шаардлагаар сольж, аж ахуйн нэгжүүд материаллаг байдлын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах талаар зааварчилгааг нэмж оруулснаар илүү хүртээмжтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгын гаргахад туслах зорилготой юм.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсвэл түүнээс хойшхи тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд хугацаанаас өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Практик тайлагнал 2 нь НББ-ийн мэдээлэлд материаллаг байдлын тодорхойлох заавал шаардагдахгүй зааварчилгааг гаргасан тул энэ өөрчлөлтөд хүчин төгөлдөр болох огноо шаардлагагүй болно. Банк одоогоор энэхүү нэмэлт өөрчлөлт нь НББ-ийн бодлогын тодруулгад хэрхэн нөлөөлөхийг үнэлж байна.

Нэг гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар - НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт

2021 оны 5-р сард НББОУС3 НББОУС 12-т нэмэлт өөрчлөлт оруулан НББОУС 12-ын дагуу анхны хүлээн зөвшөөрөлтийн хамрах хүрээг багасгаж, тэнцүү дүнтэй татвар ногдох болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг үүсгэдэг ажил гүйлгээнд цаашид хамаарахгүй болсон.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг санхүүгийн тайланд толилуулж буй зэрэгцүүлсэн тайлант жилийн эхэнд эсвэл тайлант жилийн эхнээс хойшхи хугацаанд гарсан ажил гүйлгээнд дагаж мөрдөнө. Мөн, санхүүгийн тайланд толилуулж буй зэрэгцүүлсэн тайлант хугацааны эхэнд татвар ногдох болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү үүсгэж буй түрээс болон ашиглалтаас хасах үүрэгтэй холбоотой бүх гүйлгээнд хойшлогдсон татварын хөрөнгө (татвар ногдох ашиг хангалттай үед), өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Борлуулаад буцаан түрээслэсэн хөрөнгийн түрээсийн өглөг - НББОУС 16-ын нэмэлт өөрчлөлт

СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлт нь борлуулагч-түрээслэгчийн ашиглах эрхтэй холбоотой ашиг, алдагдлыг хүлээн зөвшөөрөхгүй байхын тулд борлуулагч-түрээслэгчийн борлуулах, буцаан түрээслэх гүйлгээний явцад үүссэн түрээсийн өр төлбөрийг хэмжиж ашиглах шаардлагыг онцолдог. Нэмэлт өөрчлөлтүүд нь 2024 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчинтэй байх бөгөөд СТОУС 16-ыг анх хэрэгжүүлсэн өдрөөс хойш (өөрөөр хэлбэл 2019 оны 1-р сарын 1) хийсэн борлуулах болон буцаан түрээслэх гүйлгээнд хэрэглэх ба өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

Гэрээгээр хүлээсэн үүрэг бүхий эргэлтийн бус өр төлбөрүүд - НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт

2022 оны 10-р сард НББОУС3-өөс гаргасан 2022 оны НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүдээр зээлийн гэрээнээс үүсэх өр төлбөрийн зохистой шалгуур үзүүлэлтүүд дотроос зөвхөн тухайн байгууллага тайлант өдөр буюу түүнээс өмнө дагаж мөрдөх ёстой шалгуур үзүүлэлт нь тухайн өр төлбөрийн эргэлтийн болон эргэлтийн бус ангилалд нөлөөлнө гэдгийг илүү тодотгосон. Түүнчлэн 2022 оны нэмэлт өөрчлөлтүүд нь тайлагнаснаас хойш 12 сарын дотор ирээдүйн гэрээнд нийцэж байгаа өр төлбөрийг барагдуулахыг хойшлуулах эрхтэй бол зээлийн зохицуулалтаас үүссэн өр төлбөрийг эргэлтийн бус гэж ангилсан байгууллагаас нэмэлт тодруулга хийхийг шаардана. Нэмэлт өөрчлөлт нь 2024 оны 1-р сарын 1-ний өдөр буюу түүнээс хойшхи хугацаанд хүчинтэй байх бөгөөд өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Банк одоогоор нэмэлт өөрчлөлтийн нөлөөлөл болон одоо байгаа зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг үнэлж байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.3 Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)

Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсвэл шилжүүлсэн хөрөнгө - СТОУС 10 ба НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт

СТОУС 10 ба НББОУС 28-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь хөрөнгө оруулагч болон түүний хараат болон хамтарсан компанийн хооронд хөрөнгө худалдах болон шилжүүлэхтэй холбоотой СТОУС 10 болон НББОУС 28-ын шаардлагуудын хоорондын зөрчилтэй байдлыг зохицуулсан. Хөрөнгө оруулагч болон түүний хараат болон хамтарсан компанийн хооронд хөрөнгө борлуулах, шилжүүлэх гүйлгээ нь бизнесийн шинж чанартай бол толгой компанитай хийсэн гүйлгээний үр дүнд гарсан ашиг, алдагдлыг хараат эсвэл хамтарсан компанийг бүрэн хүлээн зөвшөөрөхийг шаардана. Хэрвээ тухайн гүйлгээ бизнесийн шинж чанаргүй бол гүйлгээний үр дүнд бий болсон олзыг зөвхөн тухайн хараат эсвэл хамтарсан компани дахь хамааралгүй хөрөнгө оруулагчийн хувь хэмжээгээр хөрөнгө оруулагчийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Нэмэлт өөрчлөлт нь ирээдүйн тайлант жилүүдэд мөрдөгднө. Нэмэлт өөрчлөлтийг мөрдөх албан хугацааг хараахан тогтоогоогүй байгаа ч хэрэгжүүлэх боломжтой.

2.4 Шинэ болон нэмэлт өөрчлөлт оруулсан стандарт, тайлбар

Банк нь гаргасан санхүүгийн тайланд батлагдсан боловч хараахан хүчин төгөлдөр болоогүй шинэ стандарт, тайлбар, нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлээгүй. 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон доорх СТОУС-ууд болон нэмэлт өөрчлөлтүүдээс бусад Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил байна. 2022 онд анх удаа мөрдөгдсөн бусад нэмэлт өөрчлөлт, тайлбарууд нь Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй юм.

- | | |
|-----------------------------|--|
| • СТОУС 3 нэмэлт өөрчлөлт | <i>Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж</i> |
| • НББОУС 16 нэмэлт өөрчлөлт | <i>Үндсэн хөрөнгө: Зориулалтын дагуу ашиглахаас өмнөх орлого</i> |
| • СТОУС 1 нэмэлт өөрчлөлт | <i>Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын анхлан хэрэгжилт – Охин компани анхлан хэрэгжүүлэх</i> |
| • НББОУС 37 нэмэлт өөрчлөлт | <i>Алдагдалтай гэрээ - Гэрээг биелүүлэх зардал</i> |
| • СТОУС 9 нэмэлт өөрчлөлт | <i>Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх “10 хувь” шалгуурт орох хураамж</i> |
| • НББОУС 41 ХАА | <i>Бодит үнэ цэнийн хэмжилттэй холбоотой татварын асуудлууд</i> |

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй

Гадаад валютын ханшийн тэгшитгэл

Санхүүгийн тайлангууд нь банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр толилуулагдсан. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээг хийсэн өдрийн спот ханшаар үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт рүү хөрвүүлж, бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг тайлагналын өдрийн спот ханшаар дахин хөрвүүлдэг. Арилжааны бус үйл ажиллагаанаас үүссэн ханшийн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагааны бусад орлого/зардлаар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн, түүхэн өртгөөр хэмжигддэг мөнгөн бус зүйлсийг хүлээн зөвшөөрөх өдрийн спот ханшаар хөрвүүлнэ.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Үр ашигт хүүний аргачлал

СТОУС 9-ийн дагуу хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн санхүүгийн бүх хөрөнгүүд, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн хүүний орлогыг үр ашигт хүүний арга ашиглан тодорхойлно. Мөн СТОУС-9-ийн дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийн хүүний орлогыг үр ашигт хүүний арга ашиглан тодорхойлно. Үр ашигт хүү гэдэг нь санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудыг хугацааных нь туршид эсвэл тохиромжтой гэж үзсэн богино хугацаанд дансны үнэ хүртэл нь хорогдуулсан хүү юм.

Үр ашигт хүүг (цаашлаад санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг) үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын хөнгөлөлт, урамшуулал, шимтгэл болон зардлыг оруулан тооцдог. Банк нь зээлийн нийт хугацааны турш тогтмол өгөөж хүртэнэ гэсэн хамгийн сайн тооцооллыг илэрхийлэх өгөөжийн хувиар хүүний орлогыг бүртгэдэг. Тиймээс өөр шатлалуудад тооцогдсон хүүний түвшнүүдийн нөлөөлөл болон бүтээгдэхүүний нийт хугацааны бусад шинж чанаруудыг (урьдчилж төлсөн төлбөр, нэмэгдүүлсэн хүү болон шимтгэлүүд) оролцуулан тооцдог.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)****Орлого хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)*****Үр ашигт хүүний аргачлал (үргэлжлэл)***

Хэрэв санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь зээлийн эрсдэлээс бусад шалтгаанаар өөрчлөгдсөн бол ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалуудын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр дискаунтчилан цаашлаад дансны үнийг тохируулна. Уг өөрчлөлт нь эерэг эсвэл сөрөг залруулгаар санхүүгийн байдлын тайланд тухайн санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны үнэд нөлөөлж үр ашигт хүүний аргаар тооцоолсон хүүний орлого/зардлыг нэмэгдүүлж эсвэл бууруулж болно.

Хүү болон түүнтэй адилтгах орлого/зардал

Цэвэр хүүний орлого болон зардлыг үр ашигт хүүний арга болон бусад аргыг ашиглан тооцдог. Эдгээрийг хүүний орлого болон зардлын аль алины хувьд харьцуулагдахуйц мэдээллийг харуулахын тулд орлогын тайланд тусад нь толилуулсан болно. Банк нь зөвхөн дээр дурьдсан санхүүгийн хэрэгслүүдийн хувьд үр ашигт хүүний аргаар хүүний орлого болон зардлыг тооцоолдог. Бусад хүүний орлого болон зардалд үүсмэл санхүүгийн хэрэгслийн хейджд хэлцлийн хүү болон бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэхээр хэмжигддэг бүх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийн хүү (гэрээний хүүний хувь хэмжээгээр тооцдог худалдах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөөс бусад) орно. Арилжааны зориулалттай санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүүний орлого болон зардал нь “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр хүлээн зөвшөөрөгдсөн болно.

Банк нь үнэ цэнэ буурсан гэж үзсэнээс бусад санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг үр ашигт хүүний аргаар уг санхүүгийн хөрөнгийн дансны үнээс тооцдог. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурч (“Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бууралт” тодруулгын дагуу), “3-р шатлал” –д орсон тохиолдолд Банк үр ашигт хүүний аргыг ашиглан санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан цэвэр өртгөөс хүүний орлогыг тооцно. Санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орохоо больсон (“Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бууралт” тодруулгын дагуу) тохиолдолд хүүний орлогыг дансны үнээс тооцно.

Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт (ХАҮҮЦБ) санхүүгийн хөрөнгүүдийн хувьд, Банк нь хүүний орлогыг зээлээр залруулагдсан үр ашигт хүүгээр хөрөнгийн хорогдуулсан өртгөөс тооцно. Зээлээр залруулагдсан үр ашигт хүү нь анх хүлээн зөвшөөрөх үед ирээдүйн мөнгөн гүйлгээг (үнэ цэнийн бууралтыг оруулан) ХАҮҮЦБ хөрөнгийг хорогдуулсан өртөг руу хорогдуулах хүү юм. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэхээр хэмжигддэг арилжааны хөрөнгө ба санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг гэрээнд заасан хүүгээр бүртгэнэ.

Хураамж ба шимтгэлийн орлого

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсний хариуд Банкны олох төлбөрийн хэмжээг тусгасан хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Гүйцэтгэлийн үүрэг, түүнчлэн тэдгээрийг биелүүлэх хугацааг гэрээ байгуулах үед тодорхойлдог. Банкны орлогын гэрээнд ихэвчлэн хэд хэдэн гүйцэтгэлийн үүрэг байдаггүй бөгөөд үүнийг доор тайлбарласан болно. Банк нь харилцагчдадаа үйлчилгээ үзүүлэх үед төлбөрийг нэхэмжлэх бөгөөд ихэнхдээ үйлчилгээ үзүүлсэн даруй эсвэл тодорхой хугацаанд үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг гэрээний хугацаа дууссаны дараа авдаг (доорхиос өөрөөр заагаагүй бол). Банк нь үйлчилгээг харилцагчид шилжүүлэхээс өмнө ихэвчлэн хяналт тавьдаг тул орлогын зохицуулалтын үндсэн үүрэг гэж дүгнэсэн.

Гэрээт хугацаацаагаар үзүүлж буй үйлчилгээний хураамжийн орлого

Гэрээт хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Үүнд шимтгэлийн орлого, хөрөнгийн зохицуулалт, кастодиан, бусад зохицуулалт болон зөвлөх үйлчилгээний хураамжууд багтана.

Гүйлгээний үйлчилгээ үзүүлсний шимтгэлийн орлого

Гуравдагч талын өмнөөс ажил гүйлгээ (хувьцаа эсвэл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт) -тэй холбоотой хэлэлцээр хийх эсвэл оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжуудыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй уялдан хураамж эсвэл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсаны дараа хүлээн зөвшөөрнө.

Холбогдох санхүүгийн хэрэглүүрийн салшгүй хэсэг болох шимтгэлийн орлого

Банкны холбогдох санхүүгийн хэрэглүүрийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого нь: зээл олголтын шимтгэл, татан авагдах магадлалтай зээлүүд дээр зээлийн үйлчилгээний шимтгэл болон зээлтэй холбоотой бусад шимтгэлүүд орно. Эдгээр шимтгэл нь (өсөн нэмэгдэх аливаа зардлын хамт) зээлийн үр ашигт хүүний залруулга гэж хүүний орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө. Харин татан авахгүй нь бараг тодорхой болсон зээлүүдийн зээлийн үйлчилгээний шимтгэл нь хугацааны эцэст орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Хураамж ба шимтгэлийн орлого (үргэлжлэл)

Хураамж ба шимтгэлийн зардал

Хураамжийн зардал нь арилжааны банкинд төлсөн захиргааны болон тогтмол шимтгэлийн хураамжийг илэрхийлнэ. Хураамжийн зардлыг бодит үйлчилгээ үзүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой гүйцэтгэлтэй холбоотой төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг зохих шалгуурыг хангасны дараа хүлээн зөвшөөрдөг.

Арилжааны цэвэр орлого

Арилжааны цэвэр орлогод арилжаалахад зориулагдсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт, түүнтэй холбоотой хүүний орлого/зардал, ногдол ашиг багтана.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө, өр төлбөрөөс үүсэх цэвэр ашиг, алдагдал

СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх хөрөнгө, өр төлбөрөөс үүсэх цэвэр ашиг, алдагдалд ашиг алдагдлаар бүртгэгдэх хөрөнгө, өр төлбөр гэж ангилагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөртэй холбоотой бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз гарз, хүү, ногдол ашиг, болон валютын өөрчлөлтийг хамруулан ойлгоно.

Хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөс үүсэх цэвэр ашиг, алдагдал

Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгүүдийг үл хүлээн зөвшөөрөхөд үүсэх цэвэр ашиг, алдагдал нь хорогдуулсан өртгөөр хэмжигдэх эсвэл бодит үнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийг борлуулах эсвэл үл хүлээн зөвшөөлөх үеийн хүлээн авсан орлого болон дансны үнэ (үнэ цэнэ бууралт тооцсон) хоорондын зөрүүгээр тооцсон алдагдал (эсвэл ашиг)-аар хэмжигдэнэ.

Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт

Хүлээн зөвшөөрөх өдөр. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, харилцагчдын харилцах болон хадгаламжаас бусад бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдрөөр (Банк нь тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд хэвийн нөхцөлтэй арилжаа буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь хөрөнгийг харилцагчдын дансанд шилжүүлсэн үед хүлээн зөвшөөрнө. Банк нь харилцагчдын харилцах, хадгаламжийг банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн анхны хэмжилт. Санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрөх үеийн ангилал нь гэрээний нөхцөл болон бизнес загвар дээр үндэслэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүдийн анхны хэмжилт нь тэдгээрийн бодит үнэ цэнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүн байна. Худалдааны авлагын анхны хэмжилт нь гүйлгээний дүнгээр байна. Санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнэ нь ажил гүйлгээний үнээс ялгаатай үед Банк дор дурдсан “Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдал гэх бүртгэлийн аргачлалыг баримталдаг.

“Эхний өдөр” -ийн ашиг ба алдагдал. Ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнээсээ ялгаатай бөгөөд бодит үнэ цэнэ нь зах зээлийн ажил гүйлгээнээс ажиглагдахуйц өгөгдөлд суурилсан үнэлгээний аргачлал ашигласан байвал Банк нь бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн зөрүүг цэвэр арилжааны орлогоор хүлээн зөвшөөрнө. Зарим өгөгдөл нь ажиглагдахуйц мэдээлэлд суурилагагүй үнэлгээний загвараар тооцсон тохиолдолд ажил гүйлгээний үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг зөвхөн орлого орж ирэх нь тодорхой болсон эсвэл санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх тохиолдолд л орлого зардалд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хэмжих ангилал. Банк өөрийн бүх хөрөнгийг бизнесийн загвар болон гэрээний нөхцөл дээр үндэслэн дараах аль нэгээр нь ангилна:

- Хорогдуулсан өртгөөр бүртгэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх;
- Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хэрэглүүр - анхны хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хэмжих ангилал (үргэлжлэл)

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэглүүр болон арилжааны үнэт цаасны багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилж хэмжинэ. Хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтийн зөрчлийг арилгаж эсвэл бууруулж байгаа нөхцөлд Банк нь санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх гэж тодорхойлж болно. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаанаас бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр эсвэл, арилжааны зорилгоор эзэмшиж буй эсвэл үүсмэл санхүүгийн хэрэглүүр тохиолдолд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдлын тайланд бүртгэж хэмжинэ.

Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Банк нь үнэлгээний аргачлалуудыг ашиглан санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

- Түвшин 1 – санхүүгийн хэрэглүүрүүд – Үнэлгээнд ашиглагдсан өгөгдлүүд нь хэмжилтийн өдрөөрх бирж дээр бүртгэлтэй ижил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийн (залруулаагүй) идэвхтэй зах зээл дээрх үнэ юм. Банк нь хэмжээ болон хөрвөх чадварын хувьд адил төсөөтэй хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн тайлангийн өдрөөр боломжтой, заавал болон хэрэгжих үнийн хангалттай арилжааны үйл ажиллагаатай байхыг идэвхтэй зах зээл гэж үзнэ.
- Түвшин 2 – санхүүгийн хэрэглүүрүүд – Үнэлгээнд ашигласан өгөгдлүүдийг санхүүгийн хэрэглүүрийн дуусах хугацааны туршид боломжтой байх зах зээлийн бүх өгөгдлүүдээс шууд болон шууд бусаар үнэлгээнд ашигласан өгөгдлүүд юм. Эдгээр өгөгдлүүдийн дотор идэвхтэй зах зээл дээрх ижил төстэй хөрөнгө болон өр төлбөрийн үнэ, идэвхгүй зах зээл дээрх ижил төстэй хэрэглүүрийн үнэ болон үүнээс өөр хүүний түвшин, өгөөжийн муруй, харгалзах хэлбэлзэл, зээлийн эрсдэлийн үнэ гэр зэрэг ажиглагдахуйц өгөгдлүүд орно. Түүнчлэн, тухайн хөрөнгийн шинж байдал болон байршил, харьцуулах зүйлсийн аль нь үнэлгээ тогтоосон хэрэглүүртэй холбогдох зэргээс хамааран залруулга хийж болно. Гэвч ажиглагдахуйц бус өгөгдөл дээр үндэслэн нийт хэмжилтэд чухал ач холбогдолтой дээрх залруулгыг хийсэн бол Банк нь хэрэглүүрийг Түвшин 3-р ангилна.
- Түвшин 3 – санхүүгийн хэрэглүүрүүд – Эдгээрт, хэмжилтийн хувьд бүхэлдээ чухал ач холбогдол бүхий нэг болон түүнээс дээш ажиглагдахуйц бус өгөгдлүүд багтана.

Банк нь үнэлгээний техник, хэрэгжүүлж буй аргачлалууд болон загварын тохируулгуудаа тогтмол шалгаж үздэг. Гэвч суурь загвар нь Банкны санхүүгийн хэрэглүүрийг үнэлэхтэй холбоотой бүх хүчин зүйлүүд болох зээлийн эрсдэл, өөрийн зээлийн болон/эсвэл санхүүжилтийн зардал зэргийг бүрэн дүүрэн хамруулж чадахгүй байх магадлалтай юм. Иймд Банк нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэглүүртэй холбоотой зээлийн эрсдэлийг тооцоолоход төрөл бүрийн техник хэрэглэдэг ба үүнд хөрөнгө тус бүрийн хувьд ашиглалтын хугацааны туршид холбогдох талд хүлээгдэж буй зээлийн эрсдэлийг багцад суурилан тооцох аргачлал багтдаг бөгөөд энэ нь холбогдох талд хүлээгдэж буй барьцаагүй санхүүгийн хэрэглүүрийн зээлийн эрсдэлийг тусгахын тулд хийгддэг. Банк өөрийн зээлийн үнэ цэнийг зах зээлийн бодит өгөгдлүүдээс, тухайлбал, арилжаалагдсан өрийн хоёрдогч үнэ зэргээс тооцдог. Тайлант хугацааны эцэс бүрт Банк нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэглүүр

Банк нь доорх нөхцөлүүд хангагдсан тохиолдолд бусад Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах хадгаламж, харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа болон бусад санхүүгийн хэрэглүүрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ:

- Бизнесийн загварын зорилго нь гэрээнд заасан мөнгөн төлбөрийг цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмшиж байгаа
- Санхүүгийн хөрөнгүүдийн гэрээний нөхцөл нь тодорхой үеүдэд үлдэгдлийн үндсэн төлбөр болон хүүний төлбөрийн мөнгөн гүйлгээг ихэсгэдэг.

Эдгээр нөхцөлүүдийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв.

Бизнесийн загварын үнэлгээ. Бизнесийн зорилгодоо хүрэхийн тулд санхүүгийн хөрөнгийг хамгийн үр дүнтэйгээр удирдах түвшинд Банк нь бизнес загвараа тодорхойлно.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Банкны бизнес загвар нь хэрэглүүрийн түвшинд биш нийлмэл багцын түвшинд хянагддаг ба дараах ажиглагдахуйц хүчин зүйлсээс хамаарна:

- Бизнес загварын (тухайн бизнес загварт хамаарагдах санхүүгийн хөрөнгө) үр дүнд нөлөөлж буй эрсдэл ба эдгээр эрсдэлийг хэрхэн хянах аргачлал
- Байгууллагын удирдлагуудад хэрхэн урамшуулал олгодог (санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл гэрээний цуглуулсан мөнгөн урсгал дээр үндэслэдэг)

Борлуулалтын хүлээгдэж буй давтамж, үнэ цэнэ ба хугацаа нь үнэлгээ хийхэд чухал хүчин зүйл болно.

Бизнес загварын тест нь хамгийн боломжит хувилбар дээр үндэслэдэг ба ‘хамгийн муу’ эсвэл ‘стресс’ нөхцөлүүдийг харгалзан үздэггүй. Хэрэв анхны хүлээн зөвшөөрөлтийн дараах мөнгөн урсгал нь анх таамагласан хүлээлтээс өөр байвал Банк тухайн бизнес загварт хамааралтай санхүүгийн хөрөнгийн ангиллыг солихгүй бөгөөд харин уг мэдээллийг шинээр санхүүгийн хөрөнгө худалдаж авах үед үнэлгээндээ оруулан үздэг.

Үндсэн төлбөр ба хүүний төлбөрийн тест (ҮТХТ тест). Санхүүгийн хэрэглүүрийн ангиллын хоёр дахь шат бол Банк үндсэн төлбөр ба хүүний төлбөрийн шаардлагыг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийг дүгнэдэг.

Энэхүү төлбөрийн хүрээнд ‘Үндсэн’ гэдэг нь анхны хүлээн зөвшөөрөх үеийн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ бөгөөд санхүүгийн хөрөнгийн ашиглах хугацааны туршид өөрчлөгдөж болно (жишээ нь, үндсэн төлбөрийн эргэн төлөлт эсвэл урамшуулал/хөнгөлөлтийн хорогдуулалт).

Зээлийн гэрээн дэх хүүний хамгийн гол элемент нь мөнгөний өнөөгийн үнэ цэнэ болон зээлийн эрсдэл байдаг. Үндсэн төлбөр ба хүүний төлбөрийн төлбөрийн үнэлгээг хийхийн тулд Банк нь хүүний түвшнийг тогтоосон хугацаа гэх мэт холбогдох хүчин зүйлс, үнэлэмжийг авч үздэг.

Нөгөө талаас, эрсдэл үүрэх магадлал багатай гэрээний заалт эсхүл үндсэн зээлийн зохицуулалттай холбоогүй гэрээний мөнгөн урсгалын тогтворгүй байдал зэрэг нь зөвхөн үндсэн болон хүүний төлбөрийн үлдэгдэл дүнгийн гэрээний мөнгөн урсгалд нөлөөлөхгүй. Ийм тохиолдолд санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүр нь санхүүгийн хэрэглүүр эсвэл бусад гэрээ байхын тулд доорх гурван шинж чанарыг бүхэлд нь агуулах шаардлагатай:

- Үнэ цэнэ нь тодорхой хүүний түвшин, санхүүгийн хэрэглүүрийн үнэ, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон гэрээний холбогдох талын үүрэг хариуцлагад хамаарахгүй бусад хувьсагчийн өөрчлөлтөөс хамаардаг бол
- Анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаггүй эсвэл зах зээлийн хүчин зүйлсийн өөрчлөлтөд ижил байдлаар хариу үзүүлэх магадлалтай адил төсөөтэй гэрээнд шаардлагатайгаас бага анхны цэвэр хөрөнгө оруулалт шаарддаг бол
- Ирээдүйд төлөгдөхөөр бол

Банк нь төрөл бүрийн харилцагчидтай үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн хэлцэл хийдэг бөгөөд эдгээрт валют хүүний своп хэлцэл, гадаад валютын болон хүүний форвард гэрээ хэлцлүүд зэрэг орно. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг хейджийн нягтлан бодох бүртгэл хэрэглэж байгаагаас бусад үед “Бусад орлого”-д бүртгэдэг.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр. Анх хүлээн зөвшөөрсний дараа, Банк НББОУС-32 санхүүгийн хэрэглүүр толилуулга болон арилжаалах зорилгоор эзэмшдэггүй өмчийн тодорхойлолтод нийцсэн зарим өмчийн хэрэгслийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өмчийн хэрэглүүр рүү буцаах боломжгүйгээр ангилна. Энэ ангилал нь хэрэглүүрийн түвшинд суурилан тодорхойлогддог.

Энэ өмчийн хэрэглүүрийн олз гарзыг хэзээ ч ашиг алдагдлын тайланд бүртгэхгүй. Банк хүлээн авах орлогын санхүүгийн хэрэглүүртэй холбоотой зардлыг нөхөн төлбөрт ашигласан тохиолдолд ашиг нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх бол бусад үед төлбөрийн эрх нь баталгаажсан тохиолдолд ногдол ашгийг бусад үйл ажиллагааны орлого гэж ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх өмчийн хэрэглүүр нь үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамаарахгүй.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэглүүр. Банк нь өрийн хэрэглүүрийг доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өрийн хэрэглүүрт ангилна:

- Бизнесийн загварын дагуу гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон санхүүгийн хэрэгслийг борлуулах зорилгоор эзэмших
- Санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөр ба хүүний шалгуурыг хангах

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр нь бодит үнэ цэнээр хэмжигдэх бөгөөд бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэнэ. Хүүний орлого болон гадаад валютын ханшийн олз, гарзыг хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн адил ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг тодруулга 29-д тайлбарласан. Банк нь нэг төрлийн үнэт цааснаас нэгээс олныг эзэмшдэг бол эхэлж авснаа эхэлж зарлагадахаар бүртгэнэ. Үл хүлээн зөвшөөрөх үед бусад орлогод хуримтлагдсан олз, гарз нь бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдана.

Гаргасан өрийн хэрэглүүр ба зээлээр авсан эх үүсвэр. Анх хүлээн зөвшөөрсний дараа, гаргасан өрийн хэрэглүүр болон зээлээр авсан эх үүсвэр дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжигднэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүний нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг оруулна. Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн аль алиных нь элементүүдийг агуулсан нийлмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хүлээн зөвшөөрөгдөх өдөр салгана.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөр. Энэ ангилал дахь санхүүгийн хөрөнгө нь арилжаалах зорилгоор эзэмшээгүй бөгөөд анх хүлээн зөвшөөрөхдөө удирдлагаас тодорхойлогдсон эсвэл СТОУС-9-н дагуу бодит үнэ цэнээр хэмжих зайлшгүй шаардлагатай гэж тодорхойлсон.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөд тодорхойлсон хэрэгслүүдээс олсон хүүний орлого эсвэл зардал нь үр ашигт хүүгээр тэдгээрт хамаарах хямдруулалт, урамшууллыг оруулах ба болон тухайн хэрэгслийн салшгүй хэсэг болох гүйлгээний зардалыг тусган тооцдог. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүний хэмжээг гэрээний хүүг ашиглан бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүрийн ногдол ашгийн орлогыг төлбөр хийх эрх тогтоогдсон үед үйл ажиллагааны бусад орлогод бүртгэнэ.

Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн үүрэг. Банк нь санхүүгийн баталгаа, аккредитив болон зээлийн амлалт гаргадаг.

Санхүүгийн баталгаа гаргаж өгсний улмаас хүлээн авсан урамшууллыг санхүүгийн тайлангуудад (сангийн хамт) анхлан бүртгэхдээ бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараагийн тайлант үед баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хэмжихдээ анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд бүртгэсэн хуримтлагдсан хорогдлыг хассан дүн болон тодруулга 30-д толилуулсан хүлээгдэж буй алдагдал хоёрын аль өндрөөр нь хэмжинэ.

Хүлээн авсан урамшууллыг баталгааны хугацааны туршид ашиг, алдагдлын тайланд “Хураамж ба шимтгэлийн орлого”-оор хүлээн зөвшөөрнө.

Олгогдоогүй зээлийн амлалт болон аккредитив нь амлалт бөгөөд энэхүү амлалтын хугацаанд Банк нь урьдчилан тодорхойлсон нөхцөлтэй зээлийг харилцагчид олгох шаардлагатай. Санхүүгийн баталгааны гэрээнүүдийн адилаар тэдгээр гэрээнүүдэд “Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал”-ын шаардлагуудын дагуу сан байгуулна.

Санхүүгийн баталгаа, аккредитив болон ашиглагдаагүй зээлийн гэрээний үнэ цэнэ нь зах зээлд олгогдох зээлийн гэрээний нөхцөлтэй ижил байхаас гадна санхүүгийн байдлын тайланд тусгагдахгүй. Энэхүү санхүүгийн хэрэглүүрийн нэрлэсэн үнэ болон үнэ цэнийн бууралтын хүлээгдэж буй алдагдал нь Тодруулга 30-д тусгагдсан.

Харилцагчдын харилцах, хадгаламж. Үүнд харилцагчдаас авсан харилцах, хугацаагүй, хугацаатай хадгаламж болон Банкны баталгааны эх үүсвэр хамаарна. Анхны хэмжилтийн дараа үед харилцагчдад өгөх өр төлбөрүүдийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр (үргэлжлэл)

Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж. Бусад банк, санхүүгийн байгууллагуудаас татсан төгрөгийн болон валютын хадгаламжууд болон дотоод гадаадын арилжааны банкнууд, Монголбанкны хугацаатай хадгаламжууд мөн хамаарна. Банк нь харилцагчдын харилцах хадгаламжийг мөнгөн хөрөнгө нь Банкинд шилжсэн үед хүлээн зөвшөөрдөг. Анхны хэмжилтийн дараа бусад Банкнуудад өгөх өр төлбөрийг үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал. Банк санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш бизнесийн шугам худалдан авах, дуусгах болон цуцлах онцгой нөхцөл байдлаас бусад нөхцөлд дахин ангилахгүй. Санхүүгийн өр төлбөр дахин ангилагддаггүй.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлт

Санхүүгийн хөрөнгийн өөрчлөлт. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын болон зээлийн эрсдэлийн бус шалтгаанаар арилжааны бүтцийн өөрчлөлтийн үйл ажиллагааны үр дүнд гэрээний мөнгөн гүйлгээг дахин тохиролцсон эсвэл өөр хэлбэрээр бүтцийн өөрчлөлт оруулсан тохиолдолд, Банк уг өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийг данснаас хасахад хүргэсэн эсэхийг үнэлж тодорхойлдог. Санхүүгийн хөрөнгийн хувьд энэхүү үнэлгээ нь чанарын хүчин зүйл дээр суурилдаг

Банк харилцагчид олгосон зээлийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэхдээ доорх нөхцөлүүдийг авч үздэг:

- Зээлийн валют өөрчлөгдсөн
- Өмчийн шинж чанартай болсон
- Гэрээний тал өөрчлөгдсөн
- Өөрчлөлтийн улмаас ҮГХТ-ийн шалгуурыг хангахгүй болсон

Хэрвээ өөрчлөлт нь мөнгөн урсгалд мэдэгдэхүйц өөрчлөлт үзүүлээгүй бол энэ өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөх гэж авч үзэхгүй. Мөнгөн урсгалын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр хорогдуулсан дүнд үндэслэн уг өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд Банкны үнэ цэнийн бууралтын алдагдал бүртгээгүй хэсгээр бүртгэнэ.

Санхүүгийн өр төлбөрийн өөрчлөлт. Одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн нөхцөлийн өөрчлөлт нь ихээхэн ач холбогдолтой гэж дүгнэгдээгүй, улмаар данснаас хасахад хүргэхгүй бол санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг гэрээнд заасан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолохдоо санхүүгийн өр төлбөрийн анхны үр ашигт хүүний хямдруулалтын аргаар дахин тооцоолно. Үүний үр дүнд гарсан аливаа зөрүүг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Банк нь санхүүгийн өр төлбөрийн хувьд, чанарын хүчин зүйлээс хамаарч, засварласан хямдруулсан өнөөгийн үнэ цэнэ болон санхүүгийн өр төлбөрийн анхны дансны үнийн хооронд арав буюу түүнээс дээш хувьтай зөрүү гарахад хүргэсэн өөрчлөлтийг мэдэгдэхүйц гэж үзнэ.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр үл хүлээн зөвшөөрөлт

Хугацаа болон нөхцөлд их хэмжээний өөрчлөлт орсны улмаас үл хүлээн зөвшөөрөх. Харилцагчдад олгосон зээл гэх мэт санхүүгийн хөрөнгийг гэрээний нөхцөл нь шинэ зээл шиг болж өөрчлөгдөхөд үл хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд эдгээр хөрөнгийн хувьд зөрүүг нь үл хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзаар бүртгэнэ. Шинээр хүлээн зөвшөөрсөн зээл нь үнэ цэнэ буурсан зээлийг худалдаж авсан нөхцөлд биш бол уг зээл нь зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал тооцоолох үүднээс 1-р шатлалд ангилагдана.

Санхүүгийн хөрөнгө. Банк санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төстэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсэг) тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан үед үл хүлээн зөвшөөрнө. Мөн Банк нь хөрөнгийг шилжүүлсэн бөгөөд шилжүүлэлт нь үл хүлээн зөвшөөрөх шаардлагыг хангаж байгаа нөхцөлд хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (санхүүгийн хөрөнгийн хэсэг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгийн хэсэг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн, эсвэл
- “Дамжуулан өнгөрөөх” хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн.

“Дамжуулан өнгөрөөх” хэлцэл нь Банк тухайн санхүүгийн хөрөнгөөс хүлээх гэрээний эрхээ хадгалж үлдэх бөгөөд (анхны хөрөнгө) доорх гурван нөхцөл биелж буй тохиолдолд гэрээний үүргийн дагуу тэдгээр хүлээн авсан мөнгөн урсгалыг нэг болон түүнээс дээш байгууллагад (эцсийн хүлээн авагчид) шилжүүлнэ:

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

- Хэрэв тухайн нэг байгууллагын зээлдүүлсэн дүн дээр зах зээлийн хүүгээр хуримтлагдсан хүүтэй хамт бүрэн төлөх эрхтэй богино хугацаат урьдчилгааг оруулалгүйгээр Банк нь эцсийн хүлээн авагчид анхны хөрөнгө нь дүйцэх хэмжээний мөнгөн урсгалыг цуглуулаагүй цагт ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй болно;
- Банк нь эцсийн хүлээн авагчдаас үнэт цааснаас бусад нөхцөлөөр анхны хөрөнгийг зарах эсвэл барьцаалж болохгүй;

Банк нь эцсийн хүлээн авагчдын өмнөөс цуглуулсан мөнгөн урсгалыг удаан хугацаагаар саатуулалгүйгээр шилжүүлэх үүрэгтэй. Үүнээс гадна, Банк нь тэдгээр мөнгөн урсгалыг, цуглуулсан өдрөөс шаардлагатай гуйвуулгын өдөр хүргэлх мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө оруулалт хийхээс бусдаар дахин хөрөнгө оруулалт хийх эрхгүй. Шилжүүлгийг зөвхөн доорх нөхцөлүүдийг хангасан тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө:

- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй болон хадгалж үлдээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Хэрвээ шилжүүлэгч холбогдолгүй гуравдагч этгээдэд хөрөнгийг бүхэлд нь зарах болон шилжүүлэхэд нэмэлт хязгаарлалтгүйгээр тухайн чадварыг эзэмшдэг гэж үзсэн үед Банк хяналтыг шилжүүлсэн гэж үзнэ.

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл “дамжуулан өнгөрөөх” хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

Хэрэв шилжүүлсэн хөрөнгөд үргэлжилсэн оролцоо бичгээр эсвэл худалдан авах опцион (эсвэл аль аль нь) хэлбэрээр байвал, Банкны үргэлжилсэн оролцоо нь эргүүлэн худалдан авахад төлөх шаардлагатай дүнгээр хэмжигдэнэ. Хөрөнгөд бичгээр худалдан авах опцион заасан байгууллагын үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ болон нөхцөлийн хэрэгжих үнийн аль багаар хязгаарлагдана.

Санхүүгийн өр төлбөр. Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч алгатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Санхүүгийн өр төлбөрийн анхны бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон зээлүүд. Банк заримдаа барьцаа хөрөнгийг хураах гэхээсээ илүү зээлдэгчийн санхүүгийн хүндрэлийн улмаас зээлийн анхны нөхцөлд хөнгөлөлт, өөрчлөлт оруулдаг. Зээлдэгчийн одоогийн эсвэл хүлээгдэж буй санхүүгийн хүндрэлээс үүдэн хөнгөлөлт, өөрчлөлтийг хийсэн ба зээлдэгч санхүүгийн хувьд хэвийн байсан бол Банк энэхүү хөнгөлөлт, өөрчлөлтийг зөвшөөрөхгүй байх байсан тохиолдолд уг зээлийг Банк өөрчлөлттэй зээл гэж үзнэ. Санхүүгийн хүндрэлийг илтгэлцүүрт гэрээний нөхцлийг зөрчих эсвэл Зээлийн Эрсдэлийн хэлтсээс гаргасан үзүүлэлтүүд хамаарна. Энэхүү өөрчлөлтүүдэд төлбөрийн хугацааг сунгах, зээлийн шинэ нөхцөлийг зөвшөөрөх зэрэг орно. Банк нь нөхцөл өөрчилсөн зээлүүдийг хянаж ирээдүйн төлөлтийг хэвийн байлгах бодлого баримталдаг.

Хэрэв ихээхэн өөрчлөлттэй бол зээлийг үл хүлээн зөвшөөрнө. Зээлийг үл хүлээн зөвшөөрөхгүйгээр, зээлийн нөхцөлийг дахин авч хэлэлцсэний дараа нөхцөл өөрчлөхөөс өмнө тооцсон анхны үр ашигт хүүгээр үнэ цэнийн бууралтыг тооцдог. Түүнчлэн Банк нь зээлийн эрсдэл ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн эсэх, цаашлаад тухайн хөрөнгийг Шатлал 3 руу ангилах хэрэгтэй эсэхийг үнэлдэг. Зээлийг үл хүлээн зөвшөөрөх болон Шатлал 2 ба Шатлал 3 руу ангилах шийдвэрийг зээл тус бүрээр үнэлнэ. Хэрвээ үнэлэх явцад зээлтэй холбоотой алдагдал хүлээхээр байгаа бол уг зээлийг төлүүлэх эсвэл данснаас хасах хүртэл Шатлал 3-ын зээл гэж толилууулж, удирдана.

Нөхцөл өөрчилсөн актив гэж ангилагдсан харилцагч уг ангиллаас гарахын тулд дараах бүх шалгуурыг хангасан байх шаардлагатай:

- Бүх зээлүүд нь хэвийн байх ёстой;
- Шинэчилсэн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу хамгийн багадаа зургаан сарын хугацаанд тогтмол төлбөр хийсэн байх
- Үйлчлүүлэгч хугацаа нь 30 хоногоос хэтэрсэн ямар ч гэрээ байгуулаагүй байх

Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн талаарх мэдээллийг 30-р тодруулгад тусгасан болно.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)****Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг цэвэршүүлэх**

Ирээдүйн үйл явдлаас хамааралгүйгээр хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй ба доорх бүх нөхцөлд цэвэр дүнгээр нь барагдуулах хандлагатай байгаа үед санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнг санхүүгийн байдлын тайланд толилуулна. Санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрийг СТОУС-ын цэвэршүүлэх шалгуурыг хангасан тохиолдлоос бусад тохиолдолд санхүүгийн байдлын тайланд тусад нь тусгадаг.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

“Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)” аргын ерөнхий ойлголт. Банк “санхүүгийн хэрэглүүр” ангилалд хамаарах зээлийн үүрэг болон санхүүгийн баталгаа, бодит үнэ цэнийн өөрчлөлт ашиг, алдагдлын тайланд бүртгэгдээгүй бусад өрийн хэрэглүүр болон бүх зээлд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын сан байгуулсан. СТОУС-9-н дагуу өмчийн хэрэглүүр нь үнэ цэнийн бууралтад орохгүй.

Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал нь хөрөнгийн ашиглалтын нийт хугацаанд үүсэх зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Хэрвээ анх бүртгэснээс алдагдал нь мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн бол алдагдал нь 12 сарын хүлээгдэж буй алдагдлаас хамаарна. Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өөрчлөгдсөнийг хэмжих Банкны бодлого журмыг тодруулга 30-д тусгасан.

Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА аргын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэгслийн чанаргүйдлийн магадлалын үр дүнгээр ЗҮЦХА-г илэрхийлнэ. Санхүүгийн хэрэгслийн үндсэн багцаас шалтгаалан нийт хугацааны ЗҮЦХА болон ирээдүйн 12 сарын ЗҮЦХА-г тусгай болон бүлгийн үнэлгээгээр тооцоолно. Банк нь бүлэг санхүүгийн хөрөнгийг бүлгийн үнэлгээний аргаар хэмжинэ.

Банк нь үнэлгээ хийх журмыг тодорхойлсон бөгөөд тайлант үеийн эцэс бүрт санхүүгийн хэрэгслийн үлдэх хугацаанд үүсч болох эрсдэлийн өөрчлөлтийг харгалзан санхүүгийн хэрэгслийг анх бүртгэснээс хойш ЗҮЦХА-д мэдэгдэхүйц өссөн эсхийг харгалзан авч үзнэ.

Дээр дурдсан процесс дээр тулгуурлан, доор дурдсанаар Банк зээлийг шатлал 1, шатлал 2, шатлал 3 гэж ангилсан:

Шатлал 1: Зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед Банк нь 12 сарын ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 1-рүү үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 2-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 2: Анх хүлээн зөвшөөрсөн үеэс зээлийн үүсч болох эрсдэл ихэссэн үед Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-г бүртгэнэ. Мөн шатлал 2-руу үүсч болох эрсдэл нь буурсан шатлал 3-ын зээлүүд дахин ангилагдана.

Шатлал 3: Үнэ цэнийн бууралтад орсон зээлүүд багтана. Банк нь нийт хугацааны турш ЗҮЦХА-г бүртгэнэ.

Банк нь санхүүгийн хөрөнгийг төлөгдөх нийт дүн эсвэл зарим хэсгийг төлөгдөх боломжгүй гэж үзвэл санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулна. Үүнийг санхүүгийн хөрөнгийн (хэсэгчилсэн) үл хүлээн зөвшөөрөлт гэнэ.

ЗҮЦХА тооцоолол. Банк нь магадлалын-жигнэсэн гурван хувилбарыг үр ашигт хүүгээр хорогдуулсан хүлээгдэж буй мөнгөний дутагдлаар ЗҮЦХА-г тооцоолдог. Мөнгөний дутагдал нь гэрээний дагуух мөнгөн гүйлгээ болон эргэн төлөгдөхөөр хүлээгдэж буй мөнгөн гүйлгээний зөрүү юм.

ЗҮЦХА тооцооллын механизм болон гол элементийн хамт доор үзүүлэв:

Чанаргүйдлийн магадлал (ЧМ): ЧМ нь өгөгдсөн цаг хугацаанд төлбөрийн чадваргүй болох магадлалаар тооцоолно. Хэрвээ хэрэгсэл нь өмнө нь үл хүлээн зөвшөөрч байгаагүй мөн харгалзах багцад үргэлжлүүлэн байгаа бол үнэлсэн хугацааны тодорхой хугацаанд нэг удаа алдагдал үүсэх боломжтой.

Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД): ЧӨД нь тайлагналын дараах зээлийн хүлээгдэж буй өөрчлөлт, гэрээний дагуух үндсэн төлбөр болон хүүний эргэн төлөлт, зээлийн үүргийн хүрээнд нэмж олгосон дүн болон төлбөр хоцорсноор үүссэн хуримтлагдсан хүүг харгалзсан, ирээдүйн ЧӨД-ийн тооцоолдог.

Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ) Алдагдал хүргэх чанаргүйдэл гэдэг нь өгөгдсөн цаг хугацааны туршид чанаргүйдлийн үеийн алдагдлын тооцоолол юм. Энэ нь гэрээний дагуу мөнгөн урсгал болон зээлдэгч хүлээн авахаар тооцоолсон дүн, барьцаа хөрөнгө борлуулсан дүнгийн нийлбэрийн зөрүүнээс тооцно.

ЗҮЦХА-г тооцохдоо Банк гурван хувилбарыг авч үздэг (суурь, эерэг болон сөрөг) ба хувилбар тус бүрийн ЧМ, ЧӨД болон АХЧ нь ялгаатай байна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)**2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)****Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)**

ЗҮЦХА-г ЧМ, ЧӨД, АХЧ-г ирээдүйн сар бүр болон тусгайлсан эсвэл бүлгийн сегмент бүрээр төсөвлөн тодорхойлдог. Эдгээр гурван үндсэн бүрэлдэхүүнийг хооронд нь үржүүлэн, цаашид эдгээр нь хэвээр үйлчлэх магадлалаар мөн тохируулна (тухайлбал, чанаргүйдэлд өртөх дүн нь ойрын саруудад урьдчилан төлөгдөхгүй эсвэл чанаргүйдэхгүй).

Үнэ цэнийн бууралтын зардал болон буцаалт нь санхүүгийн хөрөнгийн дансны үнийн өөрчлөлтийн ашиг, алдагдлын тохируулгаас тусдаа бүртгэгдэх болон толилуулагдана.

ЗҮЦХА-ын тооцооллын аргыг доор хураангуйлав:

Шатлал 1:	Ирээдүйн 12 сарын ЗҮЦХА нь нийт хугацааны ЗҮЦХА загварын нэг хэсэг байх бөгөөд тайлагналын өдрийн дараах 12 сард санхүүгийн хэрэгслийн чанаргүйдлийн үр дүнгээр ЗҮЦХА-ыг илэрхийлнэ. Банк нь ирээдүйн 12 сарын ЗҮЦХА тайлагналын өдрөөс хойш 12 сарын дотор ЧМ-д үндэслэн тооцдог. ЧӨД-ийн урьдчилсан төсөөлөлд 12 сарын дотор хүлээгдэж буй ЧМ-ыг хэрэглэх бөгөөд хүлээгдэж буй АХЧ-аар үржүүлэгдэж анхны үр ашигт хүүтэй ойролцоо дүнгээр хорогдуулна.
Шатлал 2:	Зээлийг анх олгосноос хойш тухайн зээлд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлттэй байгаа нь тогтоогдсон зээлүүдэд Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ын сан байгуулан бүртгэнэ. Санг байгуулахдаа хэд хэдэн хувилбарууд дээр үндэслэн тооцоолох боловч ЧМ болон АХЧ-ыг нь нийт хугацаанд тооцоолж гаргана. Хүлээгдэж буй мөнгөний дутагдлыг үр ашигт хүүтэй ойролцоо хувиар хорогдуулна.
Шатлал 3:	Үнэ цэнэ буурсан гэж үзсэн зээлийн хувьд, Банк нь нийт хугацааны ЗҮЦХА-ыг бүртгэнэ. Энэ аргачлал нь Шатлал 2-г ашигласантай ижил аргачлалаар тооцогдох бөгөөд ЧМ-ыг 100% гэж үзнэ.
Худалдаж авсан болон үүссэн үнэ цэнийн бууралт (“ХАҮҮЦБ”)	ХАҮҮЦБ хөрөнгө анх хүлээн зөвшөөрөх үед үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө юм. Банк нь зөвхөн анх хүлээн зөвшөөрсөн үеэс хойшхи магадлалаар жигнэсэн гурван хувилбарыг зээлээр тохируулсан үр ашигт хүүгээр хорогдуулсан хуримтлагдсан нийт хугацааны ЗҮЦХА-г хүлээн зөвшөөрнө.
Зээлийн үүрэг болон аккредитив	Зээлийн үүрэгт нийт хугацааны ЗҮЦХА тооцохдоо, Банк нь ирээдүйн олгогдох зээлийн үүргийн дүнг тооцоолно. Зээл олгогдох тохиолдолд ЗҮЦХА нь магадлалаар жигнэсэн гурван хувилбараар хүлээгдэж буй мөнгөний дутагдлын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно. Хүлээгдэж буй мөнгөний дутагдал нь хүлээгдэж буй үр ашигт хүүгээр хорогдуулсан байна. (Зээл болон үүргийг агуулсан зээлийн картын хувьд, ЗҮЦХА-г зээлтэй нь хамт тооцон, толилуулна.) Зээлийн үүрэг болон аккредитивын хувьд, ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө.
Санхүүгийн баталгааны гэрээнүүд	Банкны санхүүгийн баталгаа тус бүрийн үүрэг нь анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн хуримтлагдсан хорогдол хассан дүн болон ЗҮЦХА сангийн аль ихээр нь хэмжигдэнэ. Банк нь ЗҮЦХА-г эзэмшигчид нөхөн олгох дүнгийн өнөөгийн үнэ цэнэ дээр үндэслэн тооцно. Эрсдэлээр тохируулсан хүүгээр дутагдлыг хорогдуулна. Тооцоолол нь магадлалын жигнэсэн гурван хувилбар дээр хийгдэнэ. Санхүүгийн баталгааны ЗҮЦХА нь бусад өглөгт хүлээн зөвшөөрөгдөнө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх өрийн хэрэглүүр. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн ЗҮЦХА нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй бөгөөд бодит үнэ цэнэ нь хэвээр үлдэнэ. Үүний оронд, хэрвээ хөрөнгө нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн байсан бол үүсэх үнэ цэнийн бууралтыг бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хуримтлагдсан үнэ цэнийн бууралт гэж бүртгэх ба үр дүнг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ. Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдсэн хуримтлагдсан алдагдлыг хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед ашиг, алдагдлын тайланд шилжүүлэн бүртгэнэ.

Кредит карт ба бусад зээлийн шугамууд. Банк харилцагчдадаа төрөл бүрийн байгууллагын болон иргэдийн овердрафт, зээлийн картын бүтээгдэхүүн санал болгодог ба Банк нэг өдрийн өмнө мэдэгдэл өгч уг хэрэгслийг цуцлах, эсвэл зээлийн эрхийн хэмжээг бууруулах эрхтэй. Банк зээлийн алдагдлын эрсдэлийг гэрээний мэдэгдлийн хугацаагаар хязгаарладаггүй бөгөөд харин үйлчлүүлэгчдийн зан төлөв, чанаргүй болох магадлал болон цаашдын эрсдэлийг бууруулах арга аргачлалууд болох зээлийг цуцлах, зээлийн хэмжээг бууруулах гэх мэт зүйлсийг тусгасан байдаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Кредит карт ба бусад зээлийн шугамууд (үргэлжлэл)

Эдгээр бүтээгдэхүүнүүдийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн эсэх талаарх үнэлгээ нь зээлийн бусад бүтээгдэхүүнүүдийн үнэлгээтэй адил юм. Үнэлгээ нь харилцагчдын дотоод зээлжих зэрэглэлийн өөрчлөлтөд суурилсан боловч тухайн хэрэгслийн хэрэглээний өөрчлөлт гэх мэт чанарын хүчин зүйлсэд мөн томоохон ач холбогдлыг өгдөг.

Зээлийн карт болон овердрафтын ЗҮЦХА-г дискаунтлахад ашиглах хүүний хувь нь тухайн бүтээгдэхүүнүүдийн нийт ашиглагдах хугацаанд тооцогдох жилийн дундаж үр ашигт хүү байна. Энэхүү тооцоо нь олон зээл сар бүр бүрэн төлөгдөж, дараа сараасаа хүү тооцохгүй байхаар хийгдсэн.

Ирээдүйн мэдээлэл. ЗҮЦХА-ын загвартаа Банк нь доорх эдийн засгийн өгөгдлүүдийг ирээдүйн мэдээлэл болгон ашигладаг. Үүнд:

- Дотоодын нийт бүтээгдэхүүн (“ДНБ”)
- Ам.долларын ханшийн төсөөлөл
- Мөнгөний нийлүүлэлт
- Хэрэглээний үнийн индекс
- Ажилгүйдлийн түвшин

ЗҮЦХА-ын тооцоололд ашиглаж буй энэхүү мэдээлэл нь санхүүгийн тайлангийн өдрөөрх зах зээлийн бүх шинж чанаруудыг агуулаагүй байх магадлалтай. Үүний нөлөөг тооцоололд тусгахын тулд зарим тохиолдолд, чанарын тохируулгууд болон давхцалуудын зөрүү материаллаг үед түр тохируулга хийдэг.

Зээлийн сайжруулалт: Барьцаа хөрөнгийн үнэлгээ болон санхүүгийн баталгаа. Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийг бууруулах үүднээс, Банк барьцаа хөрөнгө авдаг. Барьцаа хөрөнгө нь төрөл бүрийн хэлбэрээр байдаг, жишээ нь: мөнгөн хөрөнгө, үнэт цаас, аккредитив болон баталгаа, үл хөдлөх хөрөнгө, авлага, бараа материал, бусад санхүүгийн бус хөрөнгө болон үр дүнгийн тооцооны гэрээ байна. Барьцаа хөрөнгийг эзэмшээгүй тохиолдолд Банкны санхүүгийн байдлын тайланд бүртгэхгүй. Зээлийн сайжруулалтаас хүлээгдэж буй мөнгөн гүйлгээг, СТОУС-ын дагуу тусад нь хүлээн зөвшөөрөх шаардлагагүй бөгөөд өр төлбөрийн хэрэгслийн гэрээний нөхцөлүүдийн салшгүй хэсэг гэж тооцогддог ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын хэмжилтэд оруулдаг. Үүний үндсэн дээр барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ нь үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд нөлөөлдөг. Барьцаа хөрөнгийг ерөнхийд нь хамгийн багадаа анх хүлээн зөвшөөрөхдөө болон хагас жилийн хугацаанд дахин үнэлдэг.

Банк нь барьцаа хөрөнгийн зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгийг үнэлэхдээ боломжит идэвхтэй зах зээлийн мэдээллийг ашигладаг. Идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй бусад санхүүгийн хөрөнгийг үнэлгээний арга ашиглан үнэлдэг. Санхүүгийн бус барьцаа хөрөнгийг (жишээ нь: үл хөдлөх хөрөнгө) ипотекийн зуучлагч буюу гуравдагч этгээдээс ирсэн мэдээлэлд эсвэл орон сууцны үнийн индексүүдэд үндэслэн үнэлнэ.

Баталгаа нь зээлийн гэрээний нөхцөлд тусгагдсан эсвэл зээлийн салшгүй хэсэг болох ба зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцоонд хамрагдсан болно.

Зээлийн гэрээний нөхцөлтэй холбоогүй баталгааг балансын гадуурх зүйл ангид салангид үзүүлэх бөгөөд үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын тооцооллыг хийдэг.

Хураан авсан барьцаа хөрөнгө

Хураан авсан барьцаа хөрөнгийг уг хөрөнгийг хураан авсан өдрөөрх холбогдох зээлийн дансны үнэ болон бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан дүнгийн аль багаар анхлан хүлээн зөвшөөрдөг. Дараагийн тайлант үеүдэд, хураан авсан барьцаа хөрөнгийг өртөг болон бодит үнэ цэнээс түүний борлуулахтай холбоотой гарах зардлыг хассан дүнгийн аль багаар бүртгэдэг ба эдгээр хөрөнгүүд нь тайланд бусад хөрөнгө хэсэгт тайлагнагддаг.

Банк нь дотоод бодлогынхоо дагуу хураан авсан барьцаа хөрөнгийг дотоод үйл ажиллагаандаа ашиглах эсвэл борлуулах зорилгоор эзэмшихээ тодорхойлдог. Дотоод үйл ажиллагаанд ашиглахаар тодорхойлогдсон хөрөнгүүдийг харгалзах хөрөнгийн ангилалд шилжүүлдэг. Хөрөнгийг борлуулах нь илүү ашигтай байхаар тодорхойлсон хөрөнгийг "Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө" рүү шилжүүлдэг. Бусад зорилгыг нь хараахан шийдээгүй хөрөнгүүд нь энэ дансандаа хэвээр бүртгэгдэнэ.

Борлуулах зорилготой хөрөнгө

Борлуулах зорилготой хөрөнгийг дансны үнэ болон бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассаны аль багаар бүртгэнэ. Хураан авсан хөрөнгийн дансны үнийг борлуулах замаар нөхөх бол уг хөрөнгийг борлуулах зорилготой хөрөнгөд ангилна.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

Борлуулах зорилготой хөрөнгө (үргэлжлэл)

Борлуулах зорилготой хөрөнгөд одоогийн нөхцөл байдлыг нь өөрчлөлгүйгээр ердийн нөхцлөөр худалдан борлуулах боломжтой байх ба хөрөнгийг борлуулах магадлал өндөр буюу удирдлага худалдан борлуулахаар төлөвлөж байгаа, мөн бүртгэснээс хойш нэг жилийн дотор зарагдах магадлалтай хөрөнгүүдийг хамруулна.

Данснаас хасах. Банк нь хөрөнгийн эргэн төлөлтийг зогсоосон үед санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн данснаас хасна. Хэрвээ данснаас хасах үнэ хуримтлагдсан алдагдлаас их тохиолдолд, зөрүүгээр нь алдагдлыг нэмэгдүүлж дараа нь дансны нийт үнийн дүнг бууруулна. Дараах үеийн эргэн төлөлтүүд нь зээлийн алдагдлын зардлыг бууруулна.

Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайланд зааснаар бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь мөнгө, Монголбанк дахь хязгаарлалтгүй харилцах данс, Засгийн газрын үнэт цаас болон бусад Банкин дахь харилцах ба 3 сар түүнээс бага хугацаатай хадгаламжууд орно.

Төв Банкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдэл. Монголбанкинд байршуулсан, заавал байлгах нөөцийн үлдэгдлийг хорогдуулсан өртгөөр бүртгэх бөгөөд Банкны өдөр тутмын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглах боломжгүй, заавал байлгах нөөцийн хүүгүй хадгаламж тул үүнийг мөнгөн гүйлгээний тайлан дахь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд оруулахгүй.

Буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл (“репо”)-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгөө хөрөнгөөр, репо хэлцлийн хуримтлагдсан хүүг өр төлбөрөөр тус тус тусгах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна. Нөгөө тал нь үнэт цаасыг худалдах эсвэл дахин барьцаалах эрхтэй бол, Банк нь тухайн үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайландаа борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө эсвэл борлуулахад бэлэн барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө оруулалтын аль тохиромжтой ангилалд үлдээнэ.

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл (“урвуу репо”)-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгөө хуримтлуулсан хүүний хамт тайлан тэнцэлд “Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөний барьцаа” гэж тусгах ба энэ нь Банкнаас авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг “Хүү болон түүнтэй адилтгах орлого” гэж бүртгэх ба үр ашигт хүүний аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Түрээс

Банк нь гэрээ байгуулагдах үед түрээсийн шинж чанар агуулсан эсэхийг үнэлдэг. Өөрөөр хэлбэл гэрээнд тодорхойлогдож байгаа хөрөнгийг хэсэг хугацааны турш ашиглан хянах эрхийг шилжүүлсэн болно.

Банк – Түрээслэгч. Банк нь богино хугацаатай түрээс эсвэл бага өртөгтэй хөрөнгийг түрээслэхээс бусад тохиолдолд бүх түрээсийг хүлээн зөвшөөрөх, хэмжих нэг аргыг ашигладаг. Банк нь түрээсийг төлөх түрээсийн өр төлбөрийг болон хөрөнгийг ашиглах эрхийг хүлээн зөвшөөрдөг.

Ашиглах эрхтэй хөрөнгө. Банк нь ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрдөг (жишээлбэл, үндсэн хөрөнгийг ашиглах боломжтой болсон өдөр). Ашиглах эрхтэй хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтын алдагдлыг хасаж өртгөөр нь хэмжиж, түрээсийн өр төлбөрийг дахин үнэлэхэд тохируулна. Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт түрээсийн өр төлбөр, хүлээн авсан түрээсийн эхний өртөг, түрээсийн урамшууллыг авалгүйгээр эхлэхээс өмнө хийсэн түрээсийн төлбөрүүд орно. Ашиглах эрхтэй хөрөнгийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Ашиглах эрхтэй хөрөнгөд үнэ цэнийн бууралт тооцно.

Түрээсийн өр төлбөр. Түрээсийн эхлэх өдөр Банк нь түрээсийн нийт хугацааны туршид хийгдэх түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнээр хэмжсэн түрээсийн өглөгийг хүлээн зөвшөөрнө. Түрээсийн төлбөрт тогтмол төлбөр (түрээсийн урамшууллыг аваагүй), индекс эсвэл хувь хэмжээнээс хамааран хувьсах түрээсийн төлбөрүүд, үлдэгдэл үнийн баталгааны дагуу төлөх хүлээгдэж буй төлбөрүүд орно. Индекс эсвэл хувь хэмжээнээс хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрнө.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Түрээс (үргэлжлэл)

Түрээсийн хүүний хэмжээг тодорхойлох боломжгүй тохиолдолд Банк нь түрээс эхлэх үеийн зээлийн өсөн нэмэгдэх хүүг ашиглан түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийнг тооцоолно. Түрээс эхэлсэн өдрөөс хойш түрээсийн өр төлбөрийг хуримтлагдсан хүүгээр нэмэгдүүлж, төлсөн түрээсийн төлбөрөөр бууруулдаг.

Мөн түүнчлэн түрээсийн хугацаанд өөрчлөлт оруулах, тогтмол төлбөрийн шинж чанарт өөрчлөлт оруулах эсвэл уг хөрөнгийг худалдаж авах үнэлгээнд өөрчлөлт оруулах зэрэг өөрчлөлтүүд гарсан тохиолдолд түрээсийн өр төлбөрийн дүнг дахин тооцоолно.

Богино хугацаат түрээс. Банк нь зарим богино хугацааны оффисын түрээсийн (12 сар болон түүнээс бага хугацаатай түрээс эсвэл эсвэл АТМ-ийн талбайн түрээс гэх мэт) хувьд хүлээн зөвшөөрөлтийн чөлөөлтийг ашигласан. Богино хугацаат түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар зардалд хүлээн зөвшөөрнө.

Түрээсийн гэрээг шинэчлэх, цуцлах сонголт бүхий түрээсийн гэрээний хугацааг тодорхойлох. Банк нь түрээсийн үл цуцлагдах хугацааг тодорхойлохдоо тухайн түрээсийг үргэлжлүүлэн түрээслэх нь тодорхой үндэслэлтэй гэж үзсэн тохиолдолд сунгагдах хугацаа эсвэл тухайн үргэлжлүүлэн түрээслэх нь үндэслэлгүй гэж үзсэн тохиолдолд цуцлах хугацааг оруулна тооцно. Банк нь тухайн түрээсийн гэрээг дахин сунгагдах үндэслэлийг тодорхойлоход тодорхой үнэлэмжийг ашиглана. Өөрөөр хэлбэл тухайн түрээсийг сунгах эсвэл цуцлах сонголтыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх эдийн засгийн хөшүүргийг бий болгох бүхий л хүчин зүйлийг авч үзнэ. Түрээс эхэлсэн өдрөөс хойш Банкны өөрийн хянаж чадах үйл явдал, нөхцөл байдалд болон сунгах (эсвэл цуцлах) сонголтыг хэрэгжүүлэх чадварт өөрчлөлт орсон тохиолдолд түрээсийн хугацааг дахин үнэлнэ.

Банк нь салбарын үйл ажиллагаанд нь өндөр ач холбогдолтой түрээсийн талбайн сунгах хугацааг түрээслэх хугацааны нэг хэсэг болгон шинэчилсэн хугацааг оруулсан.

Үндсэн хөрөнгө

Барилга болон газраас бусад үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртгийг тухай бүрт нь энэ өртөгт оруулна. Үндсэн хөрөнгийн томоохон хэсгийг үе шаттайгаар солих шаардлагатай болсон үед Банк нь ийм хэсгүүдийг тусдаа ашиглалтын хугацаа, элэгдэлтэй бие даасан хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Үүнтэй адил, үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан бол үндсэн хяналт хийх үед түүний өртгийг үндсэн хөрөнгийн бүртгэлийн дүнд оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгүүд нь хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тухайн хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцно:

<u>Хөрөнгө</u>	<u>Ашиглалтын хугацаа</u>
Барилга	25
Оффисын тавилга болон тээврийн хэрэгсэл	10
Компьютер болон бусад	2 – 10

Үндсэн хөрөнгө ба түүний томоохон хэсгүүдийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед данснаас хасна. Үүнтэй холбоотойгоор үүссэн аливаа нэг олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөд компьютерын программ хангамж орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай байх хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа тайлант жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө. Биет бус хөрөнгийн өртгийг 3-10 жилийн ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна.

Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Банк нь эргэлтийн бус хөрөнгийн дансны үнэ нь тухайн хөрөнгийг ашигласнаар бус борлуулснаар орж ирэх мөнгөн урсгалаас нөхөгдөхөөр байгаа тохиолдолд борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгө руу шилжүүлдэг. Борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгийг түүний дансны үнэ ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүнгийн аль багаар хэмжинэ. Борлуулалтын зардал нь тухайн хөрөнгийг борлуулахтай шууд холбогдон гарсан зардлаас холбогдох санхүүгийн болон орлогын албан татварын зардлыг хассан дүнтэй тэнцүү байна.

Хөрөнгийг зөвхөн тухайн нөхцөлд богино хугацаанд борлуулах боломжтой буюу өндөр магадлалтай байгаа тохиолдолд борлуулах зориулалттай үл хөдлөх хөрөнгөөр ангилна. Шаардагдах борлуулалтын үйл ажиллагаа нь борлуулалтад мэдэгдэхүйц өөрчлөлт бий болгох эсвэл борлуулалтыг зогсоох нөлөөгүй байх шаардлагатай. Удирдлагаас тухайн хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө руу ангилах шийдвэр гаргаснаас хойш нэг жилийн хугацаанд борлуулалтыг бүрэн хийж дуусгахаар төлөвлөнө.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараах бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад үзүүлэлтүүдээр эдгээр тооцооллыг хэмжиж болно.

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгийн үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Ажиллагсдын тэтгэмж

Богино хугацаат тэтгэмж. Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

Заавал төлөх даатгалын шимтгэлүүд. Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь ашиг, алдагдлын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Нөөц

Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед нөөцийг хүлээн зөвшөөрнө. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ материаллаг нөлөөтэй байх үед Банк нь тухайн өглөгтэй холбогдох хүүний түвшинг татварын өмнөх түвшинд тохируулж дискаунтлах замаар нөөцийн хэмжээг тодорхойлно. Аливаа нэг нөөцтэй холбоотой зардлыг ашиг, алдагдлаар аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь бусад үйл ажиллагааны зардалд толилуулна.

Татвар

Тайлант хугацааны орлогын албан татвар. Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар Банкны үйл ажиллагаагаа явуулж буй улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Эздийн өмч ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн зүйлтэй холбоотой тайлант хугацааны орлогын албан татвар нь ашиг алдагдлын тайланд бус эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тухайлан хүлээн зөвшөөрөгдөнө. Удирдлага нь татварын тайланд тусгасан өөрийн байр суурийг үе үе үнэлж, тайлбар тодруулга шаардлагатай холбогдох татварын зохицуулалтыг харгалзан үздэг.

Хойшлуулсан татвар. Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүүний буцаалт нь ойрын ирээдүйд арилахгүй ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлалгүй байгаа бол

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Өөрийн хөрөнгөнд шууд хүлээн зөвшөөрсөн зүйлүүдтэй холбоотой тайлант жилийн болон хойшлуулсан татваруудыг мөн өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрөх ба ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөхгүй. Тухайн татварууд нь ирээдүйд холбогдох гарз олзын хамт ашиг алдагдлын тайлан руу бүртгэгдэнэ. Түүнчлэн өөрийн хөрөнгөд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр гаргахтай холбоотой гарсан зардал болон төлбөрийн татварыг бүртгэнэ.

Банк нь цэвэршүүлсэн дүнгээр барагдуулахаар төлөвлөж байгаа үед болон хуулийн дагуу уг эрх нь үүссэн үед хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнана.

Сегментийн тайлан

Үйл ажиллагааны сегментийг, гишүүд нь нөөцийг хуваарилах, үйл ажиллагааны сегментүүдийн гүйцэтгэлийг үнэлэх үүрэгтэй гүйцэтгэх удирдлагын хороонд өгсөн дотоод тайлагналын дагуу тайлагнадаг.

Өөрийн хөрөнгө ба энгийн хувьцаанд ногдох ногдол ашиг

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөд ангилна. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гарсан гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөгт зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гаднын нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй (үргэлжлэл)

Өөрийн хөрөнгө ба энгийн хувьцаанд ногдох ногдол ашиг(үргэлжлэл)

Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ба Банкны хувьцаа эзэмшигчид баталсан үед өөрийн хөрөнгөөс хасна. Хугацааны дундуурх ногдол ашгийг зарласан, Банк буцаах аргагүй болсон үед өөрийн хөрөнгөөс хасна.

Бусад нөөц сан

Бусад нөөц сан нь бодит үнэ цэнийн нөөц болон зохицуулагч байгууллагын журмын сангаас бүрдэнэ. Бодит үнэ цэнийн нөөц нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд ангилагдсан өрийн хэрэгслийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлт, хүлээгдэж буй алдагдлыг хассан дүнгээр, өмчийн хэрэгслийн бодит үнийн хуримтлагдсан цэвэр өөрчлөлтөөс бүрдэнэ.

Тусгай зориулалттай нөөц нь зээлийн болон хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санг Монголбанкны журам болон СТОУС-ын дагуу тооцоолоход үүссэн зөрүүг илэрхийлдэг. Энэхүү нөөц нь өмчийн бусад хэсэгт бүртгэгдсэн бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилагдана.

Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашгийг тайлант хугацааны туршид гаргасан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

Хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашиг дээр аливаа гатварын нөлөөллийг оруулсан хөрвөгч давуу эрхтэй хувьцаа болон хөрвөгч бонд (хорогдуулагч үнэт цаас)-ын хүүг нэмж, уг дүнгээ хэрвээ хорогдуулагч үнэт цааснуудыг бүгдийг нь хөрвүүлсэн тохиолдолд нэмж гаргах байсан энгийн хувьцааны тоог оруулсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

Холбоотой талын ажил гүйлгээ

а. Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуйн нэгж болон хувь хүн орно. Үүнд: Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- (i) Банкинд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Банкинд томоохон нөлөөлөлтэй эсвэл;
- (iii) Банкны гол удирдах албан тушаалтнуудын нэг.

б. Дараах нөхцөлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуйн нэгж нь Банкинд хамааралтай болно. Үүнд:

- (i) Аж ахуйн нэгж болон Банкны нэг ижил Группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- (ii) Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуйн нэгж нь гишүүн болох Банкны хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- (iii) Аль аль аж ахуйн нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд.
- (iv) Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани.
- (v) Аж ахуйн нэгж нь Банкны эсвэл Банктай холбоотой аж ахуйн нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Банктай холбоотой тал болно.
- (vi) Аж ахуйн нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.
- (vii)(a)(i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуйн нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуйн нэгжийн (эсвэл аж ахуйн нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.
- (viii) Аж ахуйн нэгж нь эсвэл Банкны аль нэг гишүүн эсвэл Банкны толгой компанид гол удирдах албан тушаалтай.

Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудад тодруулсан бөгөөд дэлгэрэнгүйг тодруулга 32-с харна уу.

2.6. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь санхүүгийн тайлангийн өдрийн байдлаарх орлого, зардал, хөрөнгө ба өр төлбөр дээр үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөлөл хийх ба тэдгээрийн дагалдах тодруулгууд болон болзошгүй өр төлбөр дээр тодруулга хийхийг удирдлагаас шаарддаг. Эдгээр тооцоолол, төсөөллүүдийн тодорхойгүй байдал нь ирээдүйд хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг залруулга хийхэд хүргэж болно.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого (үргэлжлэл)

2.6. Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол болон төсөөллүүд (үргэлжлэл)

Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэх явцдаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо тайлагналын өдрөөр хөрөнгө өр төлбөрийн дансны үнэд дараагийн санхүүгийн жилд ноцтой материаллаг залруулга орж болохуйц ирээдүйн болон бусад чухал эх үүсвэрээс гарч болохуйц тооцооллын тодорхой бус байдлыг харгалзан үзэж дараах үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг хэрэглэдэг.

Ирээдүйн хөгжлийн талаарх одоо байгаа нөхцөл байдал, таамаглал нь Банкны хяналтаас гадуур нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болох ба хэзээ болох тухай таамаглалд тусгагдсан байдаг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн дүн, удирдлагын нягт нямбай үнэлгээтэй хамгийн их нөлөө үзүүлсэн зүйлсийг холбогдох шүүмж / тооцоотой харьцуулж дор харуулав.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход Банкны удирдлагын үнэлэмж шаардагддаг ялангуяа ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон хугацаа, барьцаа хөрөнгийн үнэлгээг тодорхойлох шаардлагатай байдаг. Эдгээр тооцоолол нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөх бөгөөд эдгээрийн өөрчлөлт нь өөр өөр түвшний үнэ цэнийн бууралтын сан байгуулахад хүргэдэг.

Банкны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын (ЗҮЦХА) тооцоолол нь хувьсах өгөгдөл болон тэдгээрийн харилцан хамаарлыг сонгоход ашигласан олон төсөөллүүдээс бүрдсэн цогц загварын үр дүн юм. ЗҮЦХА загварын элементүүд нь доорх нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж болон тооцооллыг шингээсэн байна:

- Тус тусын үнэлгээ бүрт ашиглах чанаргүйдлийн магадлалыг (ЧМ) тодорхойлдог Банкны дотоод зээлийн үнэлгээний систем
- Банкны санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр ихэссэн байна гэж үнэлэх шалгуур үзүүлэлтүүд болон санхүүгийн хөрөнгүүдийн нөөц санг нийт хугацааны ЗҮЦХА болон чанарын үнэлгээ ашиглан тооцно
- ЗҮЦХА нь бүлгийн үнэлгээгээр тооцоологддог бол санхүүгийн хөрөнгийн сегментчлэл
- Өгөгдлүүдийн сонголт болон томъёонуудыг ашиглан ЗҮЦХА загварыг хөгжүүлэх
- Дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляци, бодлогын хүү, гадаад валютын ханш болон ажилгүйдлийн түвшин зэрэг макро эдийн засгийн өгөгдлүүдийн харилцан холбоо хамаарлыг тодорхойлох болон эдгээрийн чанаргүйдлийн магадал (ЧМ), чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД), алдагдалд хүргэх чанаргүйдэлд (АХЧ) үзүүлэх нөлөө зэрэг
- ЗҮЦХА загварт ирээдүйг чиглэсэн макро эдийн засгийн хувилбаруудаас сонгох, тэдгээрийн жигнэсэн дундаж магадлалыг тодорхойлох, эдийн засгийн өгөгдлүүдийг гаргах

Банк нь бодит алдагдал хүлээсэн дүн дээрээ үндэслэн өөрийн загварыг жил бүр үнэлэж, шаардлагатай бол залруулж байх журамтай.

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг хэмжилтийн өдрөөрх идэвхтэй зах зээл дээрх үнээр хэмжиж чадахгүй бол бодит үнэ цэнийг дискаунтлагдсан мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн үнэлгээний аргыг ашиглан хэмжиж болно. Энэхүү үнэлгээний загварт ашигласан орцуудыг ажиглаж болохуйц идэвхтэй зах зээлийн мэдээллээс олж авсан ба тэдгээр нь нийцтэй биш тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тодорхой түвшний үнэлэмжийг авч ашигласан. Ашигласан төсөөллүүдийн өөрчлөлтүүд нь тайлагнасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэд нөлөөлж болно. Дэлгэрэнгүй толилуулгыг Тодруулга 31-ээс харна уу.

3. Сегментийн тайлан

Үйл ажиллагааны сегментүүд нь орлого олох эсвэл зардал гаргах боломжтой бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг бүрэлдэхүүн хэсгүүд бөгөөд үйл ажиллагааны үр дүнг нь үйл ажиллагааны шийдвэр гаргагч тогтмол хянаж байдаг бөгөөд санхүүгийн салангид мэдээллүүдтэй байдаг. Үйл ажиллагааны шийдвэр гаргагч нь Банкны гүйцэтгэх удирдлагын хорооны гишүүд юм. Үйл ажиллагааны шийдвэр гаргагчийн чиг үүргийг Банкны Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэдэг.

Банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээнд суурилсан бизнесийн хоёр үндсэн сегментийг дараах байдлаар хуваадаг:

- *Иргэдийн банк*: Хувийн банкны үйлчилгээ, харилцагчийн хувийн харилцах, хадгаламж, кредит болон дебит карт, хэрэглээний зээл, жижиг дунд бизнесийн зээл, ипотекийн зээл зэрэг үйлчилгээнүүд орно.

3. Сегментийн тайлан (үргэлжлэл)

- *Хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа:* Зээл авах, үүсмэл санхүүгийн хэрэгслийн эрсдэлийн удирдлагын зорилгоор ашиглах, богино хугацаат байршуулалт, компанийн болон Засгийн газрын өрийн бичиг үнэт цаас зэрэгт хөрөнгө оруулах замаар Банкны санхүүжилт, эрсдэлийн төвлөрсөн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үйл ажиллагаа нь Банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа юм.

Банкны үйл ажиллагаа нь Монгол Улсад байрладаг тул газарзүйн сегментийн талаар нэмэлт мэдээлэл байхгүй. Аливаа харилцагч болон хамтрагч байгууллагуудтай хийсэн гүйлгээний орлого нь 2022 болон 2021 онд Банкны нийт орлогын 10 ба түүнээс дээш хувийг эзэлдэггүй байна.

2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх	Иргэдийн банк мян. төг	Хөрөнгө удирдлага мян. төг	Нийт мян. төг
Үр ашигт хүүний аргаар тооцоолсон хүүний орлого	32,588,581	11,600,200	44,188,781
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	642,160	780,562	1,422,722
Үр ашигт хүүний аргаар тооцоолсон хүүний зардал	(9,728,149)	(6,530,319)	(16,258,468)
Хүүний цэвэр орлого	23,502,592	5,850,443	29,353,035
Шимтгэл ба хураамжийн орлого	2,121,638	–	2,121,638
Шимтгэл ба хураамжийн зардал	(602,073)	–	(602,073)
Шимтгэл ба хураамжийн цэвэр орлого	1,519,565	–	1,519,565
Арилжааны цэвэр орлого	–	2,044,326	2,044,326
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	(329,427)	(188,428)	(517,855)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөс олсон цэвэр орлого	–	(450,586)	(450,586)
Бусад үйл ажиллагааны орлого	6,730	1,664,793	1,671,523
Үйл ажиллагааны цэвэр орлого/(зардал)	(322,697)	3,070,105	2,747,408
Боловсон хүчний зардал	(3,908,133)	(1,520,103)	(5,428,236)
Үндсэн хөрөнгө болон ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	(1,696,718)	(39,767)	(1,736,485)
Биет бус хөрөнгийн хорогдуулга	(445,303)	(9,088)	(454,391)
Бусад үйл ажиллагааны зардал	(4,052,784)	(722,032)	(4,774,816)
Нийт үйл ажиллагааны зардал	(10,102,938)	(2,290,990)	(12,393,928)
Татварын өмнөх сегментийн ашиг	14,596,522	6,629,558	21,226,080
Орлогын албан татварын зардал			(2,169,603)
Тайлант жилийн ашиг			19,056,477
Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгөнд нэмэгдсэн	3,064,327	–	3,064,327
Биет бус хөрөнгөнд нэмэгдсэн	530,396	–	530,396
Нийт хөрөнгө	287,193,390	191,190,121	478,383,511
Нийт өр төлбөр	(252,275,572)	(109,487,861)	(361,763,433)

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

3. Сегментийн тайлан (үргэлжлэл)

2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх	Иргэдийн банк мян. төг	Хөрөнгө удирдлага мян. төг	Нийт мян. төг
Үр ашигт хүүний аргаар тооцоолсон хүүний орлого	20,246,842	5,780,387	26,027,229
Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого	487,591	193,605	681,196
Үр ашигт хүүний аргаар тооцоолсон хүүний зардал	(8,942,932)	(2,228,001)	(11,170,933)
Хүүний цэвэр орлого	11,791,501	3,745,991	15,537,492
Шимтгэл ба хураамжийн орлого	1,337,388	–	1,337,388
Шимтгэл ба хураамжийн зардал	(493,389)	–	(493,389)
Шимтгэл ба хураамжийн цэвэр орлого	843,999	–	843,999
Арилжааны цэвэр орлого	–	4,289,583	4,289,583
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал	(381,130)	(117,038)	(498,168)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөс олсон цэвэр орлого	–	533,247	533,247
Бусад үйл ажиллагааны орлого	1,721,499	26,454	1,747,953
Үйл ажиллагааны цэвэр орлого	1,340,369	4,732,246	6,072,615
Боловсон хүчний зардал	(3,438,731)	(534,599)	(3,973,330)
Үндсэн хөрөнгө болон ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	(1,333,530)	(16,869)	(1,350,399)
Биет бус хөрөнгийн хорогдуулга	(144,555)	(2,201)	(146,756)
Бусад үйл ажиллагааны зардал	(4,449,494)	(50,170)	(4,499,664)
Нийт үйл ажиллагааны зардал	(9,366,310)	(603,839)	(9,970,149)
Татварын өмнөх сегментийн ашиг	4,609,559	7,874,398	12,483,957
Орлогын албан татварын зардал			(1,702,975)
Тайлант жилийн ашиг			10,780,982
Үндсэн хөрөнгө, ашиглах эрхтэй хөрөнгөнд нэмэгдсэн	2,728,354	–	2,728,354
Биет бус хөрөнгөнд нэмэгдсэн	195,552	–	195,552
Нийт хөрөнгө	160,376,919	169,485,539	329,862,458
Нийт өр төлбөр	(145,314,872)	(82,750,924)	(228,065,796)

4. Хүү болон түүнтэй адилтгах орлого

	2022 MNT'000	2021 MNT'000
<i>Үр ашигт хүүний аргачлалаар тооцоолсон хүүний орлого</i>		
Хорогдуулсан өртгөөр бүртгэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	32,588,581	20,246,842
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэгсэл	7,900,251	4,765,479
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	1,047,046	664,688
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр	1,793,601	123,603
Урвуу репо хэлцэл	760,902	257,174
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	98,400	63,877
	44,188,781	26,121,663
<i>Бусад хүү болон түүнтэй адилтгах орлого</i>		
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр	780,562	203,852
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	642,160	382,910
	1,422,722	586,762
	45,611,503	26,708,425

5. Хүү болон түүнтэй адилтгах зардал

	2022 мян.төг	2021 мян.төг
<i>Үр ашигт хүүний аргаар тооцсон хүүний зардал</i>		
Харилцагчдын харилцах, хадгаламж	9,728,149	8,459,533
Репо хэлцэл	5,247,206	1,908,036
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	410,595	293,920
Түрээсийн өр төлбөрийн хүүний зардал (Тод. 21)	437,697	358,686
Зээлээр авсан эх үүсвэр	378,565	–
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	56,256	21,582
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэгсэл	–	129,176
	16,258,468	11,170,933

6. Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого

	2022 мян.төг	2021 мян.төг
<i>Тодорхой хугацааны туршид үзүүлэх үйлчилгээнээс олсон шимтгэлийн орлого</i>		
Картын үйлчилгээний шимтгэл хураамж	44,202	34,722
Дансны үйлчилгээний шимтгэл хураамж	107,139	73,678
Санхүүгийн баталгааны шимтгэлийн орлого	888,722	833,209
	1,040,063	941,609
<i>Тухайн удаадаа гүйцэтгэгдсэн санхүүгийн үйлчилгээнээс олсон шимтгэлийн орлого</i>		
Картын үйлчилгээний шимтгэл хураамж	560,055	218,876
Дансны үйлчилгээний шимтгэл хураамж	217,415	139,305
Мөнгөн гуйвуулга үйлчилгээний орлого	304,105	37,598
	1,081,575	395,779
Хураамж шимтгэлийн зардал		
Картын гүйлгээний хураамж	(245,678)	(195,906)
Бусад шимтгэлийн зардал	(356,395)	(297,483)
	(602,073)	(493,389)
Нийт	1,519,565	843,999

7. Арилжааны цэвэр орлого

	2022 мян.төг	2021 мян.төг
Өрийн үнэт цаас борлуулсны олз/(гарз), цэвэр	410,963	(41,825)
Ногдол ашиг (Тод.15)	67,298	97,900
Өмчийн үнэт цаас борлуулсны олз, цэвэр	9,775	4,047,554
Гадаад валютын арилжааны цэвэр орлого	1,556,291	185,954
	2,044,326	4,289,583

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

8. Үйл ажиллагааны бусад орлого

	2022	2021
	мян.төг	мян.төг
Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	(450,586)	533,247
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	414,007	–
Гадаад валютын арилжааны бус олз/(гарз)	1,224,476	(71,445)
Үндсэн хөрөнгө борлуулсны олз/(гарз) (Тод.20)	(7,551)	47,822
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны олз	–	1,568,755
Борлуулах зориулалттай хөрөнгө борлуулсны олз	–	6,000
Ковид-19 холбоотой үнийн хөнгөлөлт (Тод.21)	–	66,651
Түрээсийн нөхцөл өөрчилсний олз (Тод.21)	–	64,644
Бусад	40,590	65,526
	1,220,937	2,281,200

9. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн зардал/(буцаалт)

	2022	2021
	мян.төг	мян.төг
<i>Тайлант хугацааны цэвэр үнэ цэнийн бууралтын зардал/(буцаалт):</i>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Тод. 13)	(10,555)	10,384
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж (Тод. 14)	1,898	(1,806)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр (Тод. 15)	72,750	(6,972)
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр (Тод. 15)	124,335	122,466
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тод. 17)	325,930	381,130
Бусад хөрөнгө (Тод. 18)	(16,480)	(9,161)
Тэнцлийн гадуурх үүрэг (Тод. 29)	19,977	2,127
	517,855	498,168

10. Үйл ажиллагааны зардал

	2022	2021
	мян.төг	мян.төг
Цалин хөлс ба урамшуулал	5,428,236	3,973,330
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	1,264,440	1,589,025
Маркетинг, зар сурталчилгааны зардал	1,044,673	578,825
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тод. 20)	911,032	637,311
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл (Тод. 21)	825,453	568,609
Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тод. 22)	454,391	146,756
Засварын зардал	385,203	668,577
Даатгалын зардал	288,163	223,478
Бизнесийн томилолтын зардал	116,000	25,148
Түрээсийн зардал	112,751	90,402
Харуул, хамгаалалтын зардал	80,179	58,282
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тод. 20)	13,367	10,453
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн элэгдэл	–	162,638
Бусад үйл ажиллагааны зардал	1,470,038	1,237,315
	12,393,928	9,970,149

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

11. Орлогын албан татвар

11.1 Орлогын албан татварын зардал

2022 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн орлогын албан татварын зардлын бүрэлдэхүүнд:

	2022	2021
	мян.төг	мян.төг
Тайлант жилийн орлогын албан татвар	<u>2,169,603</u>	<u>1,702,975</u>

Банк нь санхүүгийн тайланд орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Банк 6 тэрбум төгрөг (2021: 6 тэрбум төгрөг) хүртэл ашгаас 10% (2021 онд 10%)-ийн, 6 тэрбумаас дээш төгрөгийн (2021 онд 6 тэрбум төгрөг) ашгаас 25% (2021 онд 25%) -ийн орлогын албан татвар төлдөг. Засгийн газрын бондын хүүний орлогод орлогын татвар тооцохгүй.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг банкинд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 2022 оны 12 дугаар сарын 31-нээр хэрхэн тохируулсныг дараах байдлаар үзүүлэв. Үүнд:

	2022	2021
	мян.төг	мян.төг
Татварын өмнөх ашиг	21,226,080	12,483,957
25%-ийн орлогын албан татвар (2021 онд 25%)	5,306,520	3,120,989
Татвараас чөлөөлөгдөх орлогын нөлөө	(174,881)	(121,748)
Татвар ногдуулахгүй орлогын нөлөө	(310,239)	(562,410)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөө	225,461	256,840
Татварын бага хувь хэмжээ ба татварын шатлалд хамаарах орлогын нөлөө	(2,877,259)	(990,696)
	<u>2,169,603</u>	<u>1,702,975</u>

2022 онд ногдох үр ашигт татварын хувь хэмжээ нь 10.22% (2021: 13.64%) байсан.

11.2 Орлогын албан татварын өр төлбөр

	2022	2021
	мян.төг	мян.төг
1 сарын 1-нээрх орлогын татварын өглөг	909,940	136,454
Тайлант жилийн орлогын татварын зардал	2,169,603	1,702,975
Төлсөн татвар	(1,866,258)	(929,489)
12 сарын 31-нээрх орлогын татварын өглөг	<u>1,213,285</u>	<u>909,940</u>

12. Нэгж хувьцаанд ногдох ашиг

	2022	2021
	мян.төг	мян.төг
Энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах ашиг	<u>19,056,477</u>	<u>10,780,982</u>
	2022	2021
	мян.ширхэг	мян.ширхэг
Нэгж хувьцаанд ногдох энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	<u>1,250,000,000</u>	<u>1,020,833,333</u>

12. Нэгж хувьцаанд ногдох ашиг (үргэлжлэл)

Нэгж хувьцаанд ногдох ашиг

	2022	2021
	мян.төг	мян.төг
Тухайн тайлангийн хугацаанд Банкны хувьцаа эзэмшигчид:		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	15.2	10.6
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	15.2	10.6

Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг нь цэвэр ашгийг тухайн жилийн гүйлгээнд байсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваан тооцоолж (Тод. 28), тайлагналын хугацааны дараах үеийн хувьцааны хуваагдлын нөлөөгөөр тохируулагдсан (Тод. 35).

13. Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах

	2022	2021
	мян.төг	мян.төг
Бэлэн мөнгө	3,008,601	2,600,324
Монголбанк дахь харилцах	24,333,797	9,487,301
Монголбанк дахь хадгаламж	8,004,822	–
Монголбанкны үнэт цаас	67,463,996	84,267,052
Дансны үнэ	102,811,216	96,354,677
Хасах нь: Үнэ цэнийн бууралтын сан	(2,762)	(24,472)
Цэвэр дансны үнэ	102,808,454	96,330,205
Монголбанкинд заавал байлгах нөөц	25,180,284	9,982,932
Хасах нь: Монголбанкны зайлшгүй байлгах нөөцийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(12,828)	(1,673)
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцахын цэвэр дүн	127,975,910	106,311,464

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах нөөцийн үлдэгдэл нь (2) долоо хоногийн татан төвлөрүүлсэн дотоодын валютын харилцах хадгаламжийн дундаж үлдэгдлийн 8% (2021: 6%)-аас багагүй ба гадаад валютын харилцах хадгаламжийн дундаж үлдэгдлийн 18% (2021: 18%)-аас багагүй байдаг. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах нөөцийн хэмжээ төгрөгөөр 9,609,565 мян.төг (2021: 6,932,927 мян.төг) ба гадаад валютаар 15,570,719 мян.төг (2021: 3,050,005 мян.төг) байсан.

Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгөний заавал байлгах нөөцийн үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд жилийн эцсийн ангилал болон Банкны дотоод зээлийн үнэлгээний систем дээр үндэслэсэн бэлэн мөнгө ороогүйгээр зээлийн чанар, зээлийн эрсдэлийн хамгийн их хэмжээг харуулав. Оруулсан дүн нь ЗҮЦХА -ын нийт нөөц юм. Банкны дотоод үнэлгээний систем, үнэ цэнийн бууралтын үнэлгээ ба хэмжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 30-д тайлбарласан болно.

		ЧӨД	ЗҮЦХА
	Дотоодын	Шатлал 1	Шатлал 1
	үнэлгээ	мян.төг	мян.төг
2022 оны 12 сарын 31	В	124,982,899	15,590
2021 оны 12 сарын 31	В	103,737,285	26,145

2022 болон 2021 оны 12 сарын 31-нээрх дансны үнэ болон ЗҮЦХА-н сангийн тохируулгыг доорх хүснэгтээс харна уу:

	2022	2021
	мян.төг	мян.төг
Монголбанкинд байршуулсан бэлэн мөнгөний заавал байлгах нөөцийн үнэ цэнийн бууралтын сан		
1 дүгээр сарын 1-нээр	26,145	15,761
Тайлант жилд байгуулсан/(буцаалт) (Тод. 9)	(10,555)	10,384
12 дугаар сарын 31-нээр	15,590	26,145

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

13. Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах (үргэлжлэл)

13.1 Нэмэлт мөнгөн урсгалын мэдээлэл

	2022	2021
	мян.төг	мян.төг
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах (Тод. 13)	102,811,216	96,354,677
Гурван сараас бага хугацаатай бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж (Тод. 14)	51,245,566	26,423,416
	154,056,782	122,778,093
Хасах нь: Репо хэлцэлд бэлэн мөнгөний барьцаанд байршуулсан үнэт цаас (Тод. 24)	(62,000,000)	(40,211,000)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр дүн	92,056,782	82,567,093

14. Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж

	2022	2021
	мян.төг	мян.төг
Дотоодын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	44,998,977	25,038,731
Гадаадын банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	6,246,589	1,384,685
Дансны дүн	51,245,566	26,423,416
Хасах: Үнэ цэнийн бууралтын сан	(3,653)	(1,755)
	51,241,913	26,421,661

Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж нь дотоодын болон гадаадын санхүүгийн байгууллага дахь дотоод болон гадаад валютаар илэрхийлэгдсэн харилцах болон хадгаламжийн дансуудыг хэлнэ.

Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд жилийн эцсийн ангилал болон Банкны дотоод зээлийн үнэлгээний систем дээр үндэслэсэн бэлэн мөнгө ороогүйгээр зээлийн чанар, зээлийн эрсдэлийн хамгийн их хэмжээг харуулав. Оруулсан дүн нь ЗҮЦХА-ын нийт нөөц юм. Банкны дотоод үнэлгээний систем, үнэ цэнийн бууралтын үнэлгээ ба хэмжилтийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 30-д тайлбарласан болно.

	Дотоодын	ЧӨД	ЗҮЦХА
	үнэлгээ	Шатлал 1	Шатлал 1
		мян.төг	мян.төг
2022 оны 12 сарын 31	В	51,245,566	3,653
2021 оны 12 сарын 31	В	26,423,416	1,755

2022, 2021 оны 12 сарын 31-нээрх ЗҮЦХА-н сангийн тохируулгыг доорх хүснэгтээс харна уу:

	2022	2021
	мян.төг	мян.төг
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжийн үнэ цэнийн бууралтын сан		
1 дүгээр сарын 1-нээр	1,755	3,561
Тайлант жилд байгуулсан/(буцаалт) (Тод. 9)	1,898	(1,806)
12 дугаар сарын 31-нээр	3,653	1,755

15. Санхүүгийн хөрөнгө оруулалт

	2022 мян.төг	2021 мян.төг
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
Ипотекийн зээлээр баталгаажсан давуу эрхтэй бонд ("ИЗББ") (а)	5,625,571	4,859,458
Ипотекийн зээлээр баталгаажсан энгийн бонд ("ИЗББ") (а)	2,299,382	967,532
Хөрөнгөөр баталгаажсан энгийн үнэт цаас (ХБҮЦ) (ж)	2,940,544	340,354
	10,865,497	6,167,344
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
Төв банкны үнэт цаас (б)	2,669,627	–
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бонд (в)	5,149,809	9,853,400
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компанийн бонд (д)	6,960,036	6,225,454
	14,779,472	16,078,854
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бонд (в)	19,407,715	–
Хөрөнгөөр баталгаажсан давуу эрхтэй үнэт цаас (ХБҮЦ)(ж)	4,206,603	2,339,387
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй компанийн бонд (г)	9,103,247	2,139,554
Хасах: Үнэ цэнийн бууралтын сан	(244,389)	(114,837)
	32,473,176	4,364,104
Урвуу репо хэлцэл		
Урвуу репонд төлсөн мөнгөн төлбөр	6,767,166	4,387,457
Хасах: Үнэ цэнийн бууралтын сан	(2,412)	(7,629)
	6,764,754	4,379,828
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өмчийн хэрэглүүр (е)	2,800,000	3,300,000
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр		
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй өмчийн хэрэглүүр (ё)	1,942,564	2,379,656
	1,942,564	2,379,656
	69,625,463	36,669,786

- а. Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасанд ("ИЗББ") Монголын Ипотекийн Корпораци Холдинг ХК ("МИК") -ийн зуун хувийн өмчит компаниудын гаргасан энгийн болон давуу эрхтэй хүүтэй, урт хугацаат үнэт цаас орно. Банк нь МИК-т тогтмол хүүтэй орон сууцны зээлийг зарж, ИЗББ -ийг хариу төлбөрт нь авсан.
- б. Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй Монголбанкны үнэт цаасыг нэрлэсэн үнээр, урамшуулал эсвэл хөнгөлөлттэй үнээр худалдаж авдаг.
- в. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бонд нь олон улсын зах зээлд бүртгэлтэй гадаадын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үнэт цаас юм.
- г. Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй бонд нь Булл Капитал ББСБ, Шинэ Уул Вэте ХХК, Тосон Энержи ХХК, МИГ Даатгал ХХК, ЖН Беврижс ХХК-аас гаргасан хүүтэй, богино хугацаат үнэт цаас юм. 2021 оны 12 сарын 31-ний байдлаар Богд Лизинг ХХК, БИД ББСБ-аас гаргасан хүүтэй, богино хугацаат өрийн хэрэгслийг эзэмшиж байсан.
- д. Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй бонд нь МИК -ийн гадаадын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт юм.
- е. Банк нь Бодь Цамхаг ХХК-ийн 8.045% хувьцаанд хөрөнгө оруулсан бөгөөд СТОУС 9 -ийн дагуу тус хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэгслийн санд бүртгэгдсэн болно.

15. Санхүүгийн хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

- ё. Хөрөнгийн биржид бүртгэлтэй өмчийн хэрэглүүрүүд нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй байгууллагад оруулсан хөрөнгө оруулалт юм. Уг хөрөнгө оруулалтад Ард менежмент ҮЦК, Мандал ассет менежмент ҮЦК, Бодь Даатгал ХК-ийн өмчийн үнэт цаас ордог. 2022 онд Бодь даатгал ХК-д оруулсан хөрөнгө оруулалтаас 67,298 мян.төг-ийн (2021: 97,900 мян.төг) ногдол ашиг хүлээж авсан (Тод.7).
- ж. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасанд (ХБҮЦ) Үнэт Цаасны Санхүүжилтийн Корпораци ХХК (ҮЦСК)-ийн зуун хувийн өмчит компаниудын гаргасан энгийн болон давуу эрхтэй хүүтэй, урт хугацаат үнэт цаас орно. Банк нь ҮЦСК-д тогтмол хүүтэй орон сууцны зээл шилжүүлэн, ХБҮЦ-ийг хариу төлбөрт нь авсан.

Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоод зээлийн үнэлгээний систем болон жилийн эцсийн шатлалын ангилал дээр үндэслэсэн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх болон хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг зээлийн эрсдэл ба үнэ цэнийн бууралтын сангийн хамт харуулав. Өрийн хэрэгслүүдийн дотоод зээлийн үнэлгээ нь В- эс В+ зэрэглэлтэй бөгөөд шатлал 1-д ангилагдана. Банкны дотоод үнэлгээний систем, үнэ цэнийн бууралтын хэмжилтийн талаарх мэдээллийг Тодруулга 30-д тайлбарласан.

	2022	2021
	мян.төг	мян.төг
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр		
Дансны цэвэр дүн		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	16,078,854	15,240,586
Нэмэгдсэн/худалдан авсан	39,547,568	49,203,967
Бодит үнэ цэнийн өөрчлөлт (Тод. 28)	(5,103,045)	(454,961)
Төлөгдсөн эсвэл дуусгавар болсон	(36,546,271)	(47,903,622)
Гадаад валютын ханшийн зөрүү	802,366	(7,116)
12 сарын 31-ний өдрийн байдлаар	14,779,472	16,078,854
ЗҮЦХА сан		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	58,100	65,072
Нэмэгдсэн/худалдан авсан	134,271	115,858
ЗҮЦХА-ын тооцооллын өгөгдөлд оруулсан өөрчлөлтүүд	(3,421)	5,799
Хугацаа дууссан/ төлөгдсөн	(58,100)	(128,629)
Тайлант жилийн цэвэр зардал/(буцаалт) (Тод. 9)	72,750	(6,972)
12 сарын 31-ний өдрийн байдлаар	130,850	58,100
Цэвэр санхүүгийн хөрөнгө оруулалт	14,648,622	16,020,754
	2022	2021
	мян.төг	мян.төг
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр		
Дансны үнэ		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	4,478,941	–
Нэмэгдсэн/ худалдан авсан	36,965,613	5,816,495
Төлөгдсөн эсвэл дуусгавар болсон	(8,873,454)	(1,337,610)
Гадаад валютын ханшийн зөрүү	146,465	56
12 сарын 31-ний өдрийн байдлаар	32,717,565	4,478,941
ЗҮЦХА сан		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	114,837	–
Нэмэгдсэн / худалдан авсан	156,123	149,131
ЗҮЦХА-ын тооцооллын өгөгдөлд оруулсан өөрчлөлтүүд	(26,571)	(34,294)
Тайлант жилийн цэвэр зардал (Тод. 9)	129,552	114,837
12 сарын 31-ний өдрийн байдлаар	244,389	114,837
Цэвэр санхүүгийн хөрөнгө оруулалт	32,473,176	4,364,104

15. Санхүүгийн хөрөнгө оруулалт (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

	2022	2021
	мян.төг	мян.төг
Урвуу репо хэлцэл		
Дансны үнэ		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	4,387,457	–
Нэмэгдсэн/ худалдан авсан	6,673,730	5,188,800
Төлөгдсөн эсвэл дуусгавар болсон	(4,387,457)	(801,188)
Гадаад валютын ханшийн зөрүү	93,436	(155)
12 сарын 31-ний өдрийн байдлаар	<u>6,767,166</u>	<u>4,387,457</u>
ЗҮЦХА сан		
1 сарын 1-ний өдрийн байдлаар	7,629	–
Нэмэгдсэн/ худалдан авсан	2,412	9,022
Төлөгдсөн эсвэл дуусгавар болсон	(7,629)	(1,393)
Тайлант жилийн цэвэр зардал/(буцаалт) (Тод. 9)	<u>(5,217)</u>	<u>7,629</u>
12 сарын 31-ний өдрийн байдлаар	<u>2,412</u>	<u>7,629</u>
Цэвэр санхүүгийн хөрөнгө оруулалт	<u>6,764,754</u>	<u>4,379,828</u>

16. Үүсмэл санхүүгийн хэрэглүүр

Доорх хүснэгтэд хөрөнгө болон өр төлбөрт бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамтаар харууллаа. Нэрлэсэн үнэ нь үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсхүл индекс байх бөгөөд үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь тайлант жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсхүл зээлийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

	Нэрлэсэн үнэ	Бодит үнэ цэнэ	
	мян.төг	Хөрөнгө мян.төг	Өр төлбөр мян.төг
2022 оны 12 сарын 31-нээр			
МБ-тай хийсэн урт хугацаат своп хэлцэл (а)	13,778,400	433,677	(42,448)
Форвард хэлцэл (б)	1,755,161	–	(19,670)
	<u>15,533,561</u>	<u>433,677</u>	<u>(62,118)</u>

а) Банк нь Монголбанктай урт хугацаат своп хэлцэл хийсэн. Банк нь анх Монголбанкинд ам.долларын санхүүжилт төлж, спот ханшаар тооцон төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Монголбанктай байгуулсан гэрээний хугацаанд, Банк нь ам.долларын санхүүжилтэд SOFR болон бусад тохируулагч нэмсэн хүүг хүлээн авах ба төгрөгийн санхүүжилтэд төв банкны репо хүүтэй тэнцүү хувиар тооцсон хүү төлнө. Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд анхны гүйлгээний валютын ханшийн зөрүүгээр үндсэн төлбөрийг солилцоно.

б) 2022 оны 11 болон 12-р саруудад банк Нэт Капитал ББСБ-тай валют арилжих 12 сарын хугацаатай форвард хэлцэл хийсэн. Гэрээний дагуу Банк форвард ханшаар ам.доллар зарна.

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2022	2021
	мян.төг	мян.төг
Бизнесийн зээл	132,784,117	104,681,839
Орон сууцны зээл	17,065,686	12,318,228
Хэрэглээний зээл	53,441,097	23,130,141
	<u>203,290,900</u>	<u>140,130,208</u>
Үнэ цэнийн бууралтын сан	(2,819,242)	(2,493,312)
Хорогдуулсан өртгөөр бүртгэх харилцагчдад олгосон зээл	<u>200,471,658</u>	<u>137,636,896</u>
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх зээл ба урьдчилгаа	8,133,535	10,274,021
Нийт харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	<u>208,605,193</u>	<u>147,910,917</u>

Нийт дүнгээр нь үл хүлээн зөвшөөрч шилжүүлсэн хөрөнгүүд

Орон сууцны зээлийн багцын борлуулалт

Банк нь тайлант жилд (2022 оны 8 ба 12 дугаар саруудад) тогтмол хүүтэй орон сууцны барьцаат зээлийн багцаас орж ирэх мөнгөн урсгалыг авах 100% эрхийг МИК Холдинг ХК-ийн эзэмшлийн тусгай зориулалтын компаниудтай ИЗББ-оор сольсон. Банк нь санхүүгийн тайланд зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрсөн ба давуу эрхтэй болон энгийн ИЗББ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн (Тод.15). Банк шилжүүлсэн хөрөнгөд үргэлжлүүлэн оролцож шилжүүлсэн хөрөнгийн хугацаа дуустал үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх ба улирал тутам үнийн дүнгийн 2.5%-ийн үйлчилгээний шимтгэл авдаг. 2022 онд 35.317 мян.төг-ийн (2021: 20,302 мян.төг) шимтгэлийн орлого хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ нь нийт хураамж ба шимтгэлийн орлогод багтсан. Тусгай зориулалтын компаниуд татан буугдах магадлал багатай ч татан буугдсан тохиолдолд Банк нь үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгүүдийг эргүүлэн худалдах үүрэг хүлээх магадлалтай. 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар буцаан худалдаж авч болзошгүй үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн дискаунтлагүй мөнгөн урсгал нь 19,286 сая төгрөг (2021: 13,398 сая төгрөг) байна.

Бизнесийн зээлийн багцын борлуулалт

2021 оны 2-р сарын 20-д Монгол улсын Засгийн Газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” 10 их наядын цогц төлөвлөгөөг боловсруулсан. Хөтөлбөр нь жижиг дунд бизнесүүд (ЖДҮ), орон сууцжуулалт, стратегийн ач холбогдол бүхий төсөл хөтөлбөрүүд, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, боловсролын хүртээмжийг дэмжих 5 хэсгээс бүрдсэн бөгөөд 2023 он хүртэл үргэлжлэх төлөвтэй байна. Эдгээрээс ЖДҮ-г дэмжих хөтөлбөр 2021 оны 3-р сараас, хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөр 2021 оны 5-р сараас эхэлсэн.

Банк нь ЖДҮ-ийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд ҮЦСК-ийн 100%-ийн өмчит тусгай зориулалтын компаниудтай үнэт цаасжуулалтын хөтөлбөрт оролцож, ЖДҮ-ийн зээлийн багцыг худалдсан. Хөтөлбөрийн хүрээнд Банк нийт 5,110 сая төгрөгийн (2021: 18,530 сая.төг), жилийн 10.5%-ийн хүүтэй, 2-3 жилийн хугацаатай ЖДҮ-ийн зээлийг харилцагчиддаа олгож, хариу төлбөрт ХБҮЦ хүлээн авсан. Ерөнхий репо санхүүжилтийн гэрээний 2022 оны 11 сарын 28-ны өдрийн өөрчлөлтийн дагуу банк нь ҮЦСК-д чанаргүй зээлийг солих үүрэг хүлээхгүй бөгөөд ҮЦСК-д хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн болно. Эдгээр гүйлгээний хүрээнд ҮЦСК-д худалдсан зээлтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг Банк өөртөө үлдээгээгүй. Иймд Банк зээлийн багцыг үл хүлээн зөвшөөрч, жилийн 9.5%-ийн хүүтэй, 3 хүртэлх жилийн хугацаатай давуу болон энгийн эрхтэй ХБҮЦ-ыг санхүүгийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 15-ийг харна үү).

Банк нь шилжүүлсэн хөрөнгүүдийн хувьд үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх байдлаар үргэлжлүүлэн оролцож байгаа бөгөөд улирал тутам үйлчилгээний үнийн дүнгийн 0.5%-ийг үйлчилгээний шимтгэл болгон авдаг. 2022 онд хүлээн зөвшөөрөгдсөн үйлчилгээний нийт төлбөр хураамж 55,319 мянган төгрөг (2021: 3,795 мян.төг) ба энэ нь хураамж ба шимтгэлийн орлогод багтсан. Тусгай зориулалтын компаниуд татан буугдах магадлал багатай ч татан буугдсан тохиолдолд Банк нь үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгүүдийг эргүүлэн худалдах үүрэг хүлээх магадлалтай. 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар буцаан худалдаж авч болзошгүй үл хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн дискаунтлагүй мөнгөн урсгал нь 3,340 сая.төг (2021: 0 төгрөг) байна.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Банк нь МИК-д зарагдах 3,948,751 мян.төг-ийн (2021: 10,274,021 мян.төг) орон сууцны зээлийн багц мөн ҮЦСК-д зарагдах 4,184,784 мян.төг-ийн бизнесийн зээлийн багцуудыг эзэмшдэг.

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоодын зээлийн үнэлгээний систем, жилийн эцсийн ангилал дээр тулгуурлаж зээлийн чанарыг багц болон сангийн хөдөлгөөнөөр илэрхийлж харуулсан болно. Үүнд үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй бодит хэмжээг тусгасан болно. Банкны дотоод үнэлгээний систем, ЗҮЦХА-ыг тусгай болон бүлгийн үнэлгээгээр хэрхэн үнэлэх талаар тодруулга 30-д дэлгэрэнгүй тайлбарласан.

	Бизнесийн зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Хэрэглээ- ний зээл мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12-р сарын 31				
2022 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх зээлийн нийт дүн	104,681,839	12,318,228	23,130,141	140,130,208
Шинээр олгосон	98,255,878	8,438,893	48,418,909	155,113,680
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(70,153,600)	(3,691,435)	(18,107,953)	(91,952,988)
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	132,784,117	17,065,686	53,441,097	203,290,900
2022 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	951,386	595,471	946,455	2,493,312
Шинээр олгосон	403,486	38,042	575,246	1,016,774
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(202,106)	(120,644)	(552,641)	(875,391)
ЗҮЦХА-н шатлал шилжилтийн нөлөө	470,382	(244,168)	(41,667)	184,547
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт) (Тод. 9)	671,762	(326,770)	(19,062)	325,930
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	1,623,148	268,701	927,393	2,819,242
2021 оны 12-р сарын 31				
2021 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх зээлийн нийт дүн	75,019,174	7,498,465	14,569,824	97,087,463
Шинээр олгосон	81,316,132	7,390,134	19,334,761	108,041,027
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(51,653,467)	(2,570,371)	(10,774,444)	(64,998,282)
2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	104,681,839	12,318,228	23,130,141	140,130,208
2021 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаарх ЗҮЦХА-ын сан	1,092,775	421,728	597,679	2,112,182
Шинээр олгосон	147,786	148,242	630,089	926,117
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(299,120)	(207,441)	(207,979)	(714,540)
ЗҮЦХА-н шатлал шилжилтийн нөлөө	9,945	232,942	(73,334)	169,553
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт) (Тод. 9)	(141,389)	173,743	348,776	381,130
2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар	951,386	595,471	946,455	2,493,312

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

Бизнесийн зээл	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
Зээлийн багцын чанар, дансны үнээр 2022 оны 12 сарын 31				
Маш сайн	108,223,663	–	–	108,223,663
Сайн	13,835,159	–	–	13,835,159
Хэвийн бус	–	3,616,128	1,647,768	5,263,896
Хугацаа хэтэрсэн	–	–	2,297,855	2,297,855
Үнэ цэнэ буурсан	–	–	3,163,544	3,163,544
	122,058,822	3,616,128	7,109,167	132,784,117

Бизнесийн зээл	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
Зээлийн багцын чанар, дансны үнээр 2021 оны 12 сарын 31				
Маш сайн	95,232,749	–	–	95,232,749
Сайн	–	–	–	–
Хэвийн бус	–	6,001,404	1,101,013	7,102,417
Хугацаа хэтэрсэн	–	–	1,013,880	1,013,880
Үнэ цэнэ буурсан	–	–	1,332,793	1,332,793
	95,232,749	6,001,404	3,447,686	104,681,839

Бизнесийн зээлийн нийт үлдэгдэл болон холбогдох ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийг шатлал бүрээр доорх хүснэгтээс харна уу:

Бизнесийн зээл	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
Дансны дүн				
2022 оны 1 сарын 1	95,232,749	6,001,404	3,447,686	104,681,839
Шинээр олгосон	98,255,878	–	–	98,255,878
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(65,570,977)	(3,591,568)	(991,055)	(70,153,600)
Шатлал 1-рүү шилжсэн	1,066,418	(950,242)	(116,176)	–
Шатлал 2-руу шилжсэн	(3,095,177)	3,146,798	(51,621)	–
Шатлал 3-руу шилжсэн	(3,830,069)	(990,264)	4,820,333	–
2022 оны 12 сарын 31	122,058,822	3,616,128	7,109,167	132,784,117
2022 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	156,090	6,529	788,767	951,386
Шинээр олгосон	403,486	–	–	403,486
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(74,522)	(1,633)	(125,951)	(202,106)
Шатлал 1-рүү шилжсэн	576	(425)	(151)	–
Шатлал 2-руу шилжсэн	(15,634)	16,082	(448)	–
Шатлал 3-руу шилжсэн	(135,576)	(44,631)	180,207	–
Шатлал хоорондын шилжилт, тооцооллын өгөгдлийн өөрчлөлт ЗҮЦХА -д үзүүлэх нөлөө	(101,086)	163,337	408,131	470,382
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт)	77,244	132,730	461,788	671,762
2022 оны 12 сарын 31	233,334	139,259	1,250,555	1,623,148

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

Бизнесийн зээл	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
Дансны дүн				
2021 оны 1 сарын 1	44,007,120	26,954,206	4,057,848	75,019,174
Шинээр олгосон	81,316,132	–	–	81,316,132
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(33,442,174)	(17,022,019)	(1,189,274)	(51,653,467)
Шатлал 1-рүү шилжсэн	9,884,764	(9,352,772)	(531,992)	–
Шатлал 2-руу шилжсэн	(5,305,660)	5,856,038	(550,378)	–
Шатлал 3-руу шилжсэн	(1,227,433)	(434,049)	1,661,482	–
2021 оны 12 сарын 31	95,232,749	6,001,404	3,447,686	104,681,839

2021 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	112,641	99,576	880,558	1,092,775
Шинээр олгосон	147,786	–	–	147,786
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(84,539)	(75,793)	(138,788)	(299,120)
Шатлал 1-рүү шилжсэн	52,823	(21,121)	(31,702)	–
Шатлал 2-руу шилжсэн	(9,563)	37,580	(28,017)	–
Шатлал 3-руу шилжсэн	(17,064)	(766)	17,830	–
Шатлал хоорондын шилжилт, тооцооллын өгөгдлийн өөрчлөлт ЗҮЦХА -д үзүүлэх нөлөө	(45,994)	(32,947)	88,886	9,945
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт)	43,449	(93,047)	(91,791)	(141,389)
2021 оны 12 сарын 31	156,090	6,529	788,767	951,386

Орон сууцны зээл	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
Зээлийн багцын чанар, дансны үнээр 2022 оны 12 сарын 31				
Маш сайн	14,940,315	–	–	14,940,315
Сайн	994,231	–	–	994,231
Хэвийн бус	–	522,757	–	522,757
Хугацаа хэтэрсэн	–	–	154,472	154,472
Үнэ цэнэ буурсан	–	–	453,911	453,911
	15,934,546	522,757	608,383	17,065,686

2021 оны 12 сарын 31				
Маш сайн	9,426,409	–	–	9,426,409
Сайн	–	–	–	–
Хэвийн бус	–	2,202,814	16,399	2,219,213
Хугацаа хэтэрсэн	–	–	288,194	288,194
Үнэ цэнэ буурсан	–	–	384,412	384,412
	9,426,409	2,202,814	689,005	12,318,228

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

Орон сууцны зээлийн нийт үлдэгдэл болон холбогдох ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийг шатлал бүрээр доорх хүснэгтээс харна уу:

Орон сууцны зээл	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
Дансны дүн				
2022 оны 1 сарын 1	9,426,409	2,202,814	689,005	12,318,228
Шинээр олгосон	8,438,893	–	–	8,438,893
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,894,647)	(542,827)	(253,961)	(3,691,435)
Шатлал 1-рүү шилжсэн	1,549,711	(1,515,738)	(33,973)	–
Шатлал 2-руу шилжсэн	(522,757)	522,757	–	–
Шатлал 3-руу шилжсэн	(63,064)	(144,248)	207,312	–
2022 оны 12 сарын 31	15,934,546	522,757	608,383	17,065,686
2022 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	120,554	270,158	204,759	595,471
Шинээр олгосон	38,042	–	–	38,042
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(84,639)	(648)	(35,357)	(120,644)
Шатлал 1-рүү шилжсэн	1,994	(1,965)	(29)	–
Шатлал 2-руу шилжсэн	(9,642)	9,642	–	–
Шатлал 3-руу шилжсэн	(627)	(4,384)	5,011	–
Шатлал хоорондын шилжилт, тооцооллын өгөгдлийн өөрчлөлт ЗҮЦХА-д үзүүлэх нөлөө	4,351	(251,201)	2,682	(244,168)
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт)	(50,521)	(248,556)	(27,693)	(326,770)
2022 оны 12 сарын 31	70,033	21,602	177,066	268,701
Орон сууцны зээл				
Дансны үнэ				
2021 оны 1 сарын 1	5,025,602	1,926,826	546,037	7,498,465
Шинээр олгосон	7,390,134	–	–	7,390,134
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(1,348,463)	(1,148,970)	(72,938)	(2,570,371)
Шатлал 1-руу шилжсэн	524,228	(524,228)	–	–
Шатлал 2-руу шилжсэн	(2,019,628)	2,040,408	(20,780)	–
Шатлал 3-руу шилжсэн	(145,464)	(91,222)	236,686	–
2021 оны 12 сарын 31	9,426,409	2,202,814	689,005	12,318,228
2021 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	26,450	195,882	199,396	421,728
Шинээр олгосон	148,242	–	–	148,242
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(2,246)	(184,767)	(20,428)	(207,441)
Шатлал 1-руу шилжсэн	8,099	(8,099)	–	–
Шатлал 2-руу шилжсэн	(33,746)	37,205	(3,459)	–
Шатлал 3-руу шилжсэн	(24,817)	(1,444)	26,261	–
Шатлал хоорондын шилжилт, тооцооллын өгөгдлийн өөрчлөлт ЗҮЦХА-д үзүүлэх нөлөө	(1,428)	231,381	2,989	232,942
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт)	94,104	74,276	5,363	173,743
2021 оны 12 сарын 31	120,554	270,158	204,759	595,471

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

Хэрэглээний зээл	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Зээлийн багцын чанар, дансны үнээр 2022 оны 12 сарын 31				
Маш сайн	49,868,398	–	–	49,868,398
Сайн	1,353,083	–	–	1,353,083
Хэвийн бус	–	353,027	109,473	462,500
Хугацаа хэтэрсэн	–	–	522,977	522,977
Үнэ цэнэ буурсан	–	–	1,234,139	1,234,139
	51,221,481	353,027	1,866,589	53,441,097

Хэрэглээний зээл	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2021 оны 12 сарын 31				
Маш сайн	21,221,422	–	–	21,221,422
Сайн	–	–	–	–
Хэвийн бус	–	662,418	508,493	1,170,911
Хугацаа хэтэрсэн	–	–	610,528	610,528
Үнэ цэнэ буурсан	–	–	127,280	127,280
	21,221,422	662,418	1,246,301	23,130,141

Хэрэглээний зээлийн нийт үлдэгдэл болон холбогдох ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийг шатлал бүрээр доорх хүснэгтээс харна уу:

Хэрэглээний зээл	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
Дансны дүн				
2022 оны 1 сарын 1	21,221,422	662,418	1,246,301	23,130,141
Шинээр олгосон	48,418,909	–	–	48,418,909
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(16,570,288)	(504,008)	(1,033,657)	(18,107,953)
Шатлал 1-рүү шилжсэн	149,211	(75,002)	(74,209)	–
Шатлал 2-руу шилжсэн	(338,971)	347,667	(8,696)	–
Шатлал 3-руу шилжсэн	(1,658,802)	(78,048)	1,736,850	–
2022 оны 12 сарын 31	51,221,481	353,027	1,866,589	53,441,097
2022 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	503,701	90,944	351,810	946,455
Шинээр олгосон	575,246	–	–	575,246
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(238,412)	(48,249)	(265,980)	(552,641)
Шатлал 1-рүү шилжсэн	2,275	(2,186)	(89)	–
Шатлал 2-руу шилжсэн	(14,041)	14,115	(74)	–
Шатлал 3-руу шилжсэн	(190,780)	(12,809)	203,589	–
Шатлал хоорондын шилжилт, тооцооллын өгөгдлийн өөрчлөлт ЗҮЦХА-д үзүүлэх нөлөө	(176,417)	86,781	47,969	(41,667)
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт)	(42,129)	37,652	(14,585)	(19,062)
2022 оны 12 сарын 31	461,572	128,596	337,225	927,393

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

17. Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (үргэлжлэл)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан (үргэлжлэл)

Хэрэглээний зээл	Шатлал 1 мян.төг	Шатлал 2 мян.төг	Шатлал 3 мян.төг	Нийт мян.төг
Дансны дүн				
2021 оны 1 сарын 1	11,349,163	2,624,340	596,321	14,569,824
Шинээр олгосон	19,334,761	–	–	19,334,761
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(8,971,649)	(1,413,216)	(389,579)	(10,774,444)
Шатлал 1-рүү шилжсэн	686,475	(658,462)	(28,013)	–
Шатлал 2-руу шилжсэн	(438,250)	481,374	(43,124)	–
Шатлал 3-руу шилжсэн	(739,078)	(371,618)	1,110,696	–
2021 оны 12 сарын 31	21,221,422	662,418	1,246,301	23,130,141
2021 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	205,436	202,732	189,511	597,679
Шинээр олгосон	630,089	–	–	630,089
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(109,908)	(41,476)	(56,595)	(207,979)
	112,757	(95,888)	(16,869)	–
Шатлал 2-руу шилжсэн	(76,105)	79,966	(3,861)	–
Шатлал 3-руу шилжсэн	(113,275)	(46,416)	159,691	–
Шатлал хоорондын шилжилт, тооцооллын өгөгдлийн өөрчлөлт ЗҮЦХА-д үзүүлэх нөлөө	(145,293)	(7,974)	79,933	(73,334)
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт)	298,265	(111,788)	162,299	348,776
2021 оны 12 сарын 31	503,701	90,944	351,810	946,455

18. Бусад хөрөнгө

	2022 мян.төг	2021 мян.төг
Бусад санхүүгийн хөрөнгө		
Мөнгөн гүйлгээ, төлбөр тооцооноос үүссэн авлага	172,230	142,440
Байгууллагаас авах авлага	751,497	232,764
Бусад санхүүгийн хөрөнгө	1,825,000	82,834
Хасах нь: үнэ цэнийн бууралтын сан	(157,609)	(174,089)
	2,591,118	283,949
Бусад санхүүгийн бус хөрөнгө		
Урьдчилж төлсөн зардал	2,111,506	2,820,416
Хангамжийн материал	828,398	750,506
Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн урьдчилгаа	761,298	1,014,806
Өмчлөх бусад хөрөнгө	4,850,731	50,000
	8,551,933	4,635,728
Нийт бусад хөрөнгө	11,143,051	4,919,677

Доорх хүснэгтээр бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөнийг үзүүлэв:

	2022 мян.төг	2021 мян.төг
Бусад авлагын үнэ цэнийн бууралтын сан		
1 сарын 1-нээр	174,089	183,250
Тайлант жилд байгуулсан	9,520	–
Буцаалт	(26,000)	(9,161)
Тайлант хугацааны цэвэр зардал/(буцаалт) (Тод. 9)	(16,480)	(9,161)
12 сарын 31-нээр	157,609	174,089

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

18. Бусад хөрөнгө (үргэлжлэл)

Доорх хүснэгтэд Банкны дотоодын зээлийн үнэлгээний систем, жилийн эцсийн ангилал дээр тулгуурлаж зээлийн чанарыг багц болон сангийн хөдөлгөөнөөр илэрхийлж харуулсан болно. Үүнд үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй бодит хэмжээг тусгасан болно. Банкны дотоод үнэлгээний систем, ЗҮЦХА-ыг тусгай болон бүлгийн үнэлгээгээр хэрхэн үнэлэх талаар тодруулга 30-д дэлгэрэнгүй тайлбарласан.

	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3	Нийт
	MNT'000	MNT'000	MNT'000	MNT'000
2022 оны 12 сарын 31-ний байдлаар				
Маш сайн	2,598,114	–	–	2,598,114
Сайн	–	–	–	–
Хэвийн бус	–	2,524	–	2,524
Хугацаа хэтэрсэн	–	–	–	–
Үнэ цэнэ буурсан	–	–	148,089	148,089
Нийт	2,598,114	2,524	148,089	2,748,727
2021 оны 12 сарын 31-ний байдлаар				
Маш сайн	284,866	–	–	284,866
Сайн	–	–	–	–
Хэвийн бус	–	–	–	–
Хугацаа хэтэрсэн	–	–	–	–
Үнэ цэнэ буурсан	–	–	173,172	173,172
Нийт	284,866	–	173,172	458,038

	2022	2021
	MNT'000	MNT'000
Өмчлөх бусад хөрөнгө		
1 сарын 1-нээр	50,000	–
Нэмэгдсэн	5,344,694	1,619,300
Борлуулах зориулалттай хөрөнгө рүү шилжсэн (Тод.19)	(543,963)	(1,569,300)
12 сарын 31-нээр	4,850,731	50,000

19. Борлуулах зориулалттай хөрөнгө

	2022	2021
	мян.төг	мян.төг
1 сарын 1-нээр	1,034,300	344,090
Өмчлөх бусад хөрөнгөөс нэмэгдсэн (Тод. 18)	543,963	1,569,300
Борлуулсан	(110,000)	(879,090)
12 сарын 31-нээр	1,468,263	1,034,300

Эдгээр барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийг яаралтай зарах боломжтой бөгөөд одоогийн нөхцөлд худалдан авагчид зарж борлуулах боломжтой гэж менежмент үнэлэв. Борлуулахтай холбоотой үйл ажиллагааг эхлүүлсэн ба Борлуулах зориулалттай хөрөнгөөр дахин ангилснаас нэг (1) жилийн хугацаанд борлуулахаар төлөвлөж байна. Боломжит худалдан авагчид тодорхойлогдсон ба энэхүү тайланг гаргасан өдөр ахисан шатны хэлэлцээр хийгдэж байсан. 2023 оны 2 болон 3 дугаар саруудад 1,024,770 мян.төг-ийн дүнтэй борлуулах зориулалттай хөрөнгө гуравдагч этгээдэд борлуулсан байна.

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

20. Үндсэн хөрөнгө

	Компьютер, тоног төхөөрөмж мян.төг	Тавилга, эд хогшил ба тээврийн хэрэгсэл мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12 сарын 31			
Өртөг			
2022 оны 1 сарын 1-нээр	3,012,169	1,797,355	4,809,524
Нэмэгдсэн	1,175,159	1,148,756	2,323,915
Борлуулсан	(35,256)	(78,898)	(114,154)
Данснаас хассан (Тод.10)	(8,334)	(18,134)	(26,468)
2022 оны 12 сарын 31-нээр	4,143,738	2,849,079	6,992,817
Хуримтлагдсан элэгдэл			
2022 оны 1 сарын 1-нээр	1,544,316	372,090	1,916,406
Тайлант жилд байгуулсан (Тод. 10)	730,789	180,243	911,032
Борлуулсан	(17,022)	(2,041)	(19,063)
Данснаас хассан (Тод. 10)	(7,150)	(5,951)	(13,101)
2022 оны 12 сарын 31-нээр	2,250,933	544,341	2,795,274
Дансны цэвэр үнэ	1,892,805	2,304,738	4,197,543

	Барилга мян.төг	Компьютер, тоног төхөөрөмж мян.төг	Тавилга, эд хогшил ба тээврийн хэрэгсэл мян.төг	Нийт мян.төг
2021 оны 12 сарын 31				
Өртөг				
2021 оны 1 сарын 1-нээр	348,868	1,984,799	1,557,790	3,891,457
Нэмэгдсэн	–	1,038,602	762,495	1,801,097
Борлуулсан	(348,868)	–	(509,297)	(858,165)
Данснаас хассан (Тод.10)	–	(11,232)	(13,633)	(24,864)
2021 оны 12 сарын 31-нээр	–	3,012,169	1,797,355	4,809,525
Хуримтлагдсан элэгдэл				
2021 оны 1 сарын 1-нээр	31,899	1,087,705	445,409	1,565,013
Тайлант жилд байгуулсан (Тод. 10)	14,377	467,333	155,601	637,311
Борлуулсан	(46,276)	–	(225,231)	(271,507)
Данснаас хассан (Тод. 10)	–	(10,722)	(3,689)	(14,411)
2021 оны 12 сарын 31-нээр	–	1,544,316	372,090	1,916,406
Дансны цэвэр үнэ	–	1,467,853	1,425,265	2,893,119

21. Ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өглөг

Банк нь өөрийн үйл ажиллагаанд ашигладаг салбаруудын оффисын талбайг түрээслэх гэрээтэй. Эдгээр түрээснүүд нь дунджаар таван жилийн түрээсийн хугацаатай байдаг. Банкны түрээсийн гэрээний дагуу хүлээсэн үүрэг нь түрээслүүлэгчийн өмчлөх эрхээр баталгаажсан болно.

Банк нь 12 сар болон түүнээс бага хугацаатай серверийн зай, агуулах болон лого самбар түрээсэлдэг бөгөөд бага үнэтэй түрээсэлдэг. Банк нь “богино хугацаат түрээс” болон “бага үнэ цэнтэй түрээс” гэсэн түрээсийн чөлөөлөлтүүдийг эдгээр хөрөнгийн хувьд ашигласан.

Ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөрийн дансны дүн ба тайлант жилийн хөдөлгөөнийг дор харуулав:

	Ашиглах эрхтэй хөрөнгө	
	2022 мян.төг	2021 мян.төг
1 сарын 1-нээр	2,845,683	2,269,534
Нэмэгдсэн	388,638	927,248
Түрээсийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан	–	(222,762)
Гэрээний дүнгийн өөрчлөлт	351,774	440,272
Тайлант жилийн элэгдэл (Тод. 10)	(825,453)	(568,609)
12 сарын 31-нээр	2,760,642	2,845,683

	Түрээсийн өглөг	
	2022 мян.төг	2021 мян.төг
1 сарын 1-нээр	2,994,860	2,292,720
Нэмэгдсэн	200,130	927,248
Түрээсийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан	–	(259,076)
Гэрээний дүнгийн өөрчлөлт	351,774	480,953
Хүүний зардал (Тод: 5)	437,697	358,686
Ковид-19-тэй холбоотой хөнгөлөлтүүд (Тод. 8)	–	(66,651)
Түрээсийн төлбөр	(1,028,684)	(739,020)
12 сарын 31-нээр	2,955,777	2,994,860

Түрээстэй холбоотой ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдийг дараах хүснэгтээс харна уу:

	2022 мян.төг	2021 мян.төг
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	825,453	568,609
Түрээсийн өр төлбөрийн хүүний зардал	437,697	358,686
Богино хугацаат болон бага дүнтэй түрээсийн зардал (үйл ажиллагааны зардалд орсон)	112,751	90,402
Нийт	1,375,901	1,017,697

Банк лизингийг хэрэгжих нь гарцаагүй гэж үзвэл сонголтоор сунгагдаж болох дурын хугацаанд эсвэл хэрэгжих нь гарцаагүй гэж үзвэл цуцалж болох дурын хугацаанд цуцалшгүй гэж авч үздэг. Банк нь хэд хэдэн салбар, оффистоо лизингийн сунгалт болон цуцлалтын сонголттой. Эдгээр нь банкны үйл ажиллагааны уян хатан байдлыг хангахад ашиглагддаг.

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

22. Биет бус хөрөнгө

	2022	2021
	мян.төг	мян.төг
Өртгөөр		
1 дүгээр сарын 1	1,669,146	1,480,739
Нэмэгдсэн	530,396	195,552
Данснаас хассан	(67,209)	(7,145)
12 сарын 31	<u>2,132,333</u>	<u>1,669,146</u>
Хуримтлагдсан хорогдуулалт		
1 дүгээр сарын 1-нээр	813,295	673,684
Тайлант жилд байгуулсан (Тод. 10)	454,391	146,756
Данснаас хассан	(67,209)	(7,145)
12 сарын 31	<u>1,200,477</u>	<u>813,295</u>
Цэвэр дансны үнэ	<u>931,856</u>	<u>855,851</u>

23. Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж

	2022	2021
	мян.төг	мян.төг
Бусад банк санхүүгийн байгууллагын хадгаламж	43,347,904	24,793,633

2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх бусад банк, санхүүгийн байгууллага дахь хадгаламжид дотоод арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагуудын хугацаат хадгаламжийн дансыг оруулсан. Хугацаатай хадгаламж жилийн 1% - 14% (2021: 2% - 6%) хүүтэй, 3-28 хүртэлх хоногийн (2021: 3-34 хоног) хугацаатай байна.

24. Репо хэлцэл

	2022	2021
	мян.төг	мян.төг
Монголбанк	65,471,192	49,712,396

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар богино болон урт хугацаат репо хэлцлийн үлдэгдэл 65,471,192 мянган төгрөгийг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” хөтөлбөрийн хүрээнд авсан бөгөөд банк шаардлага хангасан зээлдэгчдэд олгосон зээлүүдээ ҮЦСК-д зарж ХБҮЦ төлбөрт нь авсан (Тод. 17). Репо хэлцлүүд нь жилийн 6%-аас 10.5%-ийн хүүтэй бөгөөд хэлцлийн дуусах хугацаа нь 2025 оны 2 сарын 20 байна. Репо хэлцлүүдийн хүрээнд 62,000,000 мян.төг-ийн (2021: 40,211,000 мян.төг) 2023 оны 1 сарын 2-нд дуусах хугацаатай төв банкны үнэт цаас (Тод.13), 4,124,400 мян.төг-ийн (2021: тэг) 2024 оны 8 сарын 18-нд дуусах хугацаатай давуу эрхтэй ХБҮЦ барьцаалсан.

25. Харилцагчдын харилцах, хадгаламж

	2022	2021
	мян.төг	мян.төг
Засгийн газар		
- Харилцах данс	4,564,782	7,123,922
- Хугацаагүй хадгаламж	953,382	-
- Хугацаатай хадгаламж	-	3,227,339
Хувийн сектор		
- Хугацаат хадгаламж	49,220,996	25,271,584
- Харилцах данс	40,455,711	13,064,633
- Баталгааны эх үүсвэр	1,214,007	1,165,742
- Хугацаагүй хадгаламж	-	339,087
Иргэд		
- Хугацаат хадгаламж	105,757,927	77,478,196
- Харилцах данс	14,332,101	7,919,403
- Хугацаагүй хадгаламж	743,528	1,524,367
	<u>217,242,434</u>	<u>137,114,273</u>

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

26. Зээлээр авсан эх үүсвэр

	Дуусах огноо	2022 мян.төг	2021 мян.төг
Гадаадын банк санхүүгийн байгууллагаас зээлээр авсан санхүүжил			
ЭМФ Микрофайнанс Сан	7/7/2024 - 10/28/2024	14,057,079	–
Чайна Трейд Солюшинс Лимитэд	01/27/2024	183,528	–
Төрийн байгууллагаас зээлээр авсан санхүүжилт			
Монголбанк - Орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөр	12/15/2023	6,597,017	8,122,568
Монголбанк – Түлш эрчим хүчний төсөл	12/26/2023	6,300,000	–
ЖДҮ Хөгжлийн сан	7/1/2022	–	90,000
		27,137,624	8,212,568

Төрийн байгууллагаас авсан бүх санхүүжилт нь Монгол Улсын Засгийн газраас авсан болно. Банк 2022 оны 12 сарын 31-ний байдлаар ямар нэгэн үндсэн зээлийн болон хүүний төлөлтөөс хоцроогүй, зээлдүүлэгчтэй хийсэн гэрээний заалтуудыг ханган ажиллаж байна.

27. Бусад өр төлбөр

	2022 мян.төг	2021 мян.төг
Бусад санхүүгийн өр төлбөр		
Хойшлогдсон клирингийн төлбөр тооцоо	934,380	360,473
Байгууллагад өгөх өглөг	169,250	2,563,514
Тэнцлийн гадуурх үүргийн эрсдэлийн сан (Тод.29)	31,192	11,215
	1,134,822	2,935,202
Бусад санхүүгийн бус өр төлбөр		
Орлогын албан татвараас бусад татварын өглөг	2,406,603	646,143
Бусад	791,644	746,781
	3,198,277	1,392,924
Нийт бусад өр төлбөр	4,333,099	4,328,126

28. Хувьцаат капитал ба бусад нөөц сан

Хувьцаат капитал

Банк нь Монголын Хөрөнгийн Бирж (“МХБ”) -д бүртгэлтэй хувьцаат компани юм. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн нэг мянга зургаан зуун (1,600 төгрөг) (2021:1,000 төгрөг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 62,500,000 (2021: 62,500,000) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. 2022 болон 2021 оны 12 сарын 31-ээр гүйлгээнд нийт 62,500,000 ширхэг энгийн хувьцаа байсан. Гаргасан бүх энгийн хувьцааны төлбөрийг бүрэн төлсөн.

Банкны энгийн хувьцаа хувьцаа бүр нэг саналын эрхтэй ба ТУЗ-ын тогтоолоор ногдол ашиг хуваарилна.

28. Хувьцаат капитал ба бусад нөөц сан (үргэлжлэл)

	Энгийн хувьцаа		Нэмж төлөгдсөн капитал		Нийт	
	2022	2021	2022	2021	2022	2021
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
1 сарын 1-нээр	62,500,000	50,000,000	17,806,822	–	80,306,822	50,000,000
Нэмж гаргасан	–	12,500,000	–	19,250,000	–	31,750,000
Хувьцаа гаргахтай холбоотой шууд зардал	–	–	–	(1,443,178)	–	(1,443,178)
Хувьцаагаарх ногдол ашиг	18,250,000	–	–	–	18,250,000	–
НТК-иас Энгийн хувьцаанд шилжүүлсэн	19,250,000	–	(19,250,000)	–	–	–
12 сарын 31-нээр	100,000,000	62,500,000	(1,443,178)	17,806,822	98,556,822	80,306,822

Банк нь 2021 оны 12-р сарын 1-нд МХБ-д бүртгүүлсэн бөгөөд 12,500,000 ширхэг хувьцааг нэгж бүрийг 2,540 төгрөгөөр шинээр нэмж гарган, 31,750,000 мянган төгрөгийн хөрөнгө татан төвлөрүүлсэн. Улмаар нэмж төлөгдсөн капиталын дүн нь хувьцаа гаргахтай шууд холбоотой 1,443,178 мянган төгрөгийн зардал хассан дүнгээр буюу 17,806,822 төгрөгөөр нэмэгдсэн.

2022 оны 3 сарын 31-нд Монгол банк Банкны нэгж хувьцааны үнийг 1,000 төгрөгөөс 1,600 болгон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 62.5 тэрбум төгрөгөөс 100 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн. Үүнтэй холбогдуулан Банк хуримтлагдсан ашгаас 18,250,000 мян.төгрөгийн хувьцаагаарх ногдол ашиг олгож, нэмж төлөгдсөн капиталаас 19,250,000 мян.төгрөгийг энгийн хувьцаанд шилжүүлсэн.

Мөн Банк 2022 онд нэмж 1,205,000 мянган төгрөгийн (2021: тэг) мөнгөн ногдол ашиг зарлаж тараасан.

Бусад нөөц сан

	Өмчийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн нөөц	Өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн нөөц	Журмын сан	Нийт
2022 оны 1-р сарын 1-нээр	500,000	(118,512)	547,509	928,997
Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	(500,000)	(5,103,045)	–	(5,603,045)
Ашиг, алдагдлын тайлан руу ангилагдсан хэрэгжсэн олз/(гарз)	–	2,502,234	–	2,502,234
Хүлээгдэж буй алдагдлын сан	–	72,750	–	72,750
Журмын сангийн нэмэгдэл	–	–	519,910	519,910
2022 оны 12-р сарын 31-нээр	–	(2,646,573)	1,067,419	(1,579,154)
2021 оны 1-р сарын 1-нээр	500,000	473,181	68,010	1,041,191
Бодит үнэ цэнийн цэвэр өөрчлөлт	–	(454,961)	–	(454,961)
Ашиг, алдагдлын тайлан руу ангилагдсан хэрэгжсэн олз/(гарз)	–	(129,760)	–	(129,760)
Хүлээгдэж буй алдагдлын сан	–	(6,972)	–	(6,972)
Журмын сангийн нэмэгдэл	–	–	479,499	479,499
2021 оны 12-р сарын 31-нээр	500,000	(118,512)	547,509	928,997

Журмын сан нь СТОУС 9 -ийн дагуу байгуулсан эрсдэлийн сан дээр нэмэлтээр Монголбанкны эрсдэлийн сан байгуулах журмын дагуу байгуулсан сан юм.

29. Болзошгүй өр төлбөр ба үүрэг

Харилцагчдын санхүүгийн хэрэгцээ, шаардлагыг хангахын тулд, Банк нь төрөл бүрийн буцалтгүй үүрэг болон болзошгүй өр төлбөр хүлээдэг. Хэдийгээр эдгээр үүргийг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй ч, эдгээр нь зээлийн эрсдэл, улмаар Банкны нийт эрсдэлийн нэг хэсэг болдог.

	2022 мян.төг	2021 мян.төг
Зээлтэй холбоотой болзошгүй өр төлбөр ба үүрэг		
Эх үүсвэргүй баталгаа	17,217,151	14,449,918
Кредит картын ашиглагдаагүй үлдэгдэл	5,224,506	99,355
	22,441,657	14,549,273
Хөрөнгөтэй холбоотой үүрэг		
Үндсэн хөрөнгө	–	271,131

Доорх хүснэгтэд зээлийн чанар, Банкны дотоод үнэлгээний систем дээр үндэслэсэн зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлыг агуулсан зээлийн эрсдэлийн хамгийн их хэмжээ болон жилийн эцсийн ангиллыг харуулав. Зээлтэй холбоотой болзошгүй өр төлбөр ба үүргийн чанар 2022, 2021 онуудад “маш сайн” ангилалд байсан.

Тэнцлийн гадуурх өр төлбөр ба хүлээж болзошгүй үүргийн үнэ цэнийн бууралтын сан

	Баталгаа Шатлал 1 мян.төг	Кредит картын ашиглагдаагүй үлдэгдэл Шатлал 1 мян.төг	Нийт мян.төг
2022 оны 1 сарын 1-нээрх үлдэгдэл	14,449,918	99,355	14,549,273
Шинээр олгосон	9,326,823	20,580,549	29,907,372
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(6,559,590)	(15,455,398)	(22,014,988)
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	17,217,151	5,224,506	22,441,657
2022 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	1,413	9,802	11,215
Тайлант жилд байгуулсан/ (буцаасан) (Тод. 9)	899	19,078	19,977
2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	2,312	28,880	31,192
2021 оны 1 сарын 1-нээрх үлдэгдэл	16,853,114	108,251	16,961,365
Шинээр олгосон	5,909,144	20,787,952	26,697,096
Төлөгдсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн	(8,312,340)	(20,796,848)	(29,109,188)
2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	14,449,918	99,355	14,549,273
2021 оны 1 сарын 1-нээрх ЗҮЦХА-н сан	1,490	7,598	9,088
Тайлант жилд байгуулсан/ (буцаасан) (Тод. 9)	(77)	2,204	2,127
2021 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	1,413	9,802	11,215
Зээлийн чанараар			
2022 оны 12 сарын 31			
Маш сайн	17,217,151	5,224,506	22,441,657
2021 оны 12 сарын 31			
Маш сайн	14,449,918	99,355	14,549,273

29. Болзошгүй өр төлбөр ба үүрэг (үргэлжлэл)

Болзошгүй өр төлбөр

Тендер, дуудлага худалдаа гэх мэт тодорхой үйл явдалтай холбоотойгоор харилцагчийн өмнөөс төлбөр хийх үүргийг баталгаа Банкинд ногдуулдаг. Баталгаа нь хэдийгээр болзошгүй шинж чанартай ч зээлийн эрсдэлтэй ижил эрсдэлийг агуулдаг болно. Банкинд эдгээртэй холбоотойгоор аливаа материаллаг алдагдал учрахгүй гэсэн хүлээлттэй байна.

Үүрэг

Үүрэг гэдэг нь Банкны зүгээс зээл олгох гэрээт үүргүүдийг хүлээснийг илэрхийлдэг. Ийм үүргүүд нь тогтсон дуусах хугацаа эсвэл цуцлах бусад төрлийн заалтуудтай байдаг. Зээл олгох үүрэг нь хэрэгжээгүй байхад тус үүргийн хугацаа нь дуусаж болох тул гэрээнд заасан дүн нь ирээдүйд гарч болох мөнгөний шаардлагыг илэрхийлдэг гэсэн үг биш юм.

Ашиглагдаагүй кредит картын үлдэгдэл

Энэхүү хэрэгслийн гол зорилго нь харилцагчид шаардлагатай хэмжээний санхүүжилт бэлэн байгааг баталгаажуулах юм. Батлагдсан кредит картын эрхээс ашиглагдаагүй байгаа хэсэг нь зээлийг нэмэгдүүлэх үүргийг тодорхойлно. Зээлийг нэмэгдүүлэх үүргийн эрсдэл нь, ашиглагдаагүй кредит картын эрхийн хэмжээгээр Банк алдагдал хүлээх эрсдэл юм. Гэсэн хэдий ч, зээлийн эрхийг хэвийн байлгах тодорхой шалгуур үзүүлэлтүүдээс хамааран алдагдлын дүн нь нийт ашиглагдаагүй зээлийн эрхийн хэмжээнээс бага байх талтай байдаг.

Шүүхийн нэхэмжлэл

Бизнесийн онцлог шинж чанарын улмаас Банкны салбарт шүүхээр асуудлыг шийдэх явдал энгийн үзэгдэл байдаг. Банк нь шүүхийн нэхэмжлэлтэй хэрхэн ажиллах талаар тогтсон журам, хяналттай. Мэргэжлийн зөвлөгөө авч, гарч болох хохирлын хэмжээг зохистойгоор тооцоолон Банк нь тухайн нэхэмжлэлийн банкны санхүүгийн байдалд үзүүлж болох сөрөг нөлөөг холбогдох дансыг тохируулан толилуулдаг.

2021, 2020 оны тайлант жилийн эцэст Банкинд томоохон үүрэг хүлээх шүүхийн нэхэмжлэл байхгүй болно.

30. Эрсдэлийн удирдлага

30.1 Оршил

Банкны бизнес үйл ажиллагааны үндсэн эрсдэлийн төрөлд зээл, хөрвөх чадвар, валютын ханш, үйл ажиллагааны эрсдэлүүд ордог. Эдгээрийг Гүйцэтгэх Захиралд шууд тайлагнадаг Эрсдэлийн Нэгдсэн Удирдлагын Газар удирддаг. Банкны эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь банкны стратеги, зорилгод нөлөөлж болзошгүй эрсдэлийг Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хүрээнд тодорхойлж, эрсдэлийг илрүүлэх, хэмжих, хянах замаар удирдахад оршино. Уг үйл явц нь Банкны тасралтгүй ашигт ажиллагаанд маш чухал үүрэгтэй ба Банкны ажилтан бүрийн оролцоо, тэдний ажил үүргийн хариуцлагын хүрээнд эрсдэлийг илрүүлэхтэй шууд холбоотой юм.

Дээр дурдсан эрсдэлийн удирдлагын явцад бизнесийн эрсдэлийн удирдлага багтаагүй болно. Бизнесийн эрсдэл гэдэг нь бизнесийн хүрээлэн буй орчин, технологи, болон үйл ажиллагаа явуулж буй салбарт гарсан өөрчлөлтүүдээс үүссэн эрсдэлийг хэлнэ. Эдгээр бизнесийн эрсдэлүүд нь Банкны стратеги төлөвлөлтийн хүрээнд хянагдаж байдаг.

Банк нь эрсдэлийг бүрмөсөн арилгахад чиглэхээс илүүтэйгээр эрсдэл, өгөөжийг хамгийн оновчтой хослуулахад чиглэсэн эрсдэлийн удирдлагын бодлоготой. Одоо мөрдөж буй эрсдэлийн удирдлагын систем нь дараах зарчмуудыг агуулсан байна. Үүнд:

- Эрсдэлүүдийг удирдаж буй этгээд нь зохицуулалтын болон хэмжилтийн системийг сайн ойлгож байна;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс (“ТУЗ”) баталсан хязгаарын хүрээнд эрсдэлийг илрүүлж байна;
- ТУЗ-өөс баталсан бизнесийн бодлогын дагуу эрсдэлийг хэмжиж байна;
- Капиталын хуваарилалт нь эрсдэлийн түвшинтэйгээ уялдаж байна;
- Банкны гүйцэтгэлийн зорилт нь эрсдэл даах байдалтай уялдаж байна.

Эрсдэлийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт

Банкны ТУЗ нь Банкны эрсдэлийн удирдлагын ерөнхий тогтолцоог хариуцах ба эрсдэлийн удирдлагын бодлого болон эрсдэл хүлээх чадвар болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийг тусгасан зээлийн бодлогыг батлах үүрэгтэй. Мөн удирдлагын бүх түвшинд эрсдэлийн талаарх нэгдсэн ойлголттой байж дараах шатны хороод эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

Эрсдэлийн Удирдлагын Хороо (“ЭУХ”)

Эрсдэлийн Удирдлагын хороо нь Банкны бизнес нэгжүүдийн болон банкны үйл ажиллагаанд учирсан болон учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох, мөн үйл ажиллагааны эрсдэл, зах зээлийн эрсдэл болон бусад эрсдэлүүдийг багасгах зорилгоор тэдгээрийг үнэлэх, түүнийг хэрэгжүүлэх заавар удирдамж өгч ажилладаг.

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**30.1 Оршил (үргэлжлэл)****ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо**

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь Банкны санхүүгийн тайлангууд болон тодруулгуудын үнэн зөв байдлыг хянах, хууль эрх зүйн болон зохицуулалтын хүрээнд зохистой байдал, дотоод хяналт болон аудитын хүрээнд ТУЗ-д дэмжлэг үзүүлж ажилладаг.

Гүйцэтгэх удирдлагын хороо

Гүйцэтгэх удирдлагын хороо нь Банкны нийт гүйцэтгэх удирдлагуудаас бүрдэх бөгөөд Гүйцэтгэх захирал даргалан сар болгон хуралддаг. Хурлаар Банкны стратегийн асуудлууд болон тогтвортой бизнесийн удирдлагыг хангахад шаардлагатай төлөвлөлтийн асуудлуудыг хэлэлцдэг.

Актив пассивын удирдлагын хороо (“АПУХ”)

АПУХ нь Банкны эх үүсвэр, төлбөрийн чадвар, гадаад валют, эх үүсвэрийн эргэн төлөгдөх хугацаа, хүүний эрсдэлүүдийн ерөнхий актив пассивын удирдлагыг гүйцэтгэнэ. АПУХ-ны зорилго нь Банкны санхүүгийн тайлангийн актив пассивын бүтцийг Банкны тогтвортой хөгжлийг хангах байдлаар тогтоох, актив пассивын ерөнхий удирдлагаар ашигт ажиллагаа болон хөрвөх чадварыг хангах мөн валютын, хүүний болон зах зээлийн бусад эрсдэлийг удирдахад оршино. АПУХ-г Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч даргалдаг.

Зээлийн хороод

Банкны зээлийн хороо болон Эрсдэлийн Нэгдсэн Удирдлагын Газар нь /цаашид ЭНУГ гэх/ нь Банкны зээлийн эрсдэлийг удирддаг. Зээлийн хорооны бүтэц, зохион байгуулалт нь Банкны түвшин бүр дэх зээлийн эрсдэлийг удирдахад зохион байгуулагдсан. Банк нь зээл батлах, хяналт тавих доорх гурван шатны зээлийн хороодтой:

1. Зээлийн хороо нь 100.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийн хүсэлтийг хэлэлцэн баталдаг. Түүнчлэн, одоогийн мөрдөгдөж буй бодлого журмын дагуу 3.0 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй зээлийн хүсэлтийг мөн ТУЗ-д танилцуулан батлуулдаг.
2. Зээлийн дэд хороо нь орон нутгийн салбар болон зээлийн нэгжүүдийн зээлийн хорооны зээл батлах эрхээс давсан буюу 100 сая төгрөг хүртэлх зээлийн хүсэлтийг хэлэлцэн баталдаг.
3. Салбарын Зээлийн хороо өөрийн эрхийн хүрээнд зээлийн хүсэлтийг батална. Мөн өөрийн харьяа тооцооны төвүүдийн зээлийн эрх хамаарах бөгөөд салбарын зээлийн багцыг удирдана.

Дотоод аудит

Банкны эрсдэлийн удирдлагын үйл явцыг Дотоод аудитын газар жил бүр аудитладаг. Аудитын үед банкны журмуудын хэрэгжилт, хэрэгжүүлж буй арга хэмжээ зохистой байдлыг үнэлэн шалгадаг. Дотоод аудитын газар нь хийсэн бүх үнэлгээнийхээ үр дүнг банкны удирдлагатай хэлэлцэж, илрүүлсэн алдаа, дутагдал болон зөвлөмжүүдийн талаар ТУЗ-ын дэргэдэх аудитын хороонд тайлагнана.

Эрсдэлийг хэмжих болон тайлагнах систем

Банк нь статистик загварууд дээр үндэслэн ердийн тохиолдолд хүлээж болзошгүй алдагдал болон гэнэтийн тохиолдолд учирч болзошгүй алдагдлын аль алиныг илэрхийлж чадах арга зүйгээр эрсдэлээ хэмждэг. Эдгээр статистик загваруудыг түүхэн өгөгдлөөр тооцсон магадлалыг эдийн засгийн өнөөгийн орчинд нийцүүлэх байдлаар хэрэглэдэг. Эрсдэлийн удирдлага, хяналт нь гол төлөв Банкнаас тогтоосон хязгаарын биелэлтэд суурилна. Эдгээр хязгааруудад Банк өөрийн бизнесийн стратеги зорилт, тухайн зах зээлийн орчин, мөн цаашид хүлээх боломжтой эрсдэлийн түвшинг тусгаж өгсөн байна. Үүнээс гадна Банк нь өөрийн эрсдэл даах чадварыг бүх үйл ажиллагаа болон эрсдэлийн төрлүүдээр тодорхойлон хэмжиж, түүнд хяналт тавьж байдаг.

Эрсдэлийг цаг алдалгүй олж таних, шинжлэх, хянах үүднээс бизнесийн бүх нэгжүүдээс цуглуулсан мэдээллүүдийг шинжилж үздэг. Уг мэдээллийг ТУЗ, АПУХ, ЭУХ, зээлийн хороод болон бүх газар, хэлтсийн захирлуудад танилцуулж, тайлагнадаг. Тайланд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцын хэмжээ, кредит метрикийн таамаглал, тогтоосон лимитийн гажилт, VaR, хөрвөх чадварын харьцаа болон эрсдэлийн утгуудын өөрчлөлтийг тусгана.

Улирал бүр АПУХ болон Эрсдэлийн хороо нь Банкны эрсдэлд үнэлэлт, дүгнэлт өгөхөд бүх шаардлагатай мэдээллээр хангах зорилготой иж бүрэн эрсдэлийн тайланг хүлээн авдаг. Хоёр долоо хоног бүр Актив пассивын удирдлагын хороонд VaR, хөрвөх чадварын шинжилгээ, зах зээлийн эрсдэлийн лимитийн биелэлт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулдаг

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.1 Оршил (үргэлжлэл)

Эрсдэлийг бууруулах

Хүүгийн түвшний эрсдэл, гадаад валютын ханшийн өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдэлийн хэмжээг мэдрэмжийн шинжилгээ болон VaR аргаар тооцон, хянаж ажилладаг. Банк зээлийн эрсдэлийг барьцаа хөрөнгө болон батлан даалт гаргуулах замаар бууруулдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл нэгэн ижил газар зүйн бүсэд болон эдийн засгийн тухайлсан нэг салбарт бизнес эрхэлдэг харилцагчдын үйл ажиллагаанд улс төр, эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал төвлөрөл нь бий болдог. ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ нь эдийн засгийн салбарын төвлөрөл, нэг зээлдэгчийн төвлөрөл, шинэ бүтээгдэхүүний төвлөрөл болон хэвийн бус зээлийн харьцаа зэрэгт тавигдах хязгаарлалт, стандартуудыг тогтоодог. Төвлөрөл нь тухайн нэгж салбарт болон газар зүйн байрлалд нөлөөлж буй нөхцөл байдалд Банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илтгэнэ. Банкны гүйцэтгэлийг өсөлттэй тодорхой нэг эдийн засгийн салбар болон газарзүйн бүсээс хэр хамааралтай байгааг төвлөрөл нь илэрхийлдэг.

Эрсдэлийн хэт төвлөрлөөс зайлсхийх үүднээс Банк өөрийн бодлого, журамдаа тархагдсан багцтай байх удирдамжийг тусгасан байдаг. Улмаар зээлийн төвлөрлийн эрсдэлийг Банк тогтмол хянаж удирддаг. Монголбанк нь дараах зохистой харьцааг тогтоож, биелүүлэхийг шаарддаг. Үүнд:

- Нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд олгох нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн нийлбэр дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрэхгүй.
- Банк холбогдох этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад хөрөнгийн дүн нь Банкны өөрийн хөрөнгийн 5%-аас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-аас тус тус хэтрэхгүй.

Банкны бодлого нь эх үүсвэрийн төвлөрлийн хэмжээтэй уялдуулсан хөрвөх чадварын хүрэлцээтэй байхыг шаарддаг.

30.2 Зээлийн эрсдэл

Банкны харилцагч, үйлчлүүлэгч, зээлдэгчид нь зээлийн хүү, үндсэн төлбөрийг төлөх чадваргүй болох эсвэл төлөхийг хүсэхгүй байх, зээлийн гэрээний болон бусад санхүүгийн хэрэгслүүдтэй холбоотой үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлийг зээлийн эрсдэл гэдэг. Банк нь зээлийн өргөдлүүдийг анхааралтай хянах, эрсдэлийн түвшинд тохируулсан хүүний хувь хэмжээг тогтоох, харилцагч талуудыг газарзүйн байршил, аж үйлдвэрийн салбараар ангилан зээлийн эрсдэлд өртөх түвшинд хязгаар тогтоох зэргээр зээлийн эрсдэлд хяналт тавьдаг.

Банк нь харилцагч талуудын зээлжих чадварт орж болзошгүй өөрчлөлт (барьцаа хөрөнгөө тогтмол шинэчлэх гэх мэт)-ийг эртнээс олж таних зорилгоор зээлийн чанарын хяналтын процессыг нэвтрүүлсэн билээ. Зээлийн чанарын хяналтын процесс нь Банкинд болзошгүй алдагдлыг тодорхойлох, засах арга хэмжээнүүдийг эрт авах боломжийг олгодог. Банк зээлийн үйл ажиллагааг сайжруулахын тулд зээлийн журам зааврыг олон улсын стандарт болон Монголбанкны хэрэгжүүлж буй эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн тогтмол шинэчлэн сайжруулдаг.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл

Банк нь баталгаа, батлан даалт гаргадаг. Улмаар банк харилцагчийн өмнөөс төлбөр төлөх үүргийг хүлээдэг. Харилцагчийн өмнөөс төлбөр төлсөн тохиолдолд баталгаа батлан даалтын нөхцөл дээр тулгуурлан харилцагчдаас эргүүлэн татдаг. Эдгээр нь Банкинд зээлтэй нэгэн адил эрсдэлийг учруулах ба түүнийг мөн зээлийн үйл ажиллагааны бодлого, журмаар зохицуулдаг.

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Чанаргүйдэл, үнэ цэнийн бууралт ба сайжруулалтын тодорхойлолт

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн эсвэл Банк зээлдэгчийн барьцаа хөрөнгийг борлуулах замаар эргэн төлөлтийг гүйцээх магадлалтай бүх тохиолдолд тухайн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай гэж үзэн хүлээгдэж буй алдагдлыг тооцдог.

Харилцагчдын санхүүгийн хэрэгслийг чанарын үнэлгээгээр үнэлж зээлийг “үнэ цэнийн бууралттай” гэж үзэх болон эргэн төлөгдөхгүй байх магадлалуудыг Банк авч үздэг. Энэ тохиолдолд Банк харилцагчийн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай эсэхийг нарийвчлан шинжилж хүлээгдэж буй алдагдлыг 2-р шатлал эсвэл 3-р шатлалын алинд нь тооцоологдохыг тодорхойлох замаар үнэлгээг хийнэ. Чанарын үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үздэг. Үүнд:

- Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**30.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)****Үнэ цэнийн бууралтын үнэлгээ (үргэлжлэл)*****Чанаргүйдэл, үнэ цэнийн бууралт ба сайжруулалтын тодорхойлолт (үргэлжлэл)***

- Дараах нөхцөлөөр зээлдэгч нь санхүүгийн бэрхшээлтэйг улмаас зээлийн бүтцэд өөрчлөлт оруулсан:
 - 90-ээс дээш хоногоор хүүний тооцооллыг зогсоосон
 - Зээлийн үндсэн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулж ирэх 12 сарын нийт зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт нь анхны эргэн төлөлтийн хуваариас 50%-аар буурсан
 - Зээлийн эргэн төлөгдөх хугацааг анхны хугацаатай харьцуулахад 12 сараас дээш хугацаагаар сунгасан
 - Зээлийн хүүний болон үндсэн төлөлтийн эргэн төлөлтийн хуваарь болон хүүний түвшинд өөрчлөлт оруулсан нь анхны зээлийн гэрээгээр хүлээсэн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг 10%-иас дээш хувиар бууруулсан
- Зээлдэгч нь дампуурлаа зарласан эсвэл дампуурлын үйл ажиллагааг эхлүүлсэн.
- Тайлагналын өдрөөр үнэ цэнийн бууралттай (үл төлөгдөх) гэж үзэх шинж тэмдэг байгаа үед зээлдэгчийн бусад санхүүгийн хэрэгслүүдийг 3-р шатлалд ангилна. Үүний зэрэгцээ, нэг зээлдэгчид олгосон өөр өөр салбарын зээлүүдийг (“байгууллагад олгосон бизнесийн зээл” болон “хуулийн этгээдэд олгосон төслийн зээл”) тусад нь авч үзэхгүй.

Үл төлөгдөх магадлалд орох эсэх шалгууруудын хүчин зүйл нь дараалсан зургаан сар үргэлжлэн илрээгүй бол санхүүгийн хэрэгслийг "үнэ цэнэ сайжирсан" гэж үзэн 3-р шатлалаас шилжүүлэх эсэхийг Банк өөрийн бодлогоор зохицуулна. Хөрөнгийн зээлийн үнэлгээ сайжирсны улмаас 1-р шатлал болон 2-р шатлалд дахин ангилах эсэх шийдвэр нь тухайн зээлийн болон зээл олгох үеийн дотоод үнэлгээтэй харьцуулахад эрсдэл хэрхэн өөрчлөгдсөн байгаагаас хамаарна.

Банкны дотоод үнэлгээний систем болон ЧМ-ын тооцоолол

Банкны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь дотоод үнэлгээний загварыг гаргадаг. Энэхүү загварууд нь чанарын болон тоон мэдээллийг агуулдаг бөгөөд зээлдэгчийн онцлог мэдээллээс гадна зээлдэгчийн зан төлөвт нөлөөлж болох гаднын нэмэлт мэдээллийг ашигладаг. Хэрэв боломжтой бол Банк нь олон улсын үнэлгээний байгууллагууд (Мүүдийс, Фитч, гэх мэт)-ын мэдээллийг аль шатлалд хөрөнгийг ангилах эсэхээ шийдэхдээ ашигладаг.

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа төлбөрийн чанаргүйдлийн магадлалыг (ЧМ) тооцохдоо түүхэн мэдээллүүд дээр үндэслэн тооцох бөгөөд холбогдох макро эдийн засгийн хүчин зүйлсийг ашиглан урьдчилан таамаглалын тохируулгыг хийнэ. ЧМ нь нөхцөлт ЧМ гэж тодорхойлогддог бөгөөд энэ нь өмнөх хугацаанд тухайн дансны хувьд хийгдсэн бүрэн ба хэсэгчилсэн төлөлтийг харгалзан үзэж ЧМ муруйг бий болгодог. Түүнчлэн, Банк ЧМ муруйг янз бүрийн хугацааны хувьд тооцоолохын тулд “кохорт” дүн шинжилгээг ашигладаг.

Хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа

Банкны хөрөнгө зохицуулалт, арилжаа ба банк хоорондын харилцаа болон хамтрагч талуудад санхүүгийн байгууллагууд, банк, брокер-дилерүүд, хөрөнгийн биржүүд болон клиринг төвүүд багтана. Банкны Хөрөнгө зохицуулалтын газраас олон улсын үнэлгээний агентуудын (тухайлбал, Мүүдис) нийтэд нээлттэй гадаад мэдээлэлд дүн шинжилгээ хийж дотооддоо үнэлгээ өгөх замаар дээр дурдсан харилцаануудаа зохицуулдаг.

Бизнесийн зээл

Бизнесийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ харилцагчийн санхүүгийн түүхэн, одоо, ирээдүйн нөхцөл байдлыг харгалзан үздэг. Үүнд:

- Харилцагчийн санхүүгийн төсөөлөл болон түүхэн мэдээлэл. Энэхүү санхүүгийн мэдээлэл нь харилцагчийн санхүүгийн гүйцэтгэлийн хэрэгжилт, хүлээгдэж буй үр дүн, төлбөрийн чадварын харьцаа, хөрвөх чадварын харьцаа болон бусад холбогдох санхүүгийн чадамжийг үнэлэх харьцаануудыг агуулна. Эдгээр үзүүлэлтүүдийн зарим нь үйлчлүүлэгчидтэй хийсэн гэрээнүүд дээр тулгуурласан байдаг тул илүү анхаарч авч үздэг.
- Харилцагчдын талаарх бусад эх сурвалжаас гаралтай нийтэд нээлттэй мэдээлэл.
- Макро-эдийн засгийн болон геополитикийн аливаа мэдээлэл
- Банкны гүйцэтгэлд хамаарах харилцагчийн менежментийн чанар, ур чадварын талаарх бодитой мэдээлэл

Үнэлгээний арга барилын цар хүрээ нь зээлийн хэмжээ болон харилцагчийн хэмжээнээс шалтгаалан өөр өөр байдаг. Зарим бизнесийн зээл нь жижиг бизнест зориулсан Банкны дотоод загвараар үнэлэгддэг.

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Хэрэглээний болон орон сууцны зээл

Хэрэглээний зээлд иргэдийн бүх төрлийн хэрэглээний зээл, кредит карт болон орон сууцны зээлүүд багтдаг. Эдгээр зээлийн бүтээгдэхүүнүүд болон зарим жижиг бизнесийн зээлийн эрсдэлийн үнэлгээг зээлдэгчийн хугацаа хэтрэх магадлалыг тодорхойлох аргачлалаар үнэлдэг. Үүнд: хүн ам зүй, зээл хүсэгчийн зээлийн түүх, барьцаа хөрөнгө, одоогийн орлогын түвшин, дансны орлогын өөрчлөлт, өр төлбөрийн үлдэгдэл болон хүссэн зээлийн нөхцөл зэргийг харгалзан үздэг.

Банкны дотоод үнэлгээ

Санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарыг Банк дотооддоо боловсруулсан зээлийн үнэлгээг ашиглан удирддаг. Зээлийн багц бүрийн эрсдэлийн үнэлгээг үнэн зөв, нэгэн жигд байлгах нь Банкны бодлого юм. Энэ нь холбогдох эрсдэлийн удирдлага, болон зээлийн эрсдэлийг зээлийн бүтээгдэхүүний төрөл бүрээр харьцуулах боломжийг олгодог. Үнэлгээний систем нь санхүүгийн болон статистикийн олон төрлийн дүн шинжилгээнүүдээс бүрдэх бөгөөд үүнд багцын ба зах зээлийн мэдээллүүд нэгтгэгдэж, харилцагч талын эрсдэлийг хэмжих гол хүчин зүйл болдог. Эрсдэлийн бүх түвшинг олон төрлийн зээлд нийцүүлэн боловсруулсан бөгөөд үл төлөлтийн эрсдэлийн зэргийг, зээлийн барьцаа хөрөнгө байгаа эсэх эсвэл бусад зээлийн эрсдэлийг бууруулах аргыг харгалзан Банкны үнэлгээний бодлогын дагуу гаргадаг. Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаанаас бусад санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарыг Мүүдисийн үнэлгээ, Стандарт & Поорсийн эсвэл Фитч үнэлгээний дагуу ангилдаг.

Банкны дотоод үнэлгээ

Дотоод үнэлгээ	Дотоод үнэлгээний тайлбар	Олон улсын үнэлгээ
А	Маш сайн	A- to AA+
Б	Сайн	BBB- to BBB+
В	Хэвийн бус	B- to BB+
Г	Хугацаа хэтэрсэн	Саа-С
Д	Үнэ цэнэ буурсан	–
Үнэлэгдээгүй	Үнэлэгдээгүй	–
Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан	Тусгай үнэлгээгээр үнэ цэнэ буурсан	–

Чанаргүйдэлд өртөх дүн (“ЧӨД”)

Чанаргүйдэлд өртөх дүн нь (ЧӨД) харилцагчийн алдагдал хүлээх дүн болон эрт эргэн төлөлт хийх чадвар зэргийг харгалзан үзэж санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ буурах үед тооцсон бодит хэмжээг хэлнэ. Зээлийн карт болон бусад зээлийн шугамын чанаргүйдэлд өртөх дүнг тодруулга 2.4-өөс харна уу.

1-р шатлалд буй зээлийн ЧӨД-г тооцоолохдоо Банк нь 12 сар дотор үүсэж болох чанаргүйдэх тохиолдлыг 12 сарын ЗҮЦХА-г тооцоход авч үзнэ. 2-р шатлал болон 3-р шатлалуудад ЧӨД-г тодорхойлохдоо нийт хугацааны түүхэн чанаргүйдэх тохиолдлыг авч үзнэ.

12 сарын болон зээлийн хугацааны ЧӨД нь бүтээгдэхүүний төрлөөс хамааран хүлээгдэж буй төлбөрийг үндэслэн тодорхойлогддог:

- Хорогдуулсан болон нэг удаагийн эргэн төлөлттэй зээлийн, зээлдэгчийн 12 сарын хугацаанд эсвэл зээлийн хугацаанд нь төлөх гэрээний төлбөрт үндэслэнэ. Мөн түүнчлэн зээлдэгчийн хүлээгдэж буй илүү төлөлтийг тохируулж өгнө. Энэхүү тооцоололд эрт төлөлт/дахин санхүүжүүлэлтийн таамаглалыг мөн тусгаж өгнө.
- Зээлийн шугамын бүтээгдэхүүний хувьд, нийт лимитээс ашигласан хувиар ЧӨД-г тооцдог.

Чанаргүйдэхэд хүлээх гарз

Чанаргүйдэхэд хүлээх гарз (ЧХГ)-ыг ЭНУГ жил бүр үнэлдэг бөгөөд зээл чанаргүйдэхэд банкны хүлээх гарзыг ЧХГ харуулдаг. ЧХГ нь зээлдэгч, барьцаа хөрөнгийн хүрэлцээ, нэхэмжлэлийн төрөл болон хугацаанаас хамааран өөр өөр байна. ЧХГ нь чанаргүйдэхэд нэгжид ногдох алдагдлын хувиар илэрхийлэгддэг.

ЧХГ-ыг 12 сар эсвэл гэрээний нийт хугацаагаар тооцдог. Дараагийн 12 сард чанаргүйдвэл хүлээх гарзын хувийг 12 сарын ЧХГ-аар, харин зээлийн үлдэгдэл хугацааны туршид гарах алдагдлын хувийг зээлийн хугацааны ЧХГ-аар илэрхийлдэг.

ЧХГ нь барьцааны үнэ болон төлөлтөөс хамааран хугацааны туршид өөрчлөгдөж байдаг. ЧХГ -ийн коэффициентын гол элементүүд нь:

- Цагийн хэмжээс (ЧӨД параметрийг баталгаатай, баталгаагүй хэсэгт хуваах) ба
- Барьцаа хөрөнгийн үнэ цэнэ өөрчлөгдөхөд (үл хөдлөх хөрөнгө гэх мэт барьцааны тохиолдолд үнэ нь өөрчлөгдөхгүй хэвээр байж болно)

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)**30.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)*****Чанаргүйдэхэд хүлээх гарз (үргэлжлэл)***

Санхүүгийн хэрэгсэлд барьцаа хөрөнгө байхгүй, үл төлөлтийн түүхэн өгөгдөл хангалттай байгаа тохиолдолд банк мэргэжилтний дүгнэлт гаргадаг. Тайлангийн өдрөөрх нөхцөл байдал, өгөгдлийн бүрэн гүйцэд байдлаас хамааран Банк ЧХГ-ийн коэффициентын үе шатыг тодорхойлохын тулд түүхэн өгөгдлөө эсвэл гадаад эх сурвалжаас авсан түүхэн өгөгдлийг ашигладаг.

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт

Банк нь ЗҮЦХА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянадаг. Тухайн нэг санхүүгийн хэрэглүүр эсвэл багц хэрэглүүр нь 12 сарын ЗҮЦХА эсвэл нийт хугацааны ЗҮЦХА-т хамаарах эсэхийг тодорхойлохын тулд Банк нь уг хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг үнэлдэг.

Банк нь гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн тохиолдолд чанарын шинжилгээ хийдэг. Зарим тохиолдолд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн шалтгааныг чанаргүйдэл бус “Чанаргүйдлийн тодорхойлолт”-д дурдагдсан үйл явдлуудтай холбож тайлбарладаг. Зээлийн ангиллын өөрчлөлтийг үл харгалзан 30 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөн байна гэж үздэг.

Ижил төстэй бүлэг хөрөнгүүдийн ЗҮЦХА-г тооцохдоо, анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг шинжлэхдээ ижил арга, аргачлалуудыг ашигладаг.

Бүлгийн үнэлгээгээр санхүүгийн хөрөнгүүдийг ангилах нь

Доорх хүчин зүйлээс хамаарч “ЗҮЦХА зарчмуудын тойм” 2.4-т тайлбарласнаар Банк нь ЗҮЦХА -ын нөөцийг бүлгийн болон тусгай үнэлгээгээр тооцдог.

Банк нь ЗҮЦХА -ийг тусгай үнэлгээгээр тооцоолох хөрөнгийн ангилалд зээлийн багц үл хамааран үлдэгдэл балансаар эхний 40 эсвэл зээлийн багцаас үл хамааран 500 сая төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 3-р шатны зээлдэгч нар орно.

Банк нь ЗҮЦХА -ийг бүлгийн үнэлгээгээр тооцоолох үед тусгай үнэлгээнд ороогүй бүх зээлийг оруулна. Банк нь зээлийн зориулалт, бүтээгдэхүүнээс хамааран доорх жижиг багцуудад ангилдаг.

- Бизнесийн зээлүүд
- Хэрэглээний зээлүүд
- Орон сууцны зээлүүд

ЗҮЦХА -ын загварын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь – Ирээдүйн мэдээлэл

Банк нь ЧМ болон ЗҮЦХА-г тооцоолохдоо ирээдүйг илтгэх мэдээллийг ашиглан ирээдүйн макро эдийн засгийн өөрчлөлт ЗҮЦХА-д хэрхэн нөлөөлж болохыг харгалзаж үздэг. Энгийн шугаман хамаарлын аргыг ашиглан ажиглагдахуйц чанаргүйдлийн/дефолтын хувь болон макро эдийн засгийн хүчин зүйл хоорондын харилцан хамаарлыг тооцдог. Ашигласан мэдээллийн багцад зээлийн бүтээгдэхүүн бүрд хамаарах ЧМ болон голлох макро хүчин зүйлүүдийн улирал бүрийн мэдээллүүд ордог болно. Макро эдийн засгийн хүчин зүйлийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны мэдээллийн сангаас тагддаг бол ЧМ хувь нь банкны дотоод мэдээллийн сангаас болон Мүүдийс зэрэг олон улсын үнэлгээний байгууллагуудаас гаргасан түүхэн мэдээллийг ашигладаг. Банкны хувьд бизнесийн зээлд дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляцын түвшин, ажилгүйдэл ба ам долларын ханш, орон сууцны зээлд инфляцын түвшин болон өрхийн хэрэглээ, хэрэглээний зээлд өрхийн хэрэглээ, экспорт, ажилгүйдлийн түвшин болон мөнгөний нийлүүлэлт зэрэг макро эдийн засгийн хүчин зүйлсийг ашигладаг.

Арга зүйн хувьд, эхлээд оновчтой макро эдийн засгийн хүчин зүйлүүдийг урьдчилан сонгохдоо шугаман хамаарлын шинжилгээ хийсэн ба дараа нь коэффициентуудыг энгийн регрессийн шинжилгээ ашиглан тооцоолсон. Тооцооллын үр дүнд гарсан коэффициентууд болон таамаглалуудаас ЧМ-д хамаарах ирээдүйн талаарх мэдээлэл хүчин зүйлүүдийг тохируулан авч үзсэн тул урьдчилсан чанаргүйдлийн хувь болон түүхэн дундаж чанаргүйдлийн хувийн харьцааг ЧМ болгон авч үзсэн. Эдгээр тохируулга нөлөөлөгч хүчин зүйлс болон тохируулсан ЧМ хувиуд нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн талаар хамгийн бодитой төсөөлөл өгч чадна гэж үзсэн тул ЗҮЦХА загварын суурь төсөөлөл болно. Сайн болон муу төсөөллүүдийг тухайн загвараар таамагласан чанаргүйдлийн хувь дахь түүхэн тохируулагч хүчин зүйлүүдийг үндэслэн тооцсон ба тохируулагч хүчин зүйлийн тархалтыг тодорхой тоонуудаар хэмжсэн. Төсөөлөл бүрийн ЗҮЦХА-г тухайн төсөөлөлд хамаарах ЧМ хувьд үндэслэн тооцсон бол бодит ЗҮЦХА-г дээрх гурван төсөөллийн дараах пропорцоор жигнэсэн дунджаар авсан байна. Үүнд: сайн төсөөллийн 10%, муу төсөөллийн 30% ба суурь төсөөллийн 60%.

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

ЗҮЦХА -ын загварын өгөгдөлд дүн шинжилгээ хийх нь – Ирээдүйн мэдээлэл (үргэлжлэл)

Доорх хүснэгтээр тохируулгын коэффициентийг 3 төсөөллөөр харууллаа:

2022 оны 12-р сарын 31-нээр

	Бизнесийн зээл	Орон сууцны зээл	Хэрэглээний зээл
Муу төсөөлөл	1.0207	1.1493	1.0136
Суурь төсөөлөл	1.0144	1.0892	1.0127
Сайн төсөөлөл	1.0081	1.0292	1.0119

2021 оны 12-р сарын 31-нээр

Муу төсөөлөл	1.0128	1.0058	1.0098
Суурь төсөөлөл	1.0102	1.0050	1.0087
Сайн төсөөлөл	1.0077	1.0032	1.0083

Бүтцийн өөрчлөлт орсон зээлийн тойм

Эрсдэлийн удирдлагын үүднээс зээлд бүтцийн өөрчлөлт орсон бол Банкны тусгай хөрөнгийн хэлтэс нь зээлийг эргэн төлөгдөх хүртэл хяналт тавьдаг.

Доорх хүснэгтэд бүтэц өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгө нийт дансны дүн болон холбогдох ЗҮЦХА-г 2022 оны 12 сарын 31-нээр харуулав:

**2022
мян.төг**

Бүтэц өөрчлөгдсөн зээлүүд:

Дансны нийт үнэ	4,684,328
Холбогдох ЗҮЦХА	6,906

Эргэн төлөлтийн хойшлуулалт, баталгаатай зээл болон бусад дэмжлэг

Ковид-19-ийн улмаас Монгол Улсын Засгийн газраас зээлийн төлбөрийг тодорхой шалгуургүйгээр бүх зээлдэгчдэд хойшлуулах арга хэмжээ авсан. Зээлийн бүтэц өөрчлөлттэй холбоотой гарз нь материаллаг бус байсан.

Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем, шатлалыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 13, 14, 15 ба 17-р тодруулгаас харна уу.

Дараах хүснэгтэд Банкны харилцагчдад олгосон зээл, урьдчилгааг (Тодруулга 17) аж үйлдвэрийн салбараар нь ангилан, нийт дүнгээр (зээлийн барьцаа хөрөнгө эсвэл зээлийн чанарыг сайжруулах бусад зүйлүүдийг авч үзэхээс өмнөх нь) үзүүлэв:

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Эрсдэлийн төвлөрлийн шинжилгээ (үргэлжлэл)

	Нийт багцын хэмжээ			
	2022		2021	
	мян.төг	%	мян.төг	%
Барилга	40,200,742	19%	23,668,354	16%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	44,737,714	21%	39,448,850	26%
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	33,978,508	16%	24,197,022	16%
Цахилгаан эрчим хүч, шатахуун	137,293	0%	100,088	0%
Боловсрол	490,233	0%	325,655	0%
Санхүү болон даатгалын үйл ажиллагаа	14,467,125	7%	8,917,691	6%
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	526,474	0%	621,233	0%
Бусад	7,566,785	4%	1,955,898	1%
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5,731,629	3%	3,496,943	2%
Эрүүл мэндийн үйлчилгээ	1,183,837	1%	967,687	1%
Боловсруулах үйлдвэрлэл	10,516,064	5%	11,304,588	8%
Урлаг үзвэр, тоглоом наадам	1,322,989	1%	1,605,903	1%
Зочид буудал, байр сууц, хоолны үйлчилгээ	1,344,056	1%	836,702	1%
Мэдээлэл холбоо	1,013,970	0%	1,314,163	1%
ХАА, ойн аж ахуй, ан агнуур	1,393,898	1%	698,095	0%
Хэрэглээ	45,921,852	22%	29,701,752	20%
Бусад	891,266	0%	1,243,605	1%
Нийт	211,424,435	100%	150,404,229	100%

Зээлийн барьцаа хөрөнгө ба бусад сайжруулалтууд

Шаардлагатай барьцаа хөрөнгийн үнэлгээний дүн болон төрөл нь зээлдэгч болон харилцагчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ ба олгох зээлийн төрлөөс хамаарна. Барьцаанд авсан хөрөнгийн гол төрлүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- Байгууллагуудад олгосон зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үйлдвэр ба тоног төхөөрөмж, машин механизм;
- Жижиг бизнесийн зээлийн хувьд үл хөдлөх хөрөнгө, бараа материал
- Хэрэглээний зээлийн хувьд автомашин, санхүүжилтийн орлого, болон үл хөдлөх хөрөнгө, гэх мэт;
- Орон сууц худалдан авах зээлийн хувьд орон сууц;

Банк нь барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тогтмол хянаж байдаг ба тухайн гэрээний дагуу шаардлагатай үед нэмэлт барьцаа хөрөнгө гаргуулахаар хүсэлт тавьдаг.

Банкны журмаар өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгүүдийг Банк нь зохион байгуулалттайгаар борлуулдаг. Хөрөнгийг борлуулснаас орж ирсэн орлогыг зээлийн үлдэгдэл төлбөрийг багасгах эсвэл төлж дуусгахад зориулна. Банк нь өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийг өөрийн бизнесийн хэрэгцээнд ашигладаггүй.

Банк дотооддоо хэрэглэдэг зээлийн үнэлгээний систем ба жилийн эцсийн шатлалын ангиллыг ашиглан гаргасан зээлийн чанар болон зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнтэй холбоотой тодруулгуудыг 13, 14, 15 ба 17-р тодруулгаас харна уу. Санхүүгийн хэрэгслүүд нь бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг санхүүгийн хэрэгслүүдийн хувьд тодруулга 15-д, ирээдүйн үнэлгээний өөрчлөлтөөс үүдэн гарах зээлийн эрсдэлд өртөж болох хамгийн их дүнг бус харин одоогийн байгаа зээлийн эрсдэлийг харуулсан.

Банкны харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны барьцааг доор харуулав.

	Дансны үнэ мян.төг	Барьцааны дүн мян.төг
2022 оны 12 сарын 31		
Бизнесийн зээл	136,964,414	530,265,456
Хэрэглээний зээл	53,441,097	91,255,412
Орон сууцны зээл	21,018,924	39,786,723
	211,424,435	661,307,591
2021 оны 12 сарын 31		
Бизнесийн зээл	104,681,839	239,273,839
Хэрэглээний зээл	23,130,141	51,201,440
Орон сууцны зээл	22,592,249	31,663,823
	150,404,229	322,139,102

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон тогтворгүй нөхцөл байдалд харилцагчийн өмнө хүлээсэн төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэж чадахгүй байвал Банк төлбөрийн чадварын эрсдэлд орно. Уг эрсдэлийг хязгаарлахын тулд удирдлага нь өөрийн үндсэн харилцах, хадгаламжийн эх үүсвэрээс гадна олон төрлийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн ба ирээдүйн мөнгөн урсгал болон төлбөрийн чадвараа өдөр тутам хянаж байдаг. Үүний тулд нэмэлт эх үүсвэр шаардагдсан үед ашиглагдах өндөр үнэлгээтэй барьцаа хөрөнгийн бэлэн байдал болон хүлээгдэж буй мөнгөн урсгал зэргийн үнэлгээ хийхийг шаарддаг. Богд банк нь Монголбанкнаас тогтоосон Төлбөрийн чадварын шаардлагаас илүү хэмжээтэй түргэн борлогдох активыг байнга барьж байдаг. Үүнээс гадна харилцагчдын нийт харилцах, хадгаламжийн 6%- 18%-тай тэнцэх бэлэн мөнгийг Монголбанкинд заавал байршуулж байх ёстой.

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

Дараах хүснэгтэд 2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн өр төлбөр болон хөрөнгийн дуусгавар хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүрэг дээр үндэслэн харууллаа. Гэсэн хэдий ч, Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдөл дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

	Хугацаагүй мян.төг	3 сараас доош мян.төг	3-аас 6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-ээс 5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12 сарын 31-нээр							
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	35,347,220	92,680,284	–	–	–	–	128,027,504
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	7,734,687	43,519,476	–	–	–	–	51,254,163
Санхүүгийн хөрөнгө оруулалт	–	10,714,069	10,425,754	7,200,848	34,317,264	26,712,894	89,370,829
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	–	–	–	–	433,677	–	433,677
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	446,408	51,817,638	34,572,279	58,016,792	150,448,993	35,099,184	330,401,294
Бусад санхүүгийн хөрөнгө	1,825,000	923,727	–	–	–	–	2,748,727
	45,353,315	199,655,194	44,998,033	65,217,640	185,199,934	61,812,078	602,236,194
Бусад банкны харилцах, хадгаламж	43,361,601	–	–	–	–	–	43,361,601
Репо хэлцэл	–	11,596,499	11,634,156	11,813,781	35,234,832	–	70,279,268
Харилцагчдын харилцах, хадгаламж	65,619,104	51,292,878	36,375,435	63,628,108	5,839,675	–	222,755,200
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	–	53,973	42,047	81,891	71,986	–	249,897
Зээлээр авсан эх үүсвэр	–	498,442	648,469	18,147,299	10,374,098	–	29,668,308
Бусад санхүүгийн өр төлбөр	934,380	200,442	–	–	–	–	1,134,822
Түрээсийн өглөг	–	359,891	270,736	541,472	2,533,440	123,776	3,829,315
Нийт санхүүгийн өр төлбөр	109,915,085	64,002,125	48,970,843	94,212,551	54,054,031	123,776	371,278,411
2021 оны 12 сарын 31-нээр							
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	12,087,625	94,482,932	–	–	–	–	106,570,557
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	1,620,019	24,809,491	–	–	–	–	26,429,510
Санхүүгийн хөрөнгө оруулалт	–	6,249,635	1,577,937	1,853,489	14,555,967	19,116,359	43,353,387
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	379,046	29,729,160	21,195,377	37,669,052	101,301,104	40,282,388	230,556,127
Бусад санхүүгийн хөрөнгө	–	458,038	–	–	–	–	458,038
Нийт санхүүгийн хөрөнгө	14,086,690	155,729,256	22,773,314	39,522,541	115,857,071	59,398,747	407,367,619
Бусад банкны харилцах, хадгаламж	–	24,801,174	–	–	–	–	24,801,174
Репо хэлцэл	5,006,541	8,548,892	623,249	11,204,278	30,784,670	–	56,167,630
Харилцагчдын харилцах, хадгаламж	29,980,621	7,831,713	11,071,017	13,838,823	115,503,152	1,584	178,226,910
Зээлээр авсан эх үүсвэр	–	21,582	21,582	8,287,417	–	–	8,330,581
Бусад санхүүгийн өр төлбөр	360,473	626,897	636,293	1,132,317	353,177	–	3,109,157
Түрээсийн өглөг	–	201,553	201,553	403,105	3,076,628	139,255	4,022,094
Нийт санхүүгийн өр төлбөр	35,347,635	42,031,811	12,553,694	34,865,940	149,717,627	140,839	274,657,546

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.3 Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

Дараах хүснэгтэд Банкны болзошгүй өр төлбөр болон үүргийн гэрээний дагуух дуусгавар хугацааг үзүүлээ. Олгогдоогүй зээлийн амлалтыг хамгийн анх олгогдох өдрөөр нь оруулсан болно. Гаргасан баталгаануудын гэрээнүүдийн хувьд, баталгааны ихэнх дүнг баталгаатай холбоотой төлбөр гарах боломжтой хамгийн ойрын хугацаанд хуваарилсан болно.

	Хугацаагүй мян.төг	3 сараас доош мян.төг	3-аас 6 сар мян.төг	6 сараас 1 жил мян.төг	1-ээс 5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12 сарын 31-нээр							
Санхүүгийн баталгаа	12,965,601	2,725,056	6,000	1,345,123	175,371	–	17,217,151
Бусад олгогдоогүй зээлийн амлалт	606,487	520,100	1,135	181,063	3,915,721	–	5,224,506
Нийт баталгаа болон амлалт	13,572,088	3,245,156	7,135	1,526,186	4,091,092	–	22,441,657
2021 оны 12 сарын 31-нээр							
Санхүүгийн баталгаа	13,620,349	106,623	722,946	–	–	–	14,449,918
Бусад олгогдоогүй зээлийн амлалт	99,355	–	–	–	–	–	99,355
Нийт баталгаа болон амлалт	13,719,704	106,623	722,946	–	–	–	14,549,273

30.4 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь банкны балансын болон балансын гадуурх үр дүнд зах зээлийн өөрчлөлтийн улмаас тухайлбал хүүний түвшин, гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн удирдлага нь санхүүгийн байдлын тайлангийн хамгийн үр ашигтай бүтцийг бий болгож, түүгээрээ дамжуулан хамгийн өндөр хүүний үр ашиг хүртэх зорилготой байдаг.

Хүүний түвшний эрсдэл

Хүүний түвшний өөрчлөлтөөс банкны санхүүгийн үзүүлэлтийн үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгалд өөрчлөлт орж хүүний эрсдэл бий болдог. Банкинд зээлийн болон санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд нь хүүний эрсдэлийг бий болгодог. Хүүний хувь хэмжээний өөрчлөлт нь Банкны хүүний цэвэр орлогод тэр даруй нөлөөлдөг бол урт хугацаанд Банкны өөрийн хөрөнгөд нөлөөлдөг (Банкны хөрөнгө, өр төлбөр, тэнцлийн гадуурх зүйлсийн эдийн засгийн үнэ цэнд нөлөөлөх учраас). Тодорхой хугацаанд байж болох хүүний хувь хэмжээний өөрчлөлтийн хязгаарыг Банкны удирдлага тогтоож өгдөг. Позичуудыг өдөр бүр хянаж байдаг ба хейджинг стратеги хэрэгжүүлэх замаар позицийг тогтоосон хязгаарын хүрээнд удирдаж ажилладаг.

Дараах хүснэгтэд Банкны орлогын тайлангийн зүйлүүдийн, бусад бүх хувьсагчууд тогтмол байх үед хүүний хувь хэмжээний зохистой, боломжит өөрчлөлтүүдэд үзүүлэх мэдрэмжийг харуулав. Орлогын тайлангийн мэдрэмж гэж нэг жилийн хүүний цэвэр орлогод хүүний өөрчлөлт (2022 оны 12 дугаар сарын 31 ба 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хөвөгч хүүний өөрчлөлт)-ийн үзүүлэх нөлөөллийг хэлнэ.

Валют	Өсөлт/Бууралт	Цэвэр хүүний орлогын мэдрэмж	
		2022 мян.төг	2021 мян.төг
Төгрөг	+/-100	+/-162,533	+/-107,573
Ам.доллар	+/-100	+/-107,675	+/-58,452
Бусад	+/-100	+/-550	+/-3,864

Гадаад валютын эрсдэл

АПУХ-оос гадаад валютын ханшаас хүлээж болзошгүй алдагдалд лимит тогтоодог ба хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажилладаг. Банк нь Монголбанкнаас тогтоосон гадаад валютын нээлттэй позицитай зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах болон гадаад валютын ханшийн хөдөлгөөн Банкны төлбөрийн чадвар, ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлж буйг үнэлэх аргаар гадаад валютын эрсдэлийг удирддаг. Үүнээс гадна Банк нь гадаад валютын эрсдэлийг удирдахдаа VaR загварыг хэрэглэж байна. АПУХ улирал бүрийн валютын позицитай алдагдлын хязгаарыг тогтоодог. Зах зээлийн эрсдэлийн удирдлага батлагдсан лимитийн хэмжээнд гадаад валютын үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг хянаж байдаг.

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

‘VaR’ аргачлалын зорилго, төсөөлөл, хязгаарлалтууд

VaR нь зах зээлийн үнэ ба үнийн ирээдүйн хөдөлгөөн нь статистик тархалттай байна гэж үздэг, мөн зах зээлийн үнийн түүхэн корреляци ба огцом өөрчлөлтүүд дээр суурилдаг учраас энэ аргыг хэрэглэхэд зарим нэг хязгаарлалтууд байдаг. VaR арга нь мэдээллийг гаргахдаа түүхэн өгөгдлүүд дээр их тулгуурладаг, эрсдэлийн хүчин зүйлүүдийн ирээдүйн өөрчлөлт ба хөдөлгөөнийг тодорхой харуулж чаддаггүй зэргийн улмаас хэрэв эрсдэлийн хүчин зүйлүүдийн өөрчлөлт нь хэвийн тархалттай байна гэсэн төсөөллөөс зөрвөл, зах зээлийн том хөдөлгөөний магадлалыг дутуу үнэлж болно. Эрсдэлийн хүчин зүйлүүд ба тодорхой нэг хэрэгслүүдийн хувьд тэдгээр хүчин зүйлүүдийн хоорондын хамаарлын талаар хийсэн төсөөллүүдийн улмаас VaR нь дутуу эсвэл илүү тооцоолж болно.

Позицууд нь өдрийн туршид өөрчлөгдөөгүй байсан ч VaR нь зөвхөн ажлын өдөр дуусах үеийн байдлаарх багцын эрсдэлийг илэрхийлдэг ба 99 хувийн итгэлцлийн түвшнээс давсан аливаа нэг алдагдлыг тооцож үздэггүй. VaR-ын хязгаар ба алдагдлын хэмжээ нь удирдлагаас тогтоож өгсөн хязгаарт байгаа эсэхийг тогтмол шалгаж үздэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хэрэгсэл дээр нэг өдрийн хугацаанд гарч болох алдагдлын хэмжээг VaR аргаар тооцоолж гаргасныг дор үзүүлэв.

	Түүхэн загвар	
	2022	2021
	мян.төг	мян.төг
12 сарын 31-ний өдөр	99,378	118,406
Өдрийн дундаж	4,961	6,242
Дээд хэмжээ	85,409	173,225
Доод хэмжээ	15,257	879

Дараах хүснэгтэд Банкны гадаад валютын эрсдэлийг 2022 болон 2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

	Төгрөг	Ам.доллар	Бусад	Нийт
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2022 оны 12 сарын 31-нээр				
Санхүүгийн хөрөнгө				
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	92,511,610	14,040,738	21,423,562	127,975,910
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	20,016,544	26,504,345	4,721,024	51,241,913
Санхүүгийн хөрөнгө оруулалт	30,819,687	38,805,776	–	69,625,463
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	433,677	–	–	433,677
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	206,805,391	1,799,802	–	208,605,193
Бусад санхүүгийн хөрөнгө	2,591,118	–	–	2,591,118
Нийт	353,178,027	81,150,661	26,144,586	460,473,274
Санхүүгийн өр төлбөр				
Бусад банкны харилцах, хадгаламж	23,277,265	–	20,070,639	43,347,904
Репозитив	65,471,192	–	–	65,471,192
Харилцагчдын харилцах, хадгаламж	131,118,023	81,072,841	5,051,570	217,242,434
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	62,118	–	–	62,118
Зээлээр авсан эх үүсвэр	12,897,018	14,240,606	–	27,137,624
Түрээсийн өглөг	2,955,777	–	–	2,955,777
Бусад санхүүгийн хөрөнгө	1,134,822	–	–	1,134,822
Нийт	236,916,215	95,313,447	25,122,209	357,351,871

30. Эрсдэлийн удирдлага (үргэлжлэл)

30.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

	Төгрөг мян.төг	Ам.доллар мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12 сарын 31-нээр				
Санхүүгийн хөрөнгө				
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	102,030,489	3,413,439	867,536	106,311,464
Бусад банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	13,873,151	11,587,116	961,394	26,421,661
Санхүүгийн хөрөнгө оруулалт	26,599,467	10,070,319	–	36,669,786
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	141,146,689	6,764,228	–	147,910,917
Бусад санхүүгийн хөрөнгө	283,949	–	–	283,949
Нийт	283,933,745	31,835,102	1,828,930	317,597,777
Санхүүгийн өр төлбөр				
Бусад банкны харилцах, хадгаламж	13,823,180	10,970,453	–	24,793,633
Репо хэлцэл	49,712,396	–	–	49,712,396
Харилцагчдын харилцах, хадгаламж	117,914,733	18,040,486	1,159,054	137,114,273
Зээлээр авсан эх үүсвэр	8,212,568	–	–	8,212,568
Түрээсийн өглөг	2,994,860	–	–	2,994,860
Бусад санхүүгийн хөрөнгө	2,935,202	–	–	2,935,202
Нийт	195,592,939	29,010,939	1,159,054	225,762,932

Урьдчилсан төлбөрийн эрсдэл

Урьдчилсан төлбөрийн эрсдэл гэдэг нь Банкны үйлчлүүлэгч ба харилцагч нь хүлээж байснаас өмнө эсвэл хойно төлбөрөө хийх эсвэл төлбөр хийхийг хүссэний улмаас Банк санхүүгийн алдагдалд орох эрсдэл юм.

Банк нь төрөл бүрийн түвшний урьдчилсан төлөлтүүдийн хүүний цэвэр орлогод үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцоолохдоо хялбаршуулсан аргыг авч хэрэглэдэг. Хэрэв бусад бүх хувьсагчдыг тогтмол гэж үзэн эргэн төлөгдөх санхүүгийн хэрэгслийн 20% нь жилийн эхэнд урьдчилан төлөгдсөн бол тайлант жилийн хүүний орлого 8,753 сая төгрөгөөр буурахаар байсан. (2021: 5,342 сая төгрөг).

Үйл ажиллагааны эрсдэл

Банк үйл ажиллагааны эрсдэлийг дотоод хяналтын хангалтгүй, үр дүн муутай байдал, хүмүүсийн болон гаднын хүчин зүйлийн нөлөөллөөр учирч болзошгүй эрсдэлүүд гэж тодорхойлдог. Үүнд дотоод залилан, гадаад залилан, ажилчдын ажлын дадал болон аюулгүй байдал, бүтээгдэхүүн болон үйлчилгээний доголдол, биет хөрөнгийн гэмтэл, бизнесийн тогтворгүй байдал, дотоод үйл ажиллагааны явцын доголдол зэргийг хамруулдаг. Хууль, комплайнс болон мэдээллийн технологийн эрсдэл нь тусдаа эрсдэлийн төрөл гэж зохицуулагддаг учраас үйл ажиллагааны эрсдэлд хамаарахгүй болно. Эрсдэлийн удирдлагын хэлтэс нь үйл ажиллагааны эрсдэлийг Удирдлагын зөвлөлд болон ТУЗ-ын дэргэдэх эрсдэлийн хороонд улирал дутам тайлагнадаг.

Өмчийн хэрэглүүрийн үнийн эрсдэл

Өмчийн хэрэглүүрийн үнийн эрсдэл нь хөрөнгийн индекс болон аливаа хувьцааны үнийн түвшинд өөрчлөлт орсноор хөрөнгийн үнэ цэн буурах эрсдэл юм. Арилжааны хөрөнгийн үнийн эрсдэлийн үзүүлэлт нь “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх” гэж ангилсан өмчийн хэрэглүүрийн хөрөнгө оруулалтаас үүсдэг. 2022 оны 12-р сарын 31-нд ийм ангилал дахь Банкны хөрөнгийн үнийг 10 хувиар өсгөвөл 194 сая төгрөг (2021: 238 сая)-өөр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх байсан. Хэрэв үүнтэй тэнцүү хэмжээгээр буурсан бол эсрэгээрээ татварын өмнөх ашгийг 194 сая төгрөг (2021: 238 сая)-өөр бууруулах байсан юм. Арилжааны бус хөрөнгийн үнийн эрсдэлийн үзүүлэлт нь “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх” ангилсан өмчийн хэрэглүүрээс үүсдэг бөгөөд 31-р тодруулгад багтсан болно.

31. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн түвшинг тодорхойлох нь

Бодит үнэ цэнэ гэдэг нь дампуурсан болон албадан борлуулахад хүрсэн этгээдээс бусад аливаа сонирхож буй талуудын хооронд, санхүүгийн хэрэглүүрийн зах зээл дээр арилжаалагдах дүн юм. Зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэглүүрийн хувьд бодит үнэ цэнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно.

31. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн түвшинг тодорхойлох нь (үргэлжлэл)

Дараах хүснэгтэд бодит үнэ цэнээр бүртгэгдсэн санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн түвшнээр нь ангилан үзүүлэв:

	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12-р сарын 31				
Санхүүгийн хөрөнгө				
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр:</i>				
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бонд	5,149,809	–	–	5,149,809
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компанийн бонд	6,960,036	–	–	6,960,036
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй төв банкны үнэт цаас	–	2,669,627	–	2,669,627
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өмчийн хэрэглүүр:</i>				
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өмчийн хэрэглүүр	–	–	2,800,000	2,800,000
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдлын тайланд бүртгэгдэх өмчийн хэрэглүүр:</i>				
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй өмчийн хэрэглүүр	1,942,564	–	–	1,942,564
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө:</i>				
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, бодит үнэ цэнээр	–	8,133,535	–	8,133,535
ИЗББ – давуу болон энгийн, бодит үнэ цэнээр	–	–	7,924,953	7,924,953
ХБҮЦ – энгийн, бодит үнэ цэнээр	–	–	2,940,544	2,940,544
МБ-тай хийсэн валют, хүүний своп хэлцэл	–	371,559	–	371,559
Нийт	14,052,409	11,174,721	13,665,497	38,892,627
	Түвшин 1 мян.төг	Түвшин 2 мян.төг	Түвшин 3 мян.төг	Нийт мян.төг
2021 оны 12-р сарын 31				
Санхүүгийн хөрөнгө				
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүр:</i>				
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй Засгийн газрын бонд	9,853,400	–	–	9,853,400
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компанийн бонд, бодит үнэ цэнээр	6,225,454	–	–	6,225,454
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх өмчийн хэрэглүүр:</i>				
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өмчийн хэрэглүүр	–	–	3,300,000	3,300,000
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө:</i>				
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй өмчийн хэрэглүүр	2,379,656	–	–	2,379,656
<i>Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө:</i>				
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, бодит үнэ цэнээр	–	10,274,021	–	10,274,021
ИЗББ – давуу болон энгийн, бодит үнэ цэнээр	–	–	5,826,990	5,826,990
ХБҮЦ – энгийн, бодит үнэ цэнээр	–	–	340,354	340,354
Нийт	18,458,510	10,274,021	9,467,344	38,199,875

31. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

1, 2 болон 3 дугаар түвшний хоорондох хөдөлгөөн

Бодит үнэ цэнээр бүртгэгдсэн, санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийн 1, 2 болон 3 дугаар түвшний хооронд хөдөлгөөн гараагүй болно.

Бодит үнэ цэнийн хэмжилтэд нөлөөлөхүйц хамгийн бага түвшний өгөгдөлд үндэслэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах түвшингүүдээр ангилан толилуулдаг. Үүнд:

Түвшин 1 - Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнэ

Түвшин 2 - Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлал

Түвшин 3 - Зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ажиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлал

2022 болон 2021 оны 12-р сарын 31-ний байдлаарх 2-дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцсон аргачлал болон түүнд ашигласан мэдээлэл:

	Бодит үнэ цэнэ		Үнэлгээний Аргачлал	Ашигласан мэдээлэл
	2022 мян.төг	2021 мян.төг		
Санхүүгийн хөрөнгө				
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй төв банкны үнэт цаас	2,669,627	–	Орлогын хандлага	Мөнгөн урсгалын төсөөлөл, төгрөгийн хямдруулалтын хүү Мөнгөн урсгалын төсөөлөл, төгрөгийн бодлогын хүү, репо хүү, төв банкны үнэт цаасны хүү, z-спрэд, SOFR, төгрөг болон долларын хямдруулалтын хүү,
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	371,559	–	Орлогын хандлага	төгрөг болон долларын эрсдэлгүй хүү
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа, бодит үнэ цэнээр	8,133,535	10,274,021	Орлогын хандлага	Төлбөрийн хуваарь дээр үндэслэсэн мөнгөн урсгалын төсөөлөл, төгрөгийн хямдруулалтын хүү

2022 оны 12 сарын 31-ний байдлаар 2-дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцох аргачлалд өөрчлөлт ороогүй.

3-дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тооцоход ашигласан мэдээллийн боломжит өөрчлөлтийн бодит үнэ цэнд үзүүлэх нөлөөллийг доор харуулав:

2022 оны 12-р сарын 31	Бодит үнэ цэнэ мян.төг	Боломжит өөрчлөлт	Бодит үнэ цэнийн өөрчлөлт мян.төг	Үнэлгээний аргачлал	Ажиглагдахуйц бус мэдээлэл
Санхүүгийн хөрөнгө					
ИЗББ	7,924,953	+100bps -100bps	+22,431 -22,158	Орлогын хандлага	Төгрөгийн хямдруулалтын хүү
ХБҮЦ	2,940,544	+100bps -100bps	+49,167 -47,890	Орлогын хандлага	Төгрөгийн хямдруулалтын хүү
Хөрөнгийн биржид бүртгэлгүй өмчийн хэрэглүүр	2,800,000	+100bps -100bps	+149,648 -130,540	Орлогын хандлага	Мөнгөн урсгалын төсөөлөл, Хямдруулалтын хүү

31. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

1, 2 болон 3 дугаар түвшний хоорондох хөдөлгөөн (үргэлжлэл)

2021 оны 12-р сарын 31

Санхүүгийн хөрөнгө

ИЗББ	5,826,990	+100bps	+19,421	Орлогын хандлага	Төгрөгийн хямдруулалтын хүү
		-100bps	-20,188		
ХБҮЦ	340,354	+100bps	+3,194	Орлогын хандлага	Төгрөгийн хямдруулалтын хүү
		-100bps	-3,194		
Хөрөнгийн биржид бүртгэлгүй өмчийн хэрэглүүр	3,300,000	+100bps	+90,000	Орлогын хандлага	Мөнгөн урсгалын төсөөлөл, Хямдруулалтын хүү
		-100bps	-90,000		

2021 болон 2022 оны 12 сарын 31-ний байдлаар бодит үнэ цэнийнг тооцох аргачлалд өөрчлөлт ороогүй.

3-дугаар түвшний санхүүгийн хэрэглүүрийн хөдөлгөөнийг доорх хүснэгтүүдэд харуулав:

	2022 мян.төг	2021 мян.төг
Хөрөнгийн биржид бүртгэлгүй өмчийн хэрэглүүр		
1 сарын 1-нээр	3,300,000	3,300,000
Бодит үнэ цэнийн өөрчлөлт	(500,000)	–
12-р сарын 31-нээр	2,800,000	3,300,000
ИЗББ		
1 сарын 1-нээр	5,826,990	1,331,801
Нэмэгдсэн	9,302,000	6,368,700
Зарагдсан	(7,918,090)	(2,108,301)
Хуримтлагдсан хүү	714,053	234,790
12-р сарын 31-нээр	7,924,953	5,826,990
Энгийн ХБҮЦ		
1 сарын 1-нээр	340,354	–
Нэмэгдсэн	2,557,000	336,500
Хуримтлагдсан хүү	43,190	3,854
12-р сарын 31-нээр	2,940,544	340,354

Бодит үнэ цэнээрээ тусгагдаагүй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн тайланд бодит үнэ цэнээрээ бүртгэгдээгүй байгаа санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийнг тодорхойлоход ашиглах аргачлал, таамаглалыг доор харуулав:

Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо хөрөнгө

Хөрвөх чадвар сайтай эсвэл эргэн төлөгдөх хугацаа богинотой (нэг жилээс богино хугацаатай) аливаа санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд дансны үнийг бодит үнэ цэнтэйгээ ойролцоо байна гэж үздэг. Удирдлагын гүйцэтгэсэн бодит үнэ цэнийн үнэлгээг харахад, нэг жилээс дээш хугацаатай банк, санхүүгийн байгууллагаас татсан бодит үнэ цэнийнг санхүүгийн тайланд түүний дансны үнэ цэнээр ойролцоолон тавьсан байна. Энэ нь адил төстэй хадгаламжийн бүтээгдэхүүнд ногдож байгаа өнөөгийн зах зээлийн хүү нь зах зээлд анх гаргасан хүүгээс огцом өөрчлөгдөхгүй гэсэн зарчим баримталснаас үүдэлтэй.

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгсэл

Хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдсэн тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийнг Монгол улс дахь ижил төстэй санхүүгийн хэрэгслүүдийн одоогийн зах зээлийн хүү болон тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн үеийн зах зээлийн хүүтэй харьцуулан тооцно.

Бодит үнэ цэнэ болон дансны үнийн хооронд ихээхэн зөрүүтэй үед 2 дугаар түвшинд ангилагдсан Банкны санхүүгийн хэрэгслийг дансны болон бодит үнэ цэнээр нь харьцуулан дараах хүснэгтээр харууллаа.

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

31. Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэгсэл (үргэлжлэл)

	Дансны үнэ мян.төг	Бодит үнэ цэнэ мян.төг
2022 оны 12-р сарын 31		
<i>Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө</i>		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	203,290,900	200,471,658
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр	39,484,731	39,237,930
2021 оны 12-р сарын 31		
<i>Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө</i>		
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	140,130,208	137,636,896
Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэглүүр	8,866,398	8,743,932

32. Холбоотой талуудын тодруулга

Банкны гол удирдах албан тушаалтнуудтай хийсэн ажил гүйлгээ

Тайлант жилийн турш Банкны захирлууд болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгосон нийт олговрын дүнг дараах хүснэгтээс харна уу. Үүнд:

	2022 мян.төг	2021 мян.төг
<i>Богино хугацааны тэтгэмж:</i>		
Цалин ба бусад тэтгэмж	1,310,266	897,458
Нийгмийн даатгалын шимтгэл	155,703	113,788
Урамшуулал болон бусад тэтгэмжүүд	42,500	64,657
	1,508,469	1,075,903

Гол удирдах албан тушаалтнууд гэдэг нь Банкны болон түүний ажилчдын үйл ажиллагааг шууд болон шууд бусаар удирдан зохион байгуулах эрх үүрэгтэй хувь хүмүүсийг хэлнэ. Банк нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, Гүйцэтгэх албан тушаалтнууд болон тэдний ойрын төрөл төрөгсдийг холбоотой талууд гэж үздэг.

Банкны холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

2022 ба 2021 онуудын 12 сарын 31-ээрх, Банкны холбоотой талуудын гүйлгээний балансын үлдэгдлийг дор харуулав.

	Дансны үлдэгдэл			
	Хадгаламж болон харилцах мян.төг	Зээл мян.төг	Санхүүгийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө мян.төг	Ашиглагдаагүй кредит картын үлдэгдэл ба баталгаа мян.төг
2022 оны 12 сарын 31				
Бодь Капитал ХХК	86	–	–	–
Богд Капитал Инвестмент ХХК	25	–	–	–
Бодь Даатгал ХК	252,282	–	–	248,837
Бодь ХХК	242	228,055	–	–
Бодь Цамхаг ХХК	91,790	1,028,215	–	915,721
Бусад холбоотой аж ахуй нэгж	1,833,681	4,577,643	7,705,744	100,000
Бенефициар өмчлөгч ба түүний ойрын гэр бүл	804,624	1,276,372	–	287,437
Гол удирдах албан тушаалтнууд	3,079,496	2,189,321	–	41,910
Нийт	6,062,226	9,299,606	7,705,744	1,593,905

БОГД БАНК ХК
Санхүүгийн тайлангийн тодруулга – 2022 оны 12 дугаар сарын 31

32. Холбоотой талын тодруулга (үргэлжлэл)

Банкны гол удирдах албан тушаалтнуудтай хийсэн ажил гүйлгээ (үргэлжлэл)

	Дансны үлдэгдэл			
	Хадгаламж болон харилцах	Зээл	Санхүүгийн хөрөнгө оруулалт болон бусад хөрөнгө	Ашиглагдаагүй кредит картын үлдэгдэл ба баталгаа
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2021 оны 12 сарын 31				
Бодь Капитал ХХК	1,610	–	–	–
Богд Капитал Инвестмент ХХК	950	–	–	–
Бодь Даатгал ХК	7,654	–	36,063	–
Бодь ХХК	11,553	566,464	–	48,624
Бодь Цамхаг ХХК	99,041	–	34,986	–
Бусад холбоотой аж ахуй нэгж	1,504,046	448,622	1,410,034	–
Бенефициар өмчлөгч ба түүний ойрын гэр бүл	385,904	2,413,320	–	30,326
Гол удирдах албан тушаалтнууд	2,369,293	1,988,227	–	11,746
Нийт	4,380,053	5,416,633	1,481,083	90,696

	Ажил гүйлгээ			
	Хадгаламжийн хүүний зардал	Зээл ба урьдчилгаа зээлийн хүүний орлого	Үйлчилгээ авсан	Хүлээн авсан ногдол ашиг олон орлого
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
2022 оны 12 сарын 31				
Бодь Даатгал ХХК	–	–	82,893	67,298
Бодь ХХК	–	49,030	50,000	–
Бодь Цамхаг ХХК	475	247,211	615,518	–
Бусад холбоотой аж ахуй нэгж	104,579	746,835	607,783	–
Бенефициар өмчлөгч ба түүний ойрын гэр бүл	11,256	247,424	–	–
Гол удирдах албан тушаалтнууд	168,704	251,744	–	–
Нийт	285,014	1,542,244	1,356,194	67,298

2021 оны 12 сарын 31				
Богд Капитал Инвестмент ХХК	–	–	2,500	–
Бодь Даатгал ХХК	–	4	103,004	97,900
Бодь ХХК	–	57,192	605,000	–
Бодь Цамхаг ХХК	–	10,380	675,784	43,000
Бусад холбоотой аж ахуй нэгж	178,513	51,422	102,112	–
Бенефициар өмчлөгч ба түүний ойрын гэр бүл	4	254,182	–	–
Гол удирдах албан тушаалтнууд	100,421	137,721	–	–
Нийт	278,938	510,901	1,488,400	140,900

32. Холбоотой талын тодруулга (үргэлжлэл)

Холбоотой талуудтай хийсэн гүйлгээний нөхцөлүүд

Дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд болон ажил гүйлгээнүүд бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд үүссэн. Холбоотой талууд руу болон тэдгээрээр бодогдсон хүү нь энгийн арилжааны хувиар тооцогддог. Холбоотой талуудтай хийгдсэн санхүүгийн хөрөнгө оруулалт, зээл болон урьдчилгаанаас бусад үлдэгдэл дүнгүүд нь баталгаагүй юм.

33. Хөрөнгө болон өр төлбөрийн хугацааны шинжилгээ

Дараах хүснэгтэд Банкны хөрөнгө, өр төлбөрийг эргэн төлөгдөх, барагдах хугацаагаар шинжилгээг 2022 оны 12 сарын 31-нээр харуулсан байна. Тодруулга 30 “Төлбөрийн чадварын эрсдэл ба эх үүсвэрийн удирдлага”-аас Банкны зүгээс барагдуулах хоргодуулж тооцоогүй гэрээт үүргүүдийг харна уу.

	12 сараас доош мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
2022 оны 12 сарын 31			
Хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах Банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	127,975,910	–	127,975,910
Санхүүгийн хөрөнгө оруулалт	51,241,913	–	51,241,913
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	54,017,402	15,608,061	69,625,463
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	–	433,677	433,677
Бусад хөрөнгө	37,503,177	171,102,016	208,605,193
Борлуулах зориулалттай хөрөнгө	11,143,051	–	11,143,051
Үндсэн хөрөнгө	1,468,263	–	1,468,263
Ашиглах эрхтэй хөрөнгө	–	4,197,543	4,197,543
Биет бус хөрөнгө	–	2,760,642	2,760,642
Биет бус хөрөнгө	–	931,856	931,856
Нийт хөрөнгө	283,349,716	195,033,795	478,383,511
Өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	43,347,904	–	43,347,904
Репо хэлцэл	31,545,538	33,925,654	65,471,192
Харилцагчдын харилцах, хадгаламж	211,541,933	5,700,501	217,242,434
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	62,118	–	62,118
Зээлээр авсан эх үүсвэр	17,320,514	9,817,110	27,137,624
Бусад өр төлбөр	2,324,759	2,008,340	4,333,099
Түрээсийн өр төлбөр	1,463,489	1,492,288	2,955,777
Орлогын албан татварын өр төлбөр	1,213,285	–	1,213,285
Нийт өр төлбөр	308,528,150	53,235,283	361,763,433
Цэвэр дүн*	(25,178,434)	141,798,512	116,620,078
2021 оны 12 сарын 31			
Хөрөнгө			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах Банк ба санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	106,311,464	–	106,311,464
Санхүүгийн хөрөнгө оруулалт	26,421,661	–	26,421,661
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	6,509,221	30,160,565	36,669,786
Бусад хөрөнгө	19,305,301	128,605,616	147,910,917
Борлуулах зориулалттай хөрөнгө	4,919,677	–	4,919,677
Үндсэн хөрөнгө	1,034,300	–	1,034,300
Ашиглах эрхтэй хөрөнгө	–	2,893,119	2,893,119
Биет бус хөрөнгө	–	2,845,683	2,845,683
Биет бус хөрөнгө	–	855,851	855,851
Нийт хөрөнгө	164,501,624	165,360,834	329,862,458

33. Хөрөнгө болон өр төлбөрийн хугацааны шинжилгээ (үргэлжлэл)

	12 сараас Доош мян.төг	12 сараас дээш мян.төг	Нийт мян.төг
Өр төлбөр			
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	24,793,633	–	24,793,633
Репо хэлцэл	18,645,559	31,066,837	49,712,396
Харилцагчдын харилцах, хадгаламж	97,556,270	39,558,003	137,114,273
Зээлээр авсан эх үүсвэр	8,212,568	–	8,212,568
Бусад өр төлбөр	2,767,195	1,560,931	4,328,126
Түрээсийн өглөг	1,244,592	1,750,268	2,994,860
Орлогын албан татварын өр төлбөр	909,940	–	909,940
Нийт өр төлбөр	154,129,757	73,936,039	228,065,796
Цэвэр дүн*	10,371,867	91,424,795	101,796,662

* Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн тодорхой ангиллыг гэрээний үүрэгт үндэслэв. Банк нь олон харилцагч нэн даруй эргэн төлбөрөө шаардахгүй гэж үзэж байгаа хэдий ч дээрх хүснэгт нь банкны хадгаламжийн хугацааны түүхэн дээр үндэслээгүй болно.

34. Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

Банкны Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоож хянадаг. 2022, 2021 онуудад Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

Өөрийн хөрөнгийн удирдлага

Банкны өөрийн хөрөнгийн удирдлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шаардлагуудыг биелүүлэх ба үүс ч болзошгүй гэнэтийн цочролыг дааж чадах өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан өөрийн хөрөнгийн бүтцэдээ залруулга хийдэг байна.

Өөрийн хөрөнгийн шаардлага

Монголбанкнаас арилжааны Банкнуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг хамгийн багадаа 9% (2021: 9%), өөрийн хөрөнгийн эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 12% (2021: 12%)- с доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн уг шинж чанараар нь тохируулсан хөрөнгө болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг доор үзүүлэв:

	2022	2021
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	36.19%	44.55%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	36.19%	44.55%

Өөрийн хөрөнгийн харьцааг дор үзүүлэв:

	2022 мян.төг	2021 мян.төг
I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө		
Хувьцаат капитал	98,556,822	80,306,822
Хуримтлагдсан ашиг	19,642,410	20,560,843
Нийт I-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	118,199,232	100,867,665
II-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	–	–
Нийт өөрийн хөрөнгө	118,199,232	100,867,665

Монголбанкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагын дагуу бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өмчийн болон өрийн хэрэгслийн бусад нөөц, журмын нөөцийг I, II зэрэглэлийн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсэг болгон оруулаагүй болно.

34. Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт (үргэлжлэл)

12 дугаар сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн хөрөнгийг эрсдэлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

%	2022		2021	
	Хөрөнгө мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг	Хөрөнгө мян.төг	Эрсдэлээр жигнэсэн мян.төг
0	155,218,652	–	116,191,009	–
20	24,433,340	4,885,937	14,001,804	2,800,361
50	25,685,682	12,842,841	27,376,390	18,836,564
70	–	–	–	–
80	–	–	–	–
90	–	–	–	–
100	287,435,639	288,151,394	166,840,705	191,672,502
150	9,347,133	9,791,838	5,314,293	4,501,615
200	2,905,650	5,811,300	397,250	794,500
<i>Тохируулгууд:</i>				
Бүлгийн, тархалтын эрсдэлийн сан	–	–	–	(85,000)
Үйл ажиллагааны эрсдэлийн харьцаа	–	2,248,750	–	6,272,591
Гадаад валютын эрсдэлийн харьцаа	–	2,877,058	–	1,622,019
	<u>505,026,096</u>	<u>326,609,118</u>	<u>330,121,451</u>	<u>226,415,152</u>

35. Тайлагналын дараах үйл явдал

Богд банк 2023 оны 2 сарын 8-нд нэгж хувьцаагаа 20 хувааж, нэг бүр нь 1,600 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 62,500,000 энгийн хувьцааг нэг бүр нь 80 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,250,000,000 ширхэг энгийн хувьцаа болгосон. Энэхүү хувьцааны нэгжийн хуваагдал нь хувь нийлүүлсэн хөрөнгийн нийт дүн болох 100 сая төгрөгт нөлөөлөөгүй. Банкны хувьцаа хуваагдал, бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор МХБ-ийн үнэт цаасны арилжааг түр зогсоосон ба 2023 оны 3 сарын 2-нд Санхүүгийн зохицуулах хорооны Улсын байцаагчийн 8 тоот албан шаардлагын дагуу үнэт цаасны арилжааг сэргээсэн. Энэхүү санхүүгийн тайланд толилуулсан нэгж хувьцаанд ногдох ашиг нь нэгжийн хуваагдалтай холбоотойгоор тохируулагдсан (Тодруулга 12).

2023 оны 2 сарын 8-нд Богд банк нь 1,250,000,000 ширхэг энгийн хувьцаанд нийт 2,774,099 мянган төгрөг буюу нэгж хувьцаанд 2.2193 төгрөгийн ногдол ашиг зарласан. Ногдол ашиг нь эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, шийдвэр ирснээс 60 хоногийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хуваарилагдана.

Богд Банк нь 2022 оны 12 сарын 21-нд АНУ-ын Олон улсын хөгжлийг санхүүжүүлэх корпорацитай 15 сая ам.доллар хүртэлх дүнтэй санхүүжилтийн гэрээ байгуулсан. Тайлагналын дараа буюу 2023 оны 2 сарын 17-нд Богд банк 10 сая ам.долларын санхүүжилт татсан.

36. Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.